

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 04 дүгээр сарын 24-ны өдөр, Лхагва гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-19</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>20-68</i>

1.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	21-35
2.Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	35-47
3.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	47-56
4.Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ нарын 4 гишүүн 2020.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	хойшлуулав
5.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	56-57
6. Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл /Боловсролын салбар дахь хүний эрхийн өнхцөл байдлын талаар хэлэлцэж, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/	57-68

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
04 дүгээр сарын 24-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Б.Баярсайхан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Г.Дамдинням;
Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Н.Учрал.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хэлэлцэх асуудлыг хойшлуулах горимын санал гаргав.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12

58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийг хэлэлцэхийг хойшлуулав./10:46/

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Баттогтох, мөн газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Мөнхбат, Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал Д.Одгэрэл нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Г.Мөнхцэцэг, Ч.Ундрам, Ж.Чинбүрэн, Т.Аубакир, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан үг хэлэв.

Б.Баярсайхан: Шинжлэх ухаан, технологийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 75,0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 11 цаг 34 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны Ажлын албаны дарга Э.Тэмүүжин, мөн албаны хуульч Б.Өлзийбаяр, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, С.Дунжидмаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Б.Бат-Эрдэнэ танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Ч.Ундрам, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Олимп, нийтийн биеийн тамир, спортын

үндэсний хорооны Ажлын албаны дарга Э.Тэмүүжин, Биеийн тамир, спортын улсын хорооны дарга О.Баттулга нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан үг хэлэв.

Б.Баярсайхан: Биеийн тамир, спортын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баярсайхан: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баярсайхан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 6
Бүгд: 12
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакирын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Баярсайхан: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 5
Бүгд: 12
58.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 18 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.04.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Соёлын сайд Ч.Номин, Соёлын дэд сайд П.Баттөр, Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Г.Батхуяг, мөн яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга С.Батцэцэг, Ая зохиогч, продюсер Д.Өлзий-Орших, “Эконтэ” ХХК-ийн захирал Э.Тамир, “М мюзик” ХХК-ийн захирал Д.Батмагнай, “Өмгөөллийн Төгс энд Ко” ХХК-ийн захирал Г.Төгсбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх А.Болортуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор зүйл бүрээр хэлэлцэж, санал хураалт явуулав.

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярсайхан: 1.Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам, А.Адъяасүрэн, П.Анужин, Т.Аубакир, Э.Батшугар, Г.Дамдинням, Б.Жаргалмаа, Г.Мөнхцэцэг /Цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “эрхлэх хувь” гэснийг “эрхэлж байгаа” гэж, 4.1.8 дахь заалтын “байршлын хувьд” гэсний дараа “болон” гэж нэмж, 4.1.9 дэх заалтын “зэргийг кластержуулах замаар дэмжсэн” гэснийг “зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан” гэж, “төвлөрлийн түвшин бусад бүс нутгаас өндөр байгаа” гэснийг “төвлөрсөн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярсайхан: 2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлт,” гэснийг “6.1.3.” дахь заалт руу шилжүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг гишүүдийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарч байгаа тул гар өргөж санал хураалт явуулах талаар горимын санал гаргав.

Б.Баярсайхан: Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, санал хураалтыг гар өргөж явуулахаар тогтов.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “түгээх үйл явцыг” гэснийг “түгээхтэй холбоотой үйл ажиллагааг” гэж, 7.4 дэх хэсгийг 7.5 дахь хэсэг болгон өөрчилж, 7.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.2-т заасан” гэснийг болон “7.5” дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “агуулгыг дэмжих” гэснийг “агуулгын дэмжлэг” гэж, 8.3 дахь хэсгийн “эзэмшүүлнэ” гэснийг “олгоно” гэж, 8.4 дэх хэсгийн “15-18 хүртэлх” гэснийг “16-18” гэж, 8.5 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлж,” гэснийг “заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих болон” гэж, “хязгаарлалт тавих, шаардлага тавихтай холбоотой журам” гэснийг “хязгаарлалт тогтоохтой холбоотой журам,” гэж өөрчилж, 8.3 дахь хэсгийн “энэ хуулийн 8.4-т заасан” гэснийг болон “8.2” дахь хэсгийг тус тус хасаж, 8.5 дахь хэсгийн “8.3” гэсний өмнө “8.1,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 9.8 дахь хэсгийн “Мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “мэргэшүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, 9.6.2 дахь заалтын “Боловсролын тухай хуульд” гэснийг “боловсролын хууль тогтоомжид” гэж, 9.6.3 дахь заалтын “шатны” гэснийг “түвшний” гэж, 9.6.4 дэх заалтын “чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа” гэснийг “чиглэлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа” гэж, 9.8 дахь хэсгийн “9.6-д” гэснийг “9.6.1, 9.6.4-т” гэж, “9.7-т” гэснийг “9.7.1, 9.7.2-т” гэж өөрчилж, 9.6.1 дэх заалтын “хөнгөлөлттэй” гэснийг болон “холбогдох журмыг батлах” гэснийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн “10.3” дахь хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэргүүн ээлжид” гэснийг, 11.1.3 дахь заалтын “үндэсний болон олон улсын” гэснийг хасаж, 11.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 11.3 дахь хэсгийн “11.2” гэснийг “10.1” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, цаашид тухай бүр нийцүүлэн өөрчилж, 12.4 дэх хэсгийн “дэмжлэг” гэсний өмнө “дэд бүтэц, систем нэвтрүүлэхэд” гэж, 12.6 дахь хэсгийн “удирдлагын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “систем хөгжүүлэлтийг” гэснийг “системийг” гэж, “хийх” гэснийг “хөгжүүлэх” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай “12.7” дахь хэсэг нэмэх:

“12.7.Энэ хуулийн 12.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан дагнан байгуулсан объектын төрлийн зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн олонхийг нэгтгэсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.6” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, мөн хэсгийн “төрөөс” гэснийг, 12.4 дэх хэсгийн “тодорхой” гэснийг болон 12.10 дахь хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “дэмжлэг” гэсний өмнө “болон бусад” гэж нэмж, 13.1.1 дэх заалтын “төсвийн дэмжлэг үзүүлэх” гэснийг “төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх” гэж, 13.1.4 дэх заалтын “гаргах” гэснийг “санхүүжүүлэх” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1” гэсний дараа “, 14.5” гэж, 14.5 дахь хэсгийн “олон” гэсний дараа “улсын” гэж нэмж, 14.5 дахь хэсгийн “Холбогдох журмыг Засгийн газар батална.” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “хамтын удирдлагын байгууллага,” гэсний дараа “эсхүл” гэж, 15.10 дахь хэсгийн “Соёлын” гэсний өмнө “холбогдох төрийн байгууллага” гэж нэмж, 15.2 дахь хэсгийн “төр, нийтийн” гэснийг “төрийн” гэж, “холбогдох бүртгэлийг” гэснийг “бүртгэл” гэж, 15.6 дахь хэсгийн “таатай үнээр” гэснийг “хөнгөлөлттэй үнэ” гэж, 15.10 дахь хэсгийн “авах” гэснийг “өгөх” гэж өөрчилж, 15.8 дахь хэсгийн “, хөтөлбөрийг” гэснийг болон “15.9” дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4

Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16.1 дэх хэсгийн “боловсруулан,” гэснийг, 16.4 дэх хэсгийн “Төрөөс” гэснийг хасаж, 16.3 дахь хэсгийн “Төр өөрийн мэдэлд байгаа” гэснийг “Төрийн эзэмшлийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “кластерын” гэсний ард “төлөвлөлт, эсхүл” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “олгохдоо” гэснийг “хүссэн этгээд нь” гэж, 17.8 дахь хэсгийн “төвлөрлийн түвшинг” гэснийг “төвлөрлийг” гэж өөрчилж, 17.8 дахь хэсгийн “менежмент хийх мэргэжлийн багийн зардлыг” гэснийг болон 17.9 дэх хэсгийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолбор байгуулах саналыг техник, эдийн засгийн үндэслэлийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярсайхан: 15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг “, эсхүл” гэж, “мэдээлэлд үндэслэн бүртгэх,” гэснийг “болон шаардлагатай бусад мэдээлэл, журамд үндэслэн бүртгэх,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “үндсэн” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай “20.2.7” дахь заалт нэмэх:

“20.2.7.оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалтын “чадавхыг” гэснийг “мэдлэгийг” гэж өөрчилж, 21.1.9 дэх заалтын “улс орны хөгжлийн онцлогт нийцүүлэн” гэснийг, 21.1.10 дахь заалтын “менежмент хийх” гэснийг болон “21.1.11” дэх заалтыг хасаж, “21.1.2” дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.2.энэ хуульд заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтын “холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах” гэснийг “холбогдох хуулийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 24.1.3. дахь заалтын “соёлын” гэсний өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын “эдийн” гэсний дараа “засгийн” гэж нэмж, “хөтөлбөр, төсөв” гэснийг “төлөвлөгөө” гэж, 25.1.3 дахь заалтын “ашиглуулах” гэснийг “эзэмшүүлэх” гэж өөрчилж, “талаарх” гэснийг болон 25.1.4 дэх заалтын “нутаг дэвсгэрт” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын “эдийн” гэсний дараа “засгийн” гэж нэмж, “талаарх” гэснийг болон “, төсөв” гэснийг хасаж, 26.1.2 дахь заалтын “нутаг дэвсгэрийн” гэснийг “орон нутгийн” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын “үйлдвэрлэлийн” гэснийг “үйлдвэрлэлийг дэмжих” гэж өөрчилж, 27.1.3. дахь заалтын “соёлын” гэсний өмнө “энэ хуулийн 4.1-д заасан” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн гарчгийн “үйл ажиллагаан дахь тайлагнал” гэснийг, “үйл ажиллагааны” гэж, 28.4 дэх хэсгийн “авсан” гэснийг “олгосон” гэж өөрчилж, 28.3 дахь хэсгийн “мэдээллийн” гэсний өмнө “бүртгэл,” гэж нэмж, “энэ хууль болон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын санал:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “арга хэмжээ, журмыг” гэснийг “арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг” гэж, 9.6.1 дэх заалтын “чиглэлийн” гэснийг “чиглэлээр” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын “хөрөнгө оруулалтад” гэснийг “хөрөнгө оруулалт” гэж, 12.2 дахь хэсгийн “бүртгэгдсэн бүтээл” гэснийг “бүтээлийг” гэж, 12.8 дахь хэсгийн “этгээд” гэснийг “этгээдэд” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “эдлүүлнэ” гэснийг “үзүүлнэ” гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн “хориглоогүй буюу” гэснийг “хориглоогүй,” гэж, 15.4 дэх хэсгийн “загварыг” гэснийг “загвараар” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “хүн ам” гэснийг “иргэдэд” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “, зэрэг арга хэмжээнд” гэснийг “бусад үйл ажиллагаанд” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “гадна” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтын “системтэйгээр” гэснийг хасаж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Засгийн” гэсний дараа “газрын” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “системийг ашиглах” гэснийг “системийн” гэж өөрчилж, “системийн хөгжүүлэлт хийх” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар” гэснийг “3, 18 дугаар” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “, заалт” гэж нэмж, доор дурдсан агуулгатай “18.6” дахь хэсэг нэмэх:

“18.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн “12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “чиглэл” гэсний өмнө “тодорхой” гэж,” гэснийг хасаж, “33 дугаар зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “шилдэг бүтээл” гэснийг “шилдэг уран бүтээлч болон шилдэг бүтээл” гэж” нэмж, мөн зүйлийн “50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн “дурсгал” гэснийг “түүх соёлын дурсгалт зүйлээр” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлд “9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “уран сайхны” гэснийг” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлд “26 дугаар зүйлийн 26.3,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай” гэсний өмнө “тус тус” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “15.1.15” гэснийг “15.1.16” гэж өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.16.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “22.5.11, 22.5.12” гэснийг “22.5.20” гэж өөрчилж, “хөнгөлнө” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Барилгын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “нүүр” гэсний дараа “болон” гэж нэмж, “талд үндэсний агуулга, хэлбэр, дүр төрхийг илэрхийлсэн үзэл баримтлал,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “16.1.17” гэснийг “16.1.19” гэж, 2 дугаар зүйлийн “заалтын” гэснийг “хэсгийн” гэж, “16.1.16” гэснийг “16.1.18” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “38.1.21” гэснийг “38.1.23” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Соёл, урлагийг дэмжих сан” гэснийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж өөрчилж, 13.3.5 дахь заалтын “арга хэмжээнд оролцуулах,” гэснийг, 13.3.7 дахь заалтын “онцгой” гэснийг, “13.4” дэх хэсгийг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9.14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмэх:

“3.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоох, шаардлага тавихтай холбоотой журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 9.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дугаар зүйлийн” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.46 дахь заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “үүсвэрээс” гэсний дараа “болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувиас” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “байгууллагатай” гэсний өмнө “төв” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “, өөрчлөлт” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, **2 дугаар зүйл.**Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсгийн “34.27” гэсний дараа “, 37.28” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Б.Баярсайхан: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгон өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтын “аргачлалыг” гэсний дараа “соёлын болон” гэж нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Б.Баярсайхан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуульд Зар сурталчилгааны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд тусгагдаагүй талаар мэдэгдэв.

Мөн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэгт ажилласан уран бүтээлчдэд талархал илэрхийлж, үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Баярсайхан: “Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 04 дүгээр сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 4
Бүгд: 11
63.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэл /Санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Хүний эрхийн боловсрол хариуцсан референт О.Тодбулаг, Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан референт Н.Золжаргал, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Элбэгзаяа нар байлцав.

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийв.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүд Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 23 дахь илтгэлийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар сонслоо.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэхээр тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 3 цаг 06 минут үргэлжилж, 16 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 75.0 хувийн ирцтэйгээр 13 цаг 47 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
10 цаг 41 минут

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Баярсайхан: Эрхэм хүндэт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэнд хүргэе.

Өнөөдрийн хуралдаан ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн өнөөдөр хуралдаа хүрэлцэн ирсэн байна. Завхан аймаг 9 дүгээр тойрог Балжиннямын Баярсайхан, СХД 28 дугаар тойрог Пүрэв-Очирын Анужин гишүүн, Баян-Өлгий аймаг 2 дугаар тойрог Телеуханы Аубакир гишүүн, БГД 26 дугаар тойрог Хассуурийн Ганхуяг гишүүн, СХД 27 дугаар тойрог Бадарчийн Жаргалмаа гишүүн, СБД 24 дүгээр тойрог Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Сэлэнгэ аймаг 13 дугаар тойрог Чинбатын Ундрэм гишүүн, БЗД 23 дугаар тойрог Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн, Өвөрхангай аймаг 10 дугаар тойрог Содномын Чинзориг гишүүн, Хөвсгөл аймаг 17 дугаар тойрог Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн нар хүрэлцэн ирсэн учраас өнөөдрийн хуралдаан нээснийг мэдэгдэж байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

1 дүгээрт, Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэ шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал,

2. Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл

болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудал,

3 дугаарт, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна,

4 дүгээрт, Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна,

5-д, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаар 23 дахь илтгэл. Боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар хэлэлцэж, санал, дүгнэлтээ Хууль зүйн байнгын хороонд хүргүүлнэ.

Мөн хаврын чуулганы 4 дүгээр сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай тогтоолын төслийг батална.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Аубакир гишүүн.

Т.Аубакир: Баярлалаа. Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Энэ хэлэлцэх асуудал дээр байгаа Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулж өгөөч гэж. Манай ажлын хэсэг дахиж хуралдах шаардлагатай байна. Бид нар өчигдөр өглөө 10 цагаас хуралдсан. Дахиж хуралдах шаардлагатай байгаа учраас энэ хэлэлцэх асуудлаас хойшлуулж өгнө үү гэж хүсэлт гаргаж байна.

Б.Баярсайхан: Өнөөдрийн хуралдаанд Дундговь, Говьсүмбэр аймаг 6 дугаар тойргоос сонгогдсон Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн, СХД 28 дугаар тойрог Энхбаярын Батшугар гишүүн нар хуралдааны ирцэд орж ирсэн байна.

Ингээд Аубакир гишүүний гаргасан горимын саналаар санал

хураалт явуулъя. Хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийг.

Аубакир гишүүний гаргасан горимын санал 58,3 хувиар дэмжигдсэн тул энэ асуудлыг хойшлууллаа.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан танилцуулна.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооны гишүүдийнхээ энэ өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн 2-т ЗГ нь шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж, Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр Монгол Улсын урт дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох Алсын хараа 2050, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр төлөвлөгөөний зорилтод олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа, хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэр, тогтолцоо бүхий төр, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчныг бүр бүрдүүлэхээр заажээ.

Монгол Улсын Их Хурлаас анх 1998 онд Шинжлэх ухаан, технологийн хуулийг 2006 онд энэ хуулийн шинэчилсэн найруулгыг батлан мөрдүүлж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны эрх зүйн харилцааг зохицуулж ирсэн хэдий ч өнөөдрийн эрчимтэй хувьсан өөрчлөгдөж байгаа шинжлэх ухаан, технологийн

хөгжил, бодлого, чиглэл, түүний үйл ажиллагааны удирдлага, менежмент, хатуу болон зөөлөн дэд бүтэц, хүний нөөцийг удирдахад энэхүү хуулийн хүрээн дэх эрх зүйн зохицуулалт хэм хэмжээний заалт бүрэн хамарч чадахгүйд хүрсэн байна.

Энэ хугацаанд хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон тооны бодлого, эрх зүйн баримт бичгийг УИХ, ЗГ-аас батлан хэрэгжүүлсэн боловч хөрөнгө, санхүү, хүний нөөцийн хомсдол, салбарын удирдлага, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо оновчгүй байгаа нь шинжлэх ухаан технологийг зөвхөн нэг салбарын асуудал байдлаар зохицуулж ирсэн нь тус салбарын үр дүнг нийгэм эдийн засгийн эргэлтэд оруулах боломжийг хязгаарласан хөгжлийн урт дунд хугацааны баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, зорилтот үр дүндээ хүрэхгүй гол шалтгаан болсон байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалт Монгол Улсын Их Хурлаас баталсан урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг баримт бичигт тусгасан. Дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан, технологи, инновацын хөгжлийг эрчимжүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг анхдагч хуулийг хүчингүй болгох тухай хуулийн төсөл болон дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хамт боловсруулж яамдаас санал зөвшөөрлийг авсны үндсэн дээр өнөөдөр Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд баримтлах зарчим, уг үйл ажиллагааны бодлого, төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалт, хувийн хэвшлийн оролцоо, төрийн дэмжлэг, хүний нөөцийн хөгжил, санхүүжилт,

хөрөнгө оруулалтын эрх зүйн үндсийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахаар тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан шинжлэх ухаан, технологийн бодлого, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт шинжлэх ухаан, технологи, инновацыг хөгжүүлэх чиглэлээр тусгагдсан зорилтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдэхийн зэрэгцээ, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагаанд оролцогчдын эрх үүргийн хуваарилалтыг оновчтой тогтоож, удирдлага, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны хувьд олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх замаар шинжлэх ухаан технологийг хөгжүүлэх тогтолцоог системтэйгээр бүрдүүлж, нийгэм, эдийн засаг, хүний амьдралын чанарын үзүүлэлт дээшилж, дэвшил гарна гэж үзэж байна.

Үүний зэрэгцээ шинжлэх ухаан, технологи, инновацын чиглэлээр төр, шинжлэх ухаан хувийн хэвшлийн түншлэл нэмэгдэж салбар дундын болон салбар дамнасан хамтын ажиллагаа өргөжиж, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны санхүүжилтийн тогтолцоо оновчтой олон эх үүсвэртэй болж ил тод байдал хангагдаж санхүүжилт болон үр дүнг уялдуулан хяналтыг сайжруулах боломж бүрдэнэ.

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн боловсруулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Инновацын тухай хууль, Засгийн газрын сангийн тухай хууль, холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг тус тус боловсруулсан.

Хуулийн төслийн шинэчилсэн найруулгыг дэмжиж өгөхийг та бүгдээс хүсэж байна.

Б.Баярсайхан: Байнгын хорооны хуралдаанд ирсэн ажлын хэсгийг танилцуулъя.

Батжаргал БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Баттогтох БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Намчинсүрэн БШУЯ-ны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Одгэрэл ШУТС-ийн захирал, Хатанболд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн улс төр, эрх зүйн салбарын эрхлэгч. Ийм ажлын хэсгийн гишүүд ирсэн байна.

Хуулийн төсөл санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Цуг явчих уу? Энх-Амгалан гишүүнээр тасалъя. Мөнхцэцэг гишүүн. Ц.Мөнхцэцэг гишүүн, Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр аливаа улс орны хөгжлийн бодлогын амин сүнс бол шинжлэх ухаан, технологийн бодлого байх ёстой. Тэгээд шинжлэх ухаан технологийн бодлого дээр Монгол Улсын хувьд бол хүн ам цөөтэй, хүн амынхаа нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглах, эрдэмтдийнхээ ур чадвар, эрдэмтдийн гаргаж байгаа нийт бүтээлүүдийг салбар бүрийн хөгжилд маш үр дүнтэй ажиллах шаардлага байгаа. Зүгээр харамсалтай нь өнгөрсөн жилүүдэд шинжлэх ухаанд зарцуулах зардал, төсөв, төрийн дэмжлэг бол хомс байсан. Ялангуяа энэ шинжлэх ухаан технологийн асуудлаар бас салбарын эрдэмтэд, их, дээд сургуулиудын санал зөвлөмжүүд, академик байгууллагуудын саналуудыг бас төрийн бодлогод тусгах үйл явц бол асар дутагдалтай байсан юм.

Миний хувьд бол яах аргагүй Монгол Улсын Боловсролын сургуулийн эрдэмтэн байсан хүний хувьд бол энэ шинжлэх ухааны асуудлаар бас нэлээн санаа зовж явдаг ийм гишүүн байгаа. Тухайлбал бид нар энэ өнгөрсөн 2020 оны Улсын Их Хурлын сонгуульд МАН шинжлэх ухаан болон боловсролын чиглэлээр томоохон реформ хийх амлалтуудыг өгсөн. Өнгөрсөн хугацаанд манай Улсын Их Хурлаас Боловсролын багц хуулиа шинэчилсэн байгаа. Одоо бид нар хийх хамгийн том боловсролын салбарын гол ажил бол шинжлэх ухааны том реформ байгаа.

Тийм учраас энэ шинжлэх ухаан технологийн хуулийг оруулж ирж байгааг дэмжиж байна. Тэгээд сайдаас болон ажлын хэсгээс нэг асуулт байна. Энэ шинжлэх ухаан технологийн хуульдаа, хуулийн төсөлд шинжлэх ухаан технологийн санхүүжилт, тэгээд энэ шинжлэх ухаан технологийн салбар дахь төрийн оролцоо, дэмжлэгийг юу гэж шинээр оруулж байгаа вэ?

Мөн эрдэмтдийн маань гаргаж тавьж байгаа, судалгаа шинжилгээний ололт, нээлтүүд эсвэл тухайн салбарын гол бүтээлүүдийг олон улсын тавцанд гаргах, бүс нутгийн болон олон улсын хамтын ажиллагааг дэмжих чиглэлээр шинжлэх ухааны ямар шинэ зорилт чиглэлүүдийг тавьж байгаа вэ гэдгийг асууя.

Ер нь бол шинжлэх ухаангүйгээр Монгол Улс явахгүй. Хүн ам цөөтэй улсын хувьд бид нар аль болох оюуныхаа, эрдэмтдийнхээ, ирээдүйн шинжлэх ухааны мэргэжилтнүүдийгээ дэмжсэн, тэд нарт дэмжлэг болохуйц ийм шинэ орчин, технологийн шинэ дэвшилийг нэвтрүүлэх шаардлагатай.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдад микрофон өгье, хариулъя.

Л.Энх-Амгалан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Бид нар ер

нь энэ Үндсэн хууль дээрээ их тодорхой заалт хийчхээд тэгээд Үндсэн хуулиа ерөөсөө энэ үе үеийн ЗГ хэрэгжүүлж чадаагүй учраас л энэ шинжлэх ухаан технологийн санхүүжилтийн асуудлууд, тогтолцооны асуудлууд, шинжлэх ухаан технологиос энэ салбараас хүртэх энэ өгөөжийн асуудлуудаа бид нар ер нь энэ хүртэж чадаагүй нэг ийм эрх зүйн сул тогтолцоотой байж ирсний л гор нь өнөөдөр ингэж гарч байгаа юм болов уу л гэж бодож байгаа.

Монгол Улсын өрсөлдөх чадвараараа бид нар сүүл мушгиж байна. Экспортод гаргаж байгаа бүтээгдэхүүнүүд дээр бид нар ямар нэгэн инновац мэдлэг шингээгүй байна. Тэгэхээр яах вэ, би энэ гишүүдэд нэг зүйлийг уншаад өгчихье гэж байгаа юм. Энэ Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2-т нь уг нь их тодорхой заасан юм байна лээ. Юу гэхээр ЗГ нь шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогоо эхлээд батална. Шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлогоо батална. Тэгээд шинжлэх ухаан технологийн нэгдсэн бодлого батлагдаж байж, дараа нь улсын эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл батлагдана.

Дараа нь улсын төсөв батлагдана гэсэн ийм л Үндсэн хуулиар Засгийн газарт нэг ийм эрх, үүрэг олгосон. Харамсалтай нь үе үеийн ЗГ үүнийгээ биелүүлж чадаагүй учраас бид нар яг нөгөө шинжлэх ухаан технологийнхоо нэгдсэн бодлогыг тодорхойлж чадаагүй учраас энэтэйгээ уялдсан үндсэн чиглэл нь уялдаагүй, улсын төсвүүд нь уялдаагүй, учраас ингээд санхүүжилтийн ийм тогтворгүй тогтолцоотой явж ирсэн юм байна гэдэг 1 дүгээр нэг ийм үндэслэл байгаа юм.

2 дугаар үндэслэл бол ерөнхийдөө өнөөдөр хүртэл манай шинжлэх ухаан технологи санхүүжүүлж ирсэн ганцхан эх үүсвэр гэж хэлж болно. Энэ Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилт байгаа. Тэгэхээр өнгөрсөн нэг 10 гаруй

жилийн хугацаанд энэ Шинжлэх ухаан технологийн санхүүжилтээр бид нар 100 орчим тэрбум төгрөг зарцуулаад, 4500 орчим судалгааг энэ мөнгөөр санхүүжүүлсэн болов чиг харамсалтай нь мэдээж тодорхой үр дүн гарсан. Гэхдээ яг энэ гарсан инновац, патент, оюуны бүтээлүүд нийгэм, эдийн засгийн салбарт тодорхой ийм юу шинэ инновац болж, шинэ мэдлэг болж, ингэж шингэж чадаагүй нэг ийм сул тогтолцоотой явж ирсэн юм байна.

Яг санхүүгийн тогтолцооны талаас нь харахад бид нар илүү нөгөө суурь судалгааг хэрэглээний судалгаануудыг зөвхөн I, хоёрхон жилээр санхүүжүүлдэг. I судалгаанд зарцуулж байгаа санхүүжилт нэг 20 сая төгрөг хүрэхгүй төгрөгийн санхүүжилт өгдөг. Үүнээс бид нар хүртэж байгаа өгөөж их багатай явсан. Тэгэхээр энэ шинэ хуулиар бид нар энэ шинжлэх ухаан технологийн санхүүжилтийн бүтэн цикл болох суурь судалгаа, хэрэглээний судалгаа, тэгээд хөгжүүлэлт, туршилт, зүгшрүүлэлт, тэгээд тодорхой энэ арилжааны буюу эдийн засгийн эргэлтэд оруулдаг ийм бүтэн циклийн тогтолцоонуудыг хийж өгөх ийм санхүүгийн шинэчлэлийг бид нар энэ хуулийнхаа үзэл баримтлалд бас оруулж өгсөн байгаа.

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүн тодруулах уу? Хариулт хангалттай юу тийм ээ. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Г.Мөнхцэцэг: Шинжлэх ухаан технологийн тухай хууль бол яалт ч үгүй бас цаг үеэ олоод бараг магадгүй хоцроод ч бас орж ирж байгаа ийм хууль. Тэгэхдээ орж ирж байгаа нь сайн байна. Ялангуяа би бас Энх-Амгалан сайдыг энэ салбарынхаа хуулиудыг ингээд шат дараатай аваад орж ирээд явж байгаад нь бас талархаж байгаа. Тэгээд энэ 1998 онд анх батлагдаж байсан энэ хууль тэгээд эндээс хойш 8 удаа өөрчлөлт орсон.

Ингээд бодохоор бол бас нэг 20 гаруй жил явчихсан яалт ч үгүй өөрчлөгдөхөөс өөр арга байхгүй. Зарим нэгэн шинэчлэлүүдийг бас энд тусгаж хийхгүй бол үнэхээр энэ шинжлэх ухааны технологи гэдэг зүйл бол бас Монгол Улсын хэмжээнд үнэхээр бас орхигдоод, магадгүй эд нарт бас менежмент, зохицуулалтын асуудлууд бол бас хийх шаардлагатай, нэн шаардлагатай байгаа учраас энэ хууль орж ирж байгаа нь бас их дэмжиж байгаа юм. Тэгээд энэ нэг 2, 3 зүйлийн л асуулт байна.

Энэ ШУА, Үндэсний шинжлэх ухаан технологийн сан, эрдэм шинжилгээний байгууллага гээд. Ингээд энэ байгууллагууд маань ингээд тус тусдаа өөрсдөө эрх, үүрэгтэй ингээд оролцоод явахаар байж байна л даа. Тэгээд ирэхээр энэ би технологийн сан дээрээс нэг зүйлийг асууя гэж ингэж бодсон юм.

Тэгэхээр энэ хяналт тавих, үр дүнг нь тооцох зорилгоор үндэсний шинжлэх ухаан технологийн санг байгуулан ажиллана гэж байгаа юм. Тийм, тэгээд сантай маргаан бол бидэнд их зөндөө бол бий болдог. Тэгэхээр энэ сангаа ер нь яаж бүрдүүлэх юм? Ямар, ямар төлөөллүүдийг бас энд хамруулах юм? Мэдээж энэ сан өөрөө эдийн засгийн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтуудыг зохицуулдаг, төсөв төлөвлөгөөг бас боловсруулдаг ингээд ийм зүйлүүдийг бас хийх ёстой байх. Мэдээж бас манай эрдэмтдийн бол ур ухаан, оюун, авьяас билиг бол ерөөсөө багадаагүй. Гагцхүү бас энэ эдийн засгийн хөшүүргүүд маш их шаардлагатай байдаг юм гэдгийг бол бүгдээрээ бас мэддэг юм. Тэгэхээр энэ сантай холбоотой зүйл дээр ийм асуулт байна.

Мөн энэ шинжлэх ухаан технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ажлын албаны даргыг томилж, чөлөөлнө гэж байгаа байхгүй юу. Заавал ингэж хатуу заах бас ёстой юу үгүй юу. Ер нь өөрөө хамтын

удирдлагын байгууллага байгаад ингээд явахаар ямар хэлбэрээр бас энэ зохицуулалтуудыг төлөөлөх, томилох, ингээд удирдлагын тал руу нь яаж хандах юм бэ гэж. Эрдэм шинжилгээний байгууллага байна гээд эрдэм шинжилгээний байгууллага нь төрийн, хувийн хамтарсан өмчийн хэлбэрээр байгуулж болно гэж байгаа юм. Үүнийг бол би бас төр, хувийн хэвшлийн хамтын бас байгууллагууд ажиллаад явбал бас үр дүн гарах болов уу гэж ингэж бас харж байгаа учраас энэ бол их сайн заалт болов уу гэж ингэж бодож байна.

Тэгээд энэ 3 байгууллагын эрх, үүрэг тус тусдаа ямар байдлаар шинэчлэгдэж орж ирж байгаа вэ гэдэг зүйлийн асуултыг Энх-Амгалан сайдад тавьж байна.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Өнөөдөр Монгол Улсад шинэчлэх ухааны хүрээлэнгүүдээ их, дээд сургуулиудаа оруулаад нэг 67 орчим шинэчлэх ухааны байгууллагууд бас байгаа юм. Яах вэ, академи өөрөө бас бие даасан академийн эрх зүйн байдлын тухай хуультай. Тэгэхдээ академи бол энэ цаг хугацаандаа энэ нийгмийн хөгжлийн эрэлт хэрэгцээнд тохирсон бас бүтцийн болон тогтолцооны шинэчлэл хийх зайлшгүй шаардлага үүссэн. Гэхдээ нэг талаасаа нийгэмд одоо хүртэл байдаг нэг ийм буруу ташаа ойлголтууд байдаг. Академи өөрөө хуучирсан тогтолцоо. Академи ерөнхийдөө ажиллаж чадахгүй байна. Академийн эрдэмтэд их хөгширсөн байна. Ингээд энэ академи буюу академийн хүрээлэнгүүдээс хийгдэж байгаа энэ судалгаануудын үр дүнгүүд их бага байна гэсэн нэг ийм буруу ташаа мэдээллүүдийг бид нар бас нэг залруулах ёстой гэж 1 дүгээрт ойлгож байгаа.

2 дугаар асуудал энэ юуны шинэчлэх ухаан технологийн сан. Шинэчлэх ухааны технологийн сан

өнөөдөр хүртэл ерөөсөө ганицхан эх үүсвэрээр улсын төсвөөр л санхүүжигдэж ирдэг. Жилд нэг 10-12 тэрбум төгрөгийн л санхүүжилт гаргаж ирээд тэгээд тодорхой салбарын шаардлагатай байгаа энэ цөм болон технологийн судалгаануудыг өнөөдөр хүртэл байгаа мөнгөндөө тааруулж л хийж байгаа нэг ийм тогтолцоотой ирсэн. Одоогийн энэ шинэ өргөн барьж байгаа байгаа хуулиар бид нар сангийн эх үүсвэрүүдийг бол олон эх үүсвэртэй болгох ийм чиглэлээр бас энэ тогтолцооны санхүүжилтийн тогтолцооны бас шинэчлэлийг хийж оруулж ирж байгаа. Ийм юм байгаа юм.

Тэгээд мэдээж яг санг дагасан бас хардалт сэрдэлгүүд бий. Нөгөө нэг бараг үндсэндээ ийм шинэчлэх ухааны ЖДҮ маягтай болчихсон юм биш үү энэ тэр гэсэн бас ийм хардлага сэрдэлгүүд байдаг. Гэлээ гэхдээ ямар ч байсан яг энэ юуны өнгөрсөн хугацааны би бас түр түрүүн хэлсэн, өнгөрсөн хугацаанд манай сангаас санхүүжүүлж, үр дүнд хүрсэн маш сайн ажлууд бас байна. Жишээ нь би бас 1 хоёрхон жишээ дурдъя гэж бодож байна. Энд бас Чинбүрэн гишүүн яг энэ төслийг бас удирдаж, энэ ирэх юуны анагаахын салбарт бас томоохон энэ шинэчлэл хийсэн нэг шинэчлэл бол энэ элэг шилжүүлэн суулгах ийм судалгаа байсан. Энэ судалгааг энэ шинэчлэх ухаан технологийн сангаас санхүүжүүлж хийж, өнөөдөр Монгол Улс дотроо Монголчууд өөрсдөө элэг шилжүүлдэг болсноор жилд бид нар 8-16 тэрбум төгрөгийн гадагшаа гардаг энэ үргүй зардлуудыг багасгасан ийм тодорхой үр дүнгүүд гарсан байна. Олон мянган ард иргэдийн карманаас хэдэн 100 сая төгрөгийн хэмнэлт гаргасан ийм сайн судалгаа гэж хэлж болно.

2 дугаарт нь, энэ ганд тэсвэртэй Дарханы 144 дүгээр сортыг бас энэ сангаас санхүүжүүлж, өнөөдөр энэ энэ сорт бий болсноор ганд тэсвэртэй энэ сорт бий болсноор газар тариалангийн салбарынхан жилд дунджаар 10 тэрбум

буюу сүүлийн 6 жил бол 60 тэрбум төгрөгийн цэвэр ашиг буюу газар тариалангийн салбар өрсөлдөх чадвартай болсон гэх мэтчилнээр бодитой судалгаанаас бас гарсан үр дүнгүүд бас байгаа.

Тэгэхдээ судалгаа бүрээс бид нар яг ийм эдийн засгийн үр дүн нэхэх бас их хэцүү. Яагаад гэвэл нийгэм, эдийн засгийн бас холбогдолтой ийм судалгаанууд байдаг. Энэ судалгаануудын үр дүнгийн хэмжээс нь өнөөдөр, гадаадын мэргэжлийн, нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлэгдсэн юм ямар бүтээлүүд хэвлэгдсэн юм тэр нь хэдэн хувиар илтгэгдэж байсан юм бэ гэдэг нэг энэ үзүүлэлт байдаг.

Сүүлийн 20 жил бол манай Монголын эрдэмтдийн гадаадад хэвлүүлж байгаа бүтээлийн тоо 10 дахин нэмэгдсэн. Манай Монголын эрдэмтдийн хэвлүүлсэн энэ бүтээлээс олон улсад дэлхийд эшлэгдэж байгаа энэ эшлэлийнхээ тоогоор бид нар даруй 20 мянгад хүрсэн нь Азийн шинжлэх ухааны байгууллагуудын 40 гаруй байгууллагууд дотор 20-оор эрэмбэлэгдэж байгаа бас ийм үр дүнгүүд гарч байгаа юм. Гарсан юм. Энэ Шинжлэх ухаан технологийн сан бас тодорхой цаг үе бүрдээ бас өөрийнхөө үүргийг гүйцэтгэсэн ийм сан байгаа юм гэдгийг бас би онцолж хэлье.

Б.Баярсайхан: Чинбатын Ундрам гишүүн асуултаа асууя.

Ч.Ундрам: Энэ Шинжлэх ухаан технологийн тухай хууль шинэчилсэн найруулга нь орж ирж байгаад бол баяртай байна. Зарчмын хувьд дэмжиж байна. Тэгээд ер нь бол энэ хуулиар бид нар суурь шинжлэх ухаанд Монгол Улс суурь шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хэрхэн хувь нэмрээ оруулах юм. Мөн одоо нэгэнт нээлт хийгдсэн энэ байгаа шинжлэх ухааныг хэрхэн хэрэглээнд нэвтрүүлж, улс орныхоо асуудлыг, ард түмнийхээ асуудлыг шийдэх юм бэ. Эдийн засагт хэрхэн хувь нэмэр оруулах

юм. Улсынхаа аюулгүй байдлыг хэрхэн хангах юм гэдэг асуудлыг бол энэ хуулиар шийднэ гэж бодож байна.

Тэгээд асуултын хувьд энэ шинжлэх ухааны технологийн салбарын хүний нөөцийн асуудал гээд энд нэг дэд бүлэг байна л даа. Тэгээд энэ хүний нөөцийг бэлдэхэд бид нар ЕБС-аас л эхэлж бэлдэхээс өөр аргагүй. Тэнд л хүүхдүүдийг шинжлэх ухаанд дуртай болгож, ялангуяа байгалийн шинжлэх ухаан, математик, хими, физик, биологид дуртай болгож, ойлгодог болгож байж тэндээс манай ирээдүйн энэ салбарын эрдэмтэд бэлтгэгдэнэ. Тэгэхээр ийм энэ Боловсролын хуультайгаа хэрхэн уялдуулсан бэ? Ялангуяа ЕБС-ийн хууль, эрх зүйн орчинтой хэрхэн уялдуулсан бэ.

2 дугаарт, шинжлэх ухааны байгууллага, их сургууль 2 бол салшгүй холбоотой. Тэгэхээр яг энэ суурь шинжлэх ухааныг авч явж байгаа ирээдүйн эрдэмтдийг бэлдэж байгаа их сургууль болон ШУА, бусад хүрээлэнгүүдийн хоорондын холбоосыг энэ хуулиар хэрхэн зохицуулах юм бэ гэдэг асуулт байна. Бид нарын сая Боловсролын багц хууль дээр хийсэн нэг чухал заалт бол судалгааны их сургуулийг тусдаа хуулиар байгуулж болно гэдэг заалт байгаа. Тэгэхээр цаашид яг энэ хуультай уялдуулаад бид нар энэ суурь шинжлэх ухаанаа, хэрэглээний шинжлэх ухаанаа авч явдаг судалгааны их сургуультай болох ийм алсын хараатай ажиллах ёстой гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ тал дээр салбарын яам ямар бодолтой байна вэ?

3 дугаарт, шинжлэх ухааны ажилтнуудын цалин. Эрдэмтэн болохын тулд 20 жил зарцуулна шүү дээ. 1 дүгээр ангид орохоосоо авхуулаад л тэгээд л төгсөөд дор хаяж 10 жил их, дээд сургууль, ахисан түвшиний сургалтаар явж байж, эрдэмтэн дөнгөж бэлтгэгдэж гарна. Тэгээд ийм олон жил бэлтгэгдсэн хүмүүс маань маш бага

цалинтай байх юм бол энэ шинжлэх ухааны салбарт ажилладаггүй. Тэгээд өөр мөнгөтэй газар луу яваад өгдөг эсвэл гадаад орон руу яваад өгдөг. Тэгэхээр энэ цалин хөлсний бодлогыг яаж бид нар цаашид сайжруулах ёстой юм бэ?

4 дүгээрт, энэ шинжлэх ухааны байгууллагууд та сая хэлж байна. Салбар дундын шинжлэх ухааны мэргэжлээр хөгжүүлэх ёстой, хамтрах ёстой эрдэмтэд маань. Лабораториудаа дундаа хэрэглэх хэрэгтэй. Үүний хажуугаар бас өрсөлдөөн байх ёстой. Тэгэхгүй бол бас нөгөө эрдэмтэн чинь монопол үүсгэчихдэг. Би л ганцхан энэ салбарыг мэддэг, би энэ салбарын бүх судалгаа, мөнгө төгрөгийг нь авах ёстой гээд монопол үүсгээд явчихдаг. Тэгэхээр энэ зөв хамтрал болон энэ зөв эрүүл өрсөлдөөний орчныг бид нар бас цаашид бүрдүүлэх ёстой.

Эцэст нь санхүүжилтийн асуудал. Энд бас хувийн байгууллагууд, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтрах тухай орсон байна л даа. Хэрвээ компаниуд шинэ бүтээгдэхүүн, шинэ инновац бий болгоход зарцуулж байгаа мөнгийг нь тодорхой татвараас чөлөөлдөг ч юм уу ийм ийм хэмжээний дэмжлэг үзүүлчих юм бол компаниуд энэ эрдэм шинжилгээний хүрээлэн их, дээд сургуулиудтай илүү хамтрах сонирхол нь бий болох юм шиг надад санагдаад байгаа юм. Ер нь компани судлаачдыг ойртуулж байж л энэ судлаачдын нээлтүүд нь бизнест илүү хэрэглээнд нэвтрэх боломж нь бүрдэнэ гэж бодож байна. Ийм 5 асуулт.

Б.Баярсайхан: Ундрам гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ундрам гишүүнтэй санал нэг байна. Шинжлэх ухааны салбарын хүний нөөц бол ЕБС-аасаа бэлтгэгдэх ёстой гэдэгтэй санал нэг байна. Ундрам гишүүн ч гэсэн өөрийнхөө сонгогдсон Сэлэнгэ аймгийнхаа сургуулиудад шинжлэх

ухааны технологийн системийн байгалийн ухааны лабораториудыг иж бүрэн нийлүүлсэн анхны гишүүн. Би бас үүнийг Боловсролын сайдын хувьд бас би онцолж хэлэх ёстой. Ингээж байж энэ боловсролын салбарын шинэчлэлийн хүрээнд хийгдэж байгаа энэ хөтөлбөрийн шинэчлэлийн хамгийн гол шинэчлэлийн нэг бол ерөөсөө энэ байгалийн шинжлэх ухааны хичээлийнхээ хөтөлбөр, агуулгуудыг бид нар шинжилж, энэ олон улсын түвшинд аваачих ёстой.

Тэгээд өнгөрсөн жил бид нарын анх удаа PISA-гийн үнэлгээнд Монгол Улс хамрагдаж очсон. Тэгээд математик, унших чадвар, байгалийн ухааны хичээлийг 3 хичээлээр бид нар үнэлэгдсэн. Яг үнэхээр энэ байгалийн ухааны хичээл бол Азийн болон Европын Холбооны улсуудаас бид нар даруй 3-3,5 жилийн хоцрогдолтой байна гэдэг ийм дүгнэлт гарсан.

Тийм учраас бид нар ерөөсөө хүүхдийг багаас нь, бага ангиас бид нар кодингийн хичээл орж эхлэх гэж байна, 1 дүгээр ангиас кодингийн хичээл орж ирэх гэж байна. Тэгээд байгалийн ухааны хичээлүүдийг бид нар багаас нь оруулж ирж, хүүхдийг шинжлэх ухаанд дуртай болгох, хүүхдүүдийн авьяасыг багаас нь нээх энэ бодлого явна. Тэр тусмаа хөтөлбөр дээр энэ систем сургалт гэж ярьдаг. Энэ байгалийн ухааны хичээлүүдийн сургалтууд тэгээд төрөлжсөн ахлах сургуулиудыг бид нар байгуулж эхлэх гэж байна, шинэ хуулиар.

Тийм учраас төрөлжсөн ахлах сургууль тэр тусмаа энэ их, дээд сургуулиудын харьяа төрөлжсөн ахлах сургуулиуд, гимназ хэлбэрээр байгуулагдаж байгуулагдаж энэ төрөлжсөн ахлах сургуулиудаас жинхэнэ ирээдүйн энэ эрдэмтэн, судлаачид төрж гарах, Монгол авьяасыг нээх ингээд энэ хөтөлбөрүүд багаас ерөнхий боловсролын дунд сургуулиудаасаа эхэлж явна гэдэг нэг ийм тогтолцооны асуудал байгаа.

Бас ингээд цаашидаа бид нар энэ авьяасыг нээх нөгөө Талант Онерс гэж нэг том том хөтөлбөрүүд өндөр хөгжсөн улсуудад байдаг тэгээд Онерс гэсэн энэ ижил төрлийн хөтөлбөрүүдийг онц авьяастай гоц авьяастай хүүхдүүдийг багаас нь илрүүлэх, хөгжүүлэх энэ чиглэл рүү бас дэмжсэн ийм хуулийн эрх зүйн зохицуулалтуудыг бас энэ хуулиар оруулж ирж байгаагаараа нэг их онцлогтой юм байгаа юм.

2 дугаар асуудал бол таны хөндөж тавьсан их сургуулиуд шинжлэх ухааны байгууллагуудын хамтын ажиллагааны асуудал байгаа юм. Энэ ерөнхийдөө бол яг шинжлэх ухааны хүрээлэнгүүд их сургуулиуд чинь тус тусдаа хашаан дотроо л судалгаа хийгээд байдаг. Хоорондоо хамтарсан энэ судалгааныхаа үр дүн, үр өгөөжийг яг хэлэлцдэггүй, тэгээд улс орныхоо хөгжил дэвшилд хувь нэмэр оруулдаггүй. Бид нарт нэг ийм сул тогтолцоо байсан, өнөөдрийг хүртэл. Сүүлийн 3 жил харьцангуй энэ их сургууль, шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн хамтын ажиллагаа нэлээн шинэ шатад гарсан байгаа.

Бид нар анх удаа Монгол Улс лабораторийн тооллого хийж, Монгол Улс 350 лабораторитой юм байна лээ, тийм. Тэгэхдээ харамсалтай нь ингээд энэ дор дороо лабораториудаа дараад тавьчихдаг 1 ийм хуучин сэтгэлгээ нь байсан, сэтгэлгээ байсан. Энэ сэтгэлгээний өөрчлөлтүүд дээр томоохон өөрчлөлтүүд орж их, дээд сургуулиуд, эрдэм үйлчилгээний байгууллагууд хоорондоо дундын нээлттэй лабораториуд болж ажиллах, ингээд шинжлэх ухаан технологийн сангаас цаашидаа бид нар энэ Монгол Улсын цөм технологитой холбоотой энэ судалгаануудыг яг их, дээд сургуулиудын багш нар, шинжлэх ухаан, технологийн шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн эрдэмтэд хамтарч хийсэн тохиолдолд бид нар энэ санхүүжилтийг олгодог. Бас

ийм тогтолцоон дээр бид нар ийм хөшүүрэг эдийн засгийн ийм хөшүүргүүдийг хийж байгаа.

Тийм учраас шинжлэх ухааны хүрээлэнгүүд их, дээд сургуулиудын хамтын ажиллагаа бас нэлээн шинэ шатад гарсан гэдгийг бас би хэлнэ. Энэ хуулиар ч гэсэн бид нар бас энэ тогтолцоог дэмжсэн ийм эрх зүйн шинэчлэлүүдийг хийж өгч байгаа.

Судалгааны их сургуулийг бол УИХ хуулиар байгуулна гэсэн ийм тогтолцоотой. Цаашидаа бид нар МУИС-ийг ер нь анхны Үндэсний судалгааны их сургууль болохоор одоо болгох энэ нөхцөл байдал, бэлтгэл ажлууд бас хийгдэж байгаа.

Эрдэмтдийн маань цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмжийн асуудал бол үнэхээр бага байсан, бага байсан. Сүүлийн харин 2 жилд манай эрдэмтэд, судлаачдын цалин, үндсэн цалин нь 60-40 хувь нэмэгдсэн. Тэгээд хамгийн гол нь бид нар энэ цалингийн доод хэмжээг ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдад хугацаа нэмж өгье.

Л.Энх-Амгалан: Цалингийн доод хэмжээг бид нар тавьж өгсөн. Дээшээ бол ийм хязгааргүй байж болно. Тийм ээ, хамгийн үр бүтээл гаргаж байгаа эрдэмтэд үр дүнд суурилсан санхүүжилтийн хэлбэрээр 3 сая, 4 сая, 5 сая төгрөгийн цалинтай болох энэ боломжууд нээгдэж байгаа. Үүний анхны сайн жишгүүд химийн хүрээлэнгээс авхуулаад өөрсдөө эрдэмтдийнхээ цалинг, эрдэмтдийнхээ урамшууллауудыг 2 дахин нэмсэн ийм сайн жишгүүд бас байна.

Ингээд цаашидаа манай эрдэмтэн судлаачдын маань бүтээлүүд үнэлэгдэх ийм цалин хөлсний тогтолцоонд орох болов уу гэсэн бас ийм хүлээлт байна. Тэгээд мэдээж салбар дундын

зохицуулалт хийх шаардлагатай. Гэхдээ мэдээж эрүүл өрсөлдөөн бол байна. Үүнийг бол өрсөлдөөнийг бол бид нар дэмжинэ. Түүнээс биш бүх судлаач нар бүгдээрээ хамтраад ингээд өрсөлдөөнгүйгээр судалгаа хийнэ гэдэг ийм зүйл бол байж болохгүй. Аливаа зүйл дээр тэр тусмаа шинжлэх ухаанд эрүүл шударга өрсөлдөөн байх ёстой гэж бодож байна.

Эцэст нь энэ шинжлэх ухаанд хөрөнгө оруулсан, инновацад хөрөнгө оруулсан энэ ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Шинжлэх ухаан технологийн тухай шинэчилсэн найруулгын хуулийн төслийг дэмжиж байгаа. Бид бас энэ шинжлэх ухааны хөгжлийг тодорхойлж байгаа зүйл бол энэ хуулиараа бид үнэхээр дэмжлэг үзүүлж, Монгол Улсынхаа хөгжлийг түүчээлэх, эрдэмтдийнхээ үйл хэргийг дэмжих энэ тогтолцоог хуульчилж өгөхгүй бол бас болохгүй хуучирчхаад байгаа юм. Энэ дээр бол санал нэг байна.

Сая би бас энэ Эмийн түр хорооны ажлыг ахлаад хийж байхад Монгол Улсын эмийн салбарын төлөвшил, хөгжил ямар хэмжээнд байна вэ гээд олон улстай харьцуулахад бид бараг нялх шатад байгаа. Нялх үедээ байгаагийн гол шалтгаан нь ерөөсөө л эмнэл зүйн судалгаа хийж чаддаггүй гэдэг л үзүүлэлт. Хамгийн том оноо доошоо татаж байсан үзүүлэлт байсан. Энэ юуг харуулж байна вэ гэхээр бид энэ шинжлэх ухааныхаа судалгааныхаа ажлуудаа илүү яг эмийн чиглэлд хийж чадаагүй байгаагийн л бас нэг илрэл. Тэгэхээр энэ бол ганцхан салбар дээр л ярьж байгаа зүйл. Бусад салбаруудаа ярих юм бол бас ийм л байдал харагдах байх.

Сая Энх-Амгалан сайдын хэлж байгаатай яг сан санал нэг байна. Өнөөдөр бид эмийн чанар шалгаж байгаа

олон лабораториуд байгаа нэгдсэн удирдлага байхгүй. Тэгээд бүх лабораториуд нь дандаа л би нэг ийм багажтай болно, би нэг ийм тоног төхөөрөмжтэй болно гэдэг том хүсэлтүүд тавьдаг. Баахан мөнгө тавиад л, баахан үнэтэй тоног төхөөрөмж авчихдаг. Түүнийгээ ашиглах тогтолцоо нь байхгүй, урвалжууд нь байхгүй ингээд л гацаад зогсчихдог. Тийм учраас энэ хувааж хэрэглэдэг, хамтарч ажилладаг энэ тогтолцоог хийх нь бас энэ шинэчилсэн найруулгын бас нэг томоохон санал байх ёстой гэж дотроо бодож байгаа.

Тэгээд надад бас их анхаарал татаж болж байгаа зүйл бол энэ Шинжлэх ухаан технологийн инновацын үндэсний хороо Ерөнхий сайдын доор 20 хүний бүрэлдэхүүнтэй байна гэдэг энэ зүйл бол маш чухал. Энэ бол салбар хоорондыг нь уяж байгаа мөн төсвийг оновчтой зарцуулахад бол чухал үүрэг гүйцэтгэх энэ заалт хэсэг бүлэг орж байгаа. Энд бол их талархалтай байна.

Тэгээд нэмээд хэлэхэд мэдээж хөтөлбөрөө батлаад ажиллахаар бид бас энэ төслөө цааш нь хуулийн төслийг хэлэлцэх асуудлаа шийдээд явах юм бол харин ярилцах ёстой зүйл бол бид бас нэг орхигдуулж болохгүй зүйл ЭША-ны ёс зүйн асуудлыг бид ерөөсөө хаяж болохгүй. Бид эрх, үүрэг гэдэг зүйл оруулчихсан байгаа. Бүлэг. Тэгвэл бас эндээ бас ёс зүйн асуудлыг нэлээн сайн шигтгэж оруулахгүй бол бид олон улсын эрдэм шинжилгээний талбарт ёс зүйгүй байдлаасаа болж, улс орныхоо нэр хүндийг хүртэл гутааж байсан тохиолдлуудыг мэднэ. Худлаа дүгнэлт гаргаж, худлаа дүгнэлтээрээ мөнгө, санхүүжилт авах гэж оролддог энэ заль мэхийг ч хүртэл багагүй ийм тохиолдлууд байдгийг мэднэ.

Тийм учраас энэ дээр бид ёс зүйн талаар зайлишгүй дурдаж ярьж оруулж байх ёстой. Тэгж чадваас бид энэ Монголын шинжлэх ухаан хөгжиж,

төсөв санхүүтэй, өрсөлдөөнтэй, нэгдмэл, хамтарч ажиллаж чаддаг, салбар хоорондын уялдааг хийж чаддаг ийм тогтолцоо болчих байх гэж харж байгаа юм. Баярлалаа.

Б.Баярсайхан: Чинбүрэн гишүүн санал хэллээ. Аубакир гишүүн асуулт асууя.

Т.Аубакир: Баярлалаа. 2022 онд бас энэ шинжлэх ухаантай холбоотой энэ хүрээлэнгүүдийн асуудлуудыг салбар салбар луу нь шилжүүлэх тухай асуудал бас яригдаж байсан. Жишээлбэл, ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн бол жишээлбэл ХААЯ дээрээ байх ёстой юм. Эрүүл мэндтэй холбоотой нь ЭМЯ дээр байх ёстой юм гээд. Одоогийн байдлаар зохицуулалт Боловсролын яаман дээр шинжлэх ухаан гэдэг утгаараа Боловсролын яаман дээр харьяалагдаад явж байгаа. Миний байр суурь тухайн салбар салбарынхаа яаман дээр байх нь илүүтэй үр дүнтэй байх юм гэж би үзэж байсан. Одоо энэ хууль орж ирж байгаагаар бас тодорхой хэмжээнд энэ боловсон хүчний асуудал санхүүжилтийнх нь асуудлуудыг шийдэж өгөхөөр ийм дорвитой хууль орж ирж байна гэж ойлгож байна.

Сая та ХАА-н салбарыг ярьж байх шиг байна. Дархан 144 гэдэг сорт бол 2000-аад оны эхээр Дарханы хүрээлэн дээр л гарсан л ийм шинэ сорт л доо. Яах арга байхгүй ганд тэсвэртэй. Сүүлийн үед үүнээс өмнөх өнөөдөр энэ 24 оноос өмнөх 10 жилд бол Монгол Улсад бол хур тунадасны хэмжээ багасаад ганд тэсвэртэй ийм ургац улаан буудайнуудыг үйлдвэрлэж байсан үе л дээ. Яг үүнтэй холбоотой жишээлбэл миний бодож явдаг зүйл бол энэ ХАА-н хүрээлэн энэ цаг уурын өөрчлөлттэй холбоотой, дээрээс нь Монгол Улсын газрын үржил шим багассантай холбоотой, технологийн шинэчлэлтэй холбоотой зохицсон шинжлэх ухааны үндэслэлтэй яаж ХАА-н салбар энэ тариалангийн салбараа хөгжүүлэх вэ гэдэг тал дээр илүүтэй

ажиллах ёстой. Өнгөрсөн хугацаанд явж байсан энэ хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа явуулж байх үед үргэлж л санхүү, мөнгөний дутагдалтай, хүрээлэнгүүд гэдэг бол яамыг бодох юм бол илүү аж ахуйн чанартай, техник технологийн чанартай ажлуудыг гүйцэтгэдэг л дээ. Эд нар т үргэлж л санхүү, мөнгөний гачигдалтай явж ирсэн. Сүүлийн 2 жилээс эхлээд үндсэндээ Европт бол хур тунадасны хэмжээ багасаад үндсэндээ манай Монгол Улс руу хур тунадасны хэмжээ нэмэгдэж эхэллээ. Энэтэй холбоотой бид нар төмс, хүнсний ногооныхоо сортыг хүртэл өөрчлөх тухай асуудал. Наад зах нь ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн баруун аймаг буюу жишээлбэл Баян-Өлгий аймагт ийм хүнсний ногоо тариална шүү. Төмс, байцай, вегетац гэж нэг юм бий болц гүйцэх хугацаа гэсэн үг. Баян-Өлгий аймагт ийм төмс, хүнсний ногоо тариалахад болох юм гэдэг зөвлөгөөг хүртэл эрдэм шинжилгээний хүрээлэнгээс гаргаж өгч байгаа ёстой. Энэ ажил байхгүй.

Одоо Монголын ХАА-н газар тариалангийн салбар яаж явж байна гэхээр социализмын үед хүмүүжсэн хэдэн агрономын л заавраар явж байгаа шүү дээ. Завхан аймагт бид нар ийм болцтой ийм төмс тарина. Ийм улаан буудай байдаг ч юм уу. Ийм арвай тарих юм гэдэг зөвлөгөөг хүрээлэн биш социализмын үед хүмүүжсэн хэдэн агрономууд л өгөөд явж байгаа. Гэтэл үүнийг энэ цаг уурын өөрчлөлттэй нь холбоотой, технологийн өөрчлөлттэй нь холбоотой хүрээлэнгээс цаг тухайд нь ийм шийдвэрүүдийг гаргаад, зөвлөгөөнүүдийг өгөөд явж байх ёстой. Харамсалтай нь хөрөнгө мөнгөний асуудал шийдэгдээгүй, гачигдалтай байдаг учраас тэр зөвлөгөөгөө яг энэ зөвхөн салбарынхаа хэмжээнд бас улс эх орны нийтлэг эрх ашигт нийцсэн ийм шийдвэрүүдийг энэ хүрээлэнгүүд гаргаад явж байх ёстой. Энэ хуулиар тодорхой хэмжээний санхүүжилтүүдийг нь

шийдэж болох ийм механизмууд оруулж ирж байна гэж би ойлгож байна.

Тийм учраас яг энэ хуулиар энэ хууль батлагдах юм бол энэ салбар салбарын энэ эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн үйл ажиллагаа илт урагшлах уу? Үнэхээр үр дүнгээ өгнө гэж бодож байна уу, сайд аа, тийм ээ, 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт маань яг энэ хэлэлцээж байгаа асуудалтай холбоотой биш. Боловсролын сайд маань сууж байгаатай холбогдуулаад манай орон нутаг дээр болоод байгаа нэг асуудлыг би асуучихъя. Өдөр болгон бид нар бас тааралдаад байхгүй. Энэ манай Баян-Өлгий аймгийн Улаан ус сумын ЕБС-ийн сургуулийн хэдэн багш нарын нэг 3 жилийн тэтгэмж ерөөсөө өгөгдөхгүй байгаа юм байна. Манай боловсролын яамны газар, хэлтсийн дарга нар байна уу, үгүй юү, 27 багш 3 жилийн тэтгэмжээ авч чадахаа байчихсан юм байна, сайд аа ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд Аубакир гишүүний асуултад хариулъя.

Л.Энх-Амгалан: Аубакир гишүүн ээ, бид нар энэ 1 жаахан нэг ийм хуучинсаг гэдэг юм уу нэг ийм жалга довын энэ сэтгэлгээнээсээ бид нар салах цаг болсон. Нэг сайд гарч ирэхээр аягүй бол та ХАА-н сайд болчих юм бол ХАА-н хүрээлэн ХАА-н сургуулиа салбартаа авна гэж ярих юм байна л даа. Энэ их хуучинсаг сэтгэлгээ шүү. Хэзээ ч ийм сэтгэлгээгээр хандаж болохгүй. Одоо шинжлэх ухаан бол харин салбар хоорондын буюу салбар дамнасан энэ тогтолцоо руу дэлхийн улс орнууд орж байна. Салбар дамнасан, түүнээс биш тухайн нэг салбараараа хөгжсөөд тухайн нэг салбараа дагнаж хөгжсдөг ийм тогтолцооноос салж байгаа. Цоо шинэ интер дисциплинэр гэж ярьдаг ийм шинэ хандлага руу, шинэ тогтолцоо руу орж байна.

Тийм учраас бид нар энэ шинэ хандлагадаа орох ёстой. Тийм учраас өнөөдрийн энэ хуулиар бид нар илүү их тийм Ерөнхий сайдаар ахлуулсан Үндэсний зөвлөл гаргаж ирж байна шүү дээ. Тийм ээ, Ерөнхий сайд, Монгол улсын Ерөнхий сайд Шинжлэх ухаан технологийнхоо үндэсний хороог ахалдаг. Бусад улс орнуудад ч гэсэн хөгжсөн дэвжсэн улс орнууд ч гэсэн нэг иймэрхүү тогтолцоотой л явж ирсэн юм байна лээ.

Тэгэхээр энэ тогтолцооны шинэчлэлийн асуудлуудыг бид нар бас оруулж ирж байгаагаараа их онцлогтой юм байгаа юм. Таны хэлж байгаа яагаад өнөөдөр энэ ХАА-н салбарын судалгаа шинжилгээнүүд гэдэг юм уу, ХАА-н хүрээлэнгүүд илүү их тийм шинжлэх ухааны манлайлал үзүүлж ажиллаж чадахгүй байна вэ гэдэг нэг ийм шүүмжлэл байгаа юм. Энэ бол эргээд л нөгөө санхүүжилтийн тогтолцооны асуудал байгаа. Одоо шинжлэх ухааны аливаа нэг ингээд бид нар судалгаа хийхэд ийм 3 үе шатыг дамжиж байна. Тийм ээ, 1 дүгээрт нь судалгаа хөгжүүлэлт. Суурь судалгаа дотроо энэ бол суурь судалгаа, хэрэглээний судалгаа, тэгээд туршилт, зүгшрүүлэлт гэж байгаа. Энэ хүрээнд юу гэдэг юм шинжлэх ухааны байгууллагууд, их, дээд сургуулиуд бол тодорхой судалгаагаа хийгээд байдаг. Шинжлэх ухаан технологийн сангаас зөвхөн энэ хүрээнд нь л эхний үе шатад нь л санхүүжилт хийгээд орхичихдог. Гэтэл яг энэ хийсэн судалгаанууд маань өөрөө технологи дамжуулалтууд, бүтээгдэхүүн турших, шинэ бүтээгдэхүүн гаргах гэдэг инновацын хөгжүүлэлт хийдэг тэр үе шат дээр нь нөгөө энэ санхүүжилт нь байдаггүй. Үүнийг нөгөө үхлийн хөндий гэж ярьдаг юм байна лээ.

Тийм учраас манай энэ хийсэн судалгаа шинжилгээнүүд яг энэ бүтэн, хамгийн сүүлийн юу болох тэр хэрэглээнд нэвтрэх, бизнесийн хөгжүүлэлт гээд гэх мэтчилнээр энэ 3 үе шатыг суурь

судалгааны хөгжүүлэлтүүд, инновацын хөгжүүлэлтүүд, бизнесийн хөгжүүлэлтүүд гэсэн энэ 3 бүтэн циклээр нь бид нар энэ санхүүжилт хийж чаддаггүй учраас л манай нөгөө судалгаанууд үхлийн хөндий рүү уначхаад байдаг нэг ийм л нөхцөл байдлаас болсон.

Тийм учраас бид нарын энэ оруулж ирж байгаа шинэ хуулиар илүү шинжлэх ухааны энэ судалгаануудын санхүүжилтийг бүтэн циклээр нь санхүүжүүлдэг энэ тогтолцоо руу шилжиж байгаа гэж ойлгож болно.

Тэгэхээр яг үндсэндээ би тантай санал нэг байна. ХАА-н чиглэлийн энэ судалгаанууд, тэр тусмаа өнөөдөр энэ цаг уурын эрсдэлтэй байгаа цаг, ган зуд их ойрхон ойрхон болж байгаа нөхцөлд явал бид нар энэ тэсвэртэй, өрсөлдөх чадвартай, бүтээмж өндөртэй ХАА-н салбартай болох вэ л гэдэг бол манай шинжлэх ухааны салбарын нэг номерын зорилт байх ёстой. Энэ зорилтдоо бид нар хүрэх ёстой.

Тийм учраас саяхан бид нар бас ХАА-н чиглэлээр судалгаа хийдэг Мал эмнэлгийн хүрээлэн, ХАА-н хүрээлэнгүүд сая бас томоохон зөвлөгөөн, үндэсний зөвлөгөөнүүдийг хийж, цаашидаа ер нь энэ цаг уурын энэ эрсдэлтэй нөхцөлд Монгол Улсад тохирсон ямар ХАА-н тогтолцоо, ямар МАА-н тогтолцоо, ямар газар тариалангийн тогтолцоо байх вэ гэдэг дээр бас үндэсний хэлэлцүүлэг хийж, өмнө нь хийсэн судалгаануудаа бас хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр бас салбар дундын ийм сайн хэлэлцүүлгүүд хийгдэж байгаа. Бас сайн сайн чиг хандлагууд байгаа гэдгийг бас та бүхэнд энэ таширамд онцлоод бас хэлчихье гэж бодож байна.

Б.Баярсайхан: Аубакир гишүүн тодруулах уу? Аубакир гишүүн тодруулъя.

Т.Аубакир: Баярлалаа. Би харин хуучинсаг биш, харин шинэлэг санаа би

танд хэлээд байна шүү дээ. Яах вэ, 22 онд салбарын яамнууд дээрээ байх ёс байх нь зөв юм гэж би үздэг байсан юм. Энэ хуулийн төсөл орж ирээд харин ч зөв юм болчхов уу даа Энх-Амгалан сайд аа, гээд сууж байна шүү дээ. Хуучинсгаар нь дуудаад байх юм, энэ чинь.

Тэгээд энэ мэдээжийн хэрэг энэ бол аливаа энэ шинжлэх ухааны салбар салбартаа энэ нийтлэг эрх ашгийн төлөө л ажиллах ёстой юм. Энэ хууль орж ирснээрээ үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалт, дэд бүтцийг өргөжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэр, санхүүжилтийн журам, захиалагч, гүйцэтгэгчийн эрх үүргийг зохицуулна гэж байгаа юм. Сайн байна гэж.

Гэхдээ энэ дээр та илүүтэй анхаарах ёстой. Та өөрөө яг ХАА-н хүрээлэн дээрээ очиж үзэх хэрэгтэй. Би 22 онд хэлж байхдаа та өөрөө очиж үзсэн юм уу гэж би асууж байсан, тийм ээ. Тийм учраас энэ эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдээ бид нар дэмжих цаг нь Монгол Улс өнөөдөр дэмжих цаг нь болчихсон шүү гэдгийг би хэлж байгаа юм.

2 дугаар миний асуусан асуулт орон нутаг дээр үүсээд байгаа тэр Улаанхус сумын 27 багшийн 3 жилийн тэтгэмжийн асуудал яагаад үлдчихэв ээ? Хуулийг нь бид нар батлаад өгчихсөн. 3 жилийн тэтгэ ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Аубакир гишүүн ээ, тантай санал нэг байна. Таныг би хуучинсаг гэж ерөөсөө хэлээгүй. Харин ч шинэлэг ийм сэтгэлгээ, шинэлэг ийм санал санаачилга гаргаж байгаад их талархаж байгаа. Би ер нь нүүр бардам хэлэхэд бүх шинжлэх ухааныхаа хүрээлэнгээр явж үзсэн анхны сайд болов уу гэж би бодож байгаа шүү. Тийм ээ, нийт 60 гаруй их, дээд сургуульд эрдэм

шинжилгээнийхээ хүрээлэнгээр ингээд явсан өмнөх сайд нар бол хугацаа богино ч байсан байх. Гэхдээ ийм боломжууд бас гарч байгаагүй юм шиг байна лээ.

Тэгэхээр анх удаа бас энэ бүх хүрээлэнгүүдээрээ явж бүх хүрээлэнгийнхээ юунуудтай танилцаж, ажил судалгаануудтай нь танилцаж, ЗГ-аар бид нар чинь 2 ч удаа энэ хүрээлэнгүүдийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийн талаар тогтоолууд батлуулсан. Сайханбилигийн Засгийн газрын үед бас нэг хар тушаал гарч байсан. Энэ хүрээлэнгүүдийг татан буулгаж их, дээд сургуулиудын харьяанд өгч байсан бас ийм гишүүн сургамж бас байгаа шүү. Тийм учраас бид нар энэ алдаагаа бол давтаж болохгүй гэж бас бодож байна. Тэр ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайд гүйцээгээд хариулъя. 1 минут өгье. Улаан хус сум

Л.Энх-Амгалан: Аубакир гишүүн ээ, энэ Улаан хус сумын тэнд байгаа багш нар маань 3 жилийнхээ нэмэгдлийг авч чадахгүй байгаа ийм нөхцөл тэтгэмжийг авч чадахгүй байгаа нөхцөл байсан. Энэ бол цэвэр орон нутгийн асуудал. Сум, орон нутаг нь 24 он дээр яг тэр Улаанхус сум гэдэг юм уу Баян-Өлгий сум дээр яг тэтгэвэрт гарах багш хэд байгаа юм, 5 жилийн нэмэгдэл авах багш хэд байгаа юм, 3 жилийн нэмэгдэл ба авах багш хэд байгаа юм бэ гэдгийг яг энэ тооцоог нь өгөөд бид нар 24 оны улсын төсвийг баталдаг. Тухайн жилийн улсын төсвийг баталдаг.

Тийм учраас энэ сум, орон нутгийн удирдлагуудын алдаатай нөхцөлөөс болж ингээд багш нарын эрх ашиг хөндөгдөх ийм асуудлууд үүссэн байхыг үгүйсгэхгүй. Гэлээ гэхдээ энэ асуудлуудыг бид нар нэгтгэж ямар ч байсан төсөв дотроо зохицуулалт хийх хэлбэрээр бид нар энэ 17 багш нарын тэр тэтгэмжийн асуудлуудыг бол шийдвэрлэж өгье гэж бодож байна.

Б.Баярсайхан: Та өөрөө асуух юм уу, одоо.

Тэгвэл би нэг 2 асуулт байна. Энэ хууль батлагдсанаараа өнөөдөр бас манай боловсрол, шинжлэх ухааны салбарын төсөв энэ жил бол нэлээн нэмэгдсэн. Энэ хууль батлагдсанаараа манай шинжлэх ухааны салбарын төсөв яаж нэмэгдэх гэж байгаа юм бэ? 1 дэх асуудал.

2 дугаар асуудал энэ манай залуу эрдэмтдийг дэмжих энэ зорилгын хүрээнд энэ хууль батлагдсанаараа яг ямар ахиц дэвшил гарах юм бэ? Сайд сая төрөлжсөн ахлах сургуулийг дурдаж байна. Энэ хөдөө орон нутагт энэ төрөлжсөн ахлах сургууль байгуулагдах юм уу? Зөвхөн нийслэлийн хэмжээнд ярьж байгаа юм уу.

4 дэх асуудал Шинжлэх ухаан технологийн сангаас асууя. Сая Чинбүрэн гишүүн ёс зүйн асуудал хөндөж байна. Сая Боловсролын зээлийн сан дээр гарч байгаа энэ ёс зүйн асуудал нийгмийг бол үнэхээр бухимдуулж байгаа. Хэдэн жилийн өмнө бас Шинжлэх ухаан технологийн сан дээр шинжлэх ухааны маань салбарт бас ёс зүйгүй олон асуудлууд байсан. Энэ асуудлууд цэгцэрсэн үү? Энэ сангийн үйл ажиллагаа өнөөдөр бас ямар түвшинд явагдаж байна. Энэ хууль батлагдсанаараа Шинжлэх ухаан технологийн сан цаашидаа ямар үр дүнтэй, яаж ажиллах юм бэ гэсэн энэ 4 асуултыг би асууж байна. Баярлалаа.

Энх-Амгалан сайдад микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Баярсайхан дарга аа. Үндсэндээ ...

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдад микрофон өгье.

Л.Энх-Амгалан: Өнөөдрийн байдлаар ямар ч байсан энэ 24 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр манай

шинжлэх ухааны санхүүжилт 103 тэрбум төгрөг байна. Үүний 65,7 тэрбум төгрөг нь шинжлэх ухааны байгууллагад ажиллаж байгаа эрдэм шинжилгээний ажилтнуудын цалингийн асуудал. Ингээд эрдэм шинжилгээний зардал эрдэм шинжилгээний зардал дээр 11 тэрбум, ингээд хөрөнгө оруулалт дээр 27 тэрбум гэдэг нь яах вэ ерөнхийдөө бол сүүлийн жилүүдэд энэ манай шинжлэх ухаанд хийж байгаа хөрөнгө оруулалтууд бол нэмэгдэж байгаа.

Энэ шинжлэх ухаан технологийн цогцолборуудыг Монгол улсын Ерөнхийлөгч Хүрэлсүх Ерөнхийлөгч Ерөнхий сайд байхдаа маш том бүтээн байгуулалтын ажлуудыг эхлүүлсэн. Нийт 150 орчим тэрбум төгрөгийн өртөгтэй Монгол Улсад анх удаа энэ шинжлэх ухааны технологиудын шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолбор буюу шинжлэх ухааны паркийн анхны ийм дэд бүтцүүд бас бий болж байгаа. Энэ оны сүүл ирэх оны эхээр энэ цогцолбор ашиглалтад орно. 1-д.

2-т нь, энэ хуулиуд батлагдаж гарснаараа шинжлэх ухаанд бол ганцхан улсын төсвийн эх үүсвэр Шинжлэх ухаан технологийн сангийн хоёрхон эх үүсвэр байсан бол олон талт санхүүжилтийн эх үүсвэрүүд бид нар бий боллоо гэж бас бодож байгаа. Тийм учраас бол шинжлэх ухаанд зарцуулагдах санхүүжилтийн эх үүсвэрүүд олон эх үүсвэрүүд бий болсноор ингээд энд шинжлэх ухаанд зарцуулах зардлууд, санхүүжилтийн эх үүсвэрүүд бол нэмэгдэнэ гэсэн ийм эрх зүйн шинэчлэлүүдийг 1 дүгээрт хийж байгаа.

2 дугаарт нь, энэ төрөлжсөн ахлах сургуулиудыг бол бид нар бас дан ганц их, дээд сургуулиудаа харьяанд Улаанбаатар хотод байгуулагдах биш бүх аймгийн төвүүд дээр энэ төрөлжсөн ахлах сургуулиудыг байгуулахаар бас ийм зохицуулалтуудыг бас хийж оруулж байгаа.

Ёс зүйн асуудал буюу тэр юуны Шинжлэх ухаан технологийн сантай холбоотой асуудлууд ярьж байна. Алдаа дутагдлууд байсан уу гэвэл байсан, юуг нь нуух вэ. Гэлээ гэхдээ ямар ч байсан энэ юуны Шинжлэх ухаан технологийн сангийн дүрмүүд, цаашидаа энэ Шинжлэх ухаан технологийн сангаас олгож байгаа энэ санхүүжилтүүдийн тоглоомын дүрмүүдийг нь бид нар нэлээн ил тод, шударга, тийм ээ, нээлттэй сонголттойгоор буюу өрсөлдөөнт санхүүжилт, суурь санхүүжилт гэсэн ийм тогтолцоонд оруулсан ийм тогтолцооны шинэчлэл болж чадсан гэдгийг би бас хариуцлагатайгаар хэлье гэж бодож байна.

Ёс зүйн асуудлууд байгаа. Плажеризмаас авхуулаад тийм ээ. Зохиогчийн эрхийн асуудлууд, энэ хуулбарлалтын асуудлууд гээд ингээд олон асуудлууд бас байдаг. Үүнийг бид нар ямар ч байсан энэ сүүлийн 2 жилд энэ плажеризмийн асуудлуудыг бол нэлээн өндөр түвшинд тавьж, өнөөдрийн байдлаар энэ Шинжлэх ухаан технологийн санд хадгалагдаж байгаа докторын ажлуудыг бид нар яг плажеризмын сканераар буюу шүүж үзэж, хэнийх нь докторын ажлууд оюуны хулгайд байна вэ гэдгийг бид нар удахгүй бас олон нийтэд мэдээлэх энэ ажлууд бас хийгдэж байгаа. Мэдээж юу гэдэг юм, олон удаа энэ сангаас санхүүжилт авсан, тэр санхүүжилт авсан судалгаанууд нь үр дүнд хүрээгүй гэсэн иймэрхүү зөрчил, дутагдлууд бол арилсан.

Гэхдээ ямар ч байсан тэр Боловсролын зээлийн сан шиг энэ ард иргэдийн дунд байгаа уур бухимдлыг төрүүлэх ийм хэмжээний ноцтой алдаа дутагдлууд бас энэ сан дээр гараагүй гэдгийг бас би хариуцлагатайгаар хэлье.

Б.Баярсайхан: Энх-Амгалан сайдад баярлалаа.

Ер нь бол манай Монгол Улсын хөгжлийг шинжлэх ухааных нь салбар нь түүчээлж явж байж улс хөгжинө. Харамсалтай нь шинжлэх ухааны салбарын маань төсөв, шинжлэх ухааны салбарын хөгжил төдийлөн бас энэ улс орныг түүчээлэх хэмжээнд бас хүрч чадахгүй байгаа гэдгийг бид нар мэдэж байгаа. 2018 оноос тухайн үеийн Монгол Улсын Ерөнхий сайд өнөөдрийн Монгол Улсын Ерөнхийлөгч Хүрэлсүхийн бас дэмжлэгтэйгээр шинжлэх ухааны салбарынхаа Үндэсний чуулганыг хийж, энэ салбарын хөгжилд бас онцгой анхаарч, энэ ЗГ Оюун-Эрдэнийн ЗГ ч гэсэн энэ шинжлэх ухааны салбарт бас нэлээн өөрчлөлт, шинэчлэлт авчрахаар ингэж явж байгаа. Энэ Их Хурлын бүрэн эрхийн хугацаандаа багтаад бид нар Шинжлэх ухаан технологийн хуулиа бас өнөөдөр шинэчлэн найруулах энд хуулийг ч гэсэн өргөн барьж хэлэлцүүлж байгаа нь энэ салбарын хөгжилд бас нэлээн урагшлах ийм ажил болно гэж харж байгаа.

Ингээд энэ хуулиа бүгдээрээ хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Шинжлэх ухаан технологийн тухай хуулийг хэлэлцэх эсэхийг Байнгын хорооны гишүүдийн 58,3 хувиар дэмжигдлээ.

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн дэмжсэн. Төхөөрөмж ажиллаагүй учраас Мөнхцэцэг гишүүнийг дэмжсэнээр протоколд оруулж өгнө үү. Минийх эсрэг гарчхаж уу. Баярсайхан гишүүн миний бие бас дэмжсэн. Мөнхцэцэг гишүүн, Баярсайхан гишүүнийг энэхүү хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжсэнээр протоколд тэмдэглэж өгөөрэй. Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн уншина.

Ингээд хэлэлцэх асуудлынхаа 1 дүгээр асуудлыг дууслаа.

11.34 цаг.

2 дахь асуудал.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны дарга Бат-Эрдэнэ танилцуулна.

Бат-Эрдэнэ сайдад микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Монгол Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооноос боловсруулсан Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг өнөөдөр Байнгын хорооны хурлаар хэлэлцүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 12 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтад Биеийн тамир⁰ спортын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тусгасан.

Улсын Их Хурлын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2021 оны 10 сарын 19-ний өдрийн хурлаар Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 8 дугаар тогтоолыг баталсан. Тус тогтоолд Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилт, цаашид боловсронгуй болох арга замын тухайд мэргэжлийн байгууллагаар судалгаа хийлгүүлж, судалгааны үр дүнд санал, зөвлөмж боловсруулах, Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 24 оны үйл ажиллагааны

хөтөлбөрт тусгагдсан суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулах, зарим дүүргийн спорт цогцолборыг ашиглалтад оруулах, магадлан итгэмжлэгдсэн спорт клубүүдэд хичээллэсэн иргэний төлбөрийн тодорхой хувийг ЭМД-ын сангаас төлөх хуулийн заалтыг сэргээн хэрэгжүүлэх зэрэг хууль, эрх зүйн орчин, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудал зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тамирчны ёс зүйн дүрмийн хэрэгжилтийн талаар санал боловсруулах, нийтийн биеийн тамирын арга хэмжээ, уралдаан тэмцээн зохион байгуулах, улсын төсвөөс олгодог санхүүжилтийг оновчтой болгох, иргэдийн идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарах талаар санал боловсруулах, спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэлтийн талаар санал боловсруулах, биеийн тамирын багш бэлтгэж байгаа одоогийн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, давтан бэлтгэх тогтолцоог мөн боловсронгуй болгох талаар санал боловсруулах, иргэдийг эрүүл, зөв амьдралын дадал хэвшилтэй болгоход бие бялдрын түвшин тогтоох сорил авах арга, аргачлалыг боловсронгуй болгох, сорилын стандартын батлуулах талаар холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэхээр заасан.

Монгол Улсын Их Хурлын 20 оны 5 сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор батлагдсан Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт идэвхтэй, амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн билээ.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1-д хүн амын хөдөлгөөний дутагдлаас урьдчилан

сэргийлэх, эрүүл амьдрах зан төлөвт насан туршийн дадал олгох зорилго бүхий биеийн тамир, спортын хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн түншилд суурилалтад нээлттэй уян хатан тогтолцоог үндэсний хэмжээнд бүрдүүлнэ гэж заасан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн үзэл баримтлалын түвшинд эргэн харах, шинэчлэх шаардлага үүсээд байгаа. Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны даргын шийдвэрээр Улсын Их Хурлын ажилтан, Монголын үндэсний олимпын болон паралимпын хороод, спортын салбарын төрийн болон ТББ, судлаач эрдэмтэн болон хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 16 гишүүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулсан. 1 жилийн хугацаанд ажлын хэсэг нийт 8 удаа, ажлын дэд хэсгүүд 20 гаруй удаа хуралдаж, гадаад орны биеийн тамир спортын салбарын хууль тогтоомжийн судалгаа, төсөв, санхүүгийн асуудал, цаашилах юм бол допингийн олон улсын хууль, эрх зүйн зохицуулалт, биеийн тамир, спортын салбарын дотоодын хууль тогтоомж, иргэд, мэргэжлийн байгууллагуудын санал зэрэг чиглэлээр ажиллаж, хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан.

Хуулийн төсөлд Монгол Улсын нийгэм, биеийн тамир, спортын салбарт гарч буй шинэчлэл, өөрчлөлт нийгмийн эрэлт хэрэгцээг даган зайлшгүй зохицуулах харилцааг тусгах шаардлагатай болсон тул хуулийн үйлчлэх цар хүрээг тэлж, 8 бүлэг, 41 зүйлтэйгээр боловсруулсан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг өргөнөөр явагдсан. Нийт 68 спортын холбоод, 5 мэргэжил судалгааны байгууллага, аймаг, дүүргийн биеийн тамир, спортын төрийн байгууллагын 30 гаруй удирдах ажилтан, 300 гаруй тамирчин, дасгалжуулагч,

шүүгч, 20 орчим хувийн хэвшлийн төлөөлөгч, хөрөнгө оруулагч, ивээн тэтгэгч нар оролцсон. Хэлэлцүүлэг зөвлөгөөнд оролцогч нарын дэвшүүлсэн саналуудын 72 хувийг хуулийн төсөлд тусгасан.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь дараах байдлаар 2003 болоод 2017 онд баталж байсан спортын салбарын харилцааг зохицуулж байгаа хуулиудаас ялгаатай болно. Үүнд:

Энэхүү хуулийн төсөл нь биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааг Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн идэвхтэй амьдралын хэвшилтэй иргэн, гэр бүлийг дэмжиж, биеийн тамир, спортын ээлтэй орчныг бүрдүүлэх зорилтыг биелүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн.

Тус эрх зүйн баримтад хуулийн зорилтыг биеийн тамир, спортоор дамжуулан сэтгэл, оюуны болон бие бялдрын боловсрол олгох, идэвхтэй хөдөлгөөн, амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, биеийн тамир, спортын удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино хэмээн тодорхойлсон.

Урьд өмнөх хуулийн зорилтоос ялгаатай зүйл нь сэтгэл оюуны болон бие бялдрын боловсрол олгох болон зөв дадал хэвшлийг дэмжих гэж заасан. Сүүлийн 10 жилийн хугацаанд дэлхий даяар өрнөж буй биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулах, иргэдийнхээ хэрэгцээнд нийцүүлэх, оюуны болон бие бялдрын хувьд эрүүл хөдөлмөрийн өндөр бүтээмжтэй иргэний тоог нэмэгдүүлэх чиг хандлагыг Монгол Улсад хуульчлах боломжийг нээж байна.

Улс үндэсний эрүүл чийрэг байхын үндэс нь зөвхөн төрийн бодлого

дэмжлэгээс гадна хувь хүний өөрийн эрүүл мэндийг сахин хамгаалах үүрэг оролцоо хамгаас чухал болохыг тодорхойлж, эрх, үүргийг зохицуулж өгсөн учир хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд иргэн, гэр бүлийн эрхэмлэх зүйл, бүлэг шинээр нэмсэн.

Спортын тамирчид, дасгалжуулагч, шүүгч, ажилтан, арга зүйч нь оюун ухаан, бие бялдар, ёс суртахууны зөв хандлагатай, бүтээлч иргэн, идэвхтэй амьдралын дадал хэвшилтэй гэр бүлийн орчныг төлөвшүүлэхийн төлөө ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахин мөрдөхөөр хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд заасан. Тухайлбал спортын холбоо бүр өөрийн ёс зүйн зөвлөлтэй байх, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдлыг салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэдэх Ёс зүйн зөвлөл хэлэлцэн шийдвэрлэх, ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд мөнгөн шагнал урамшууллын олгохыг түр түдгэлзүүлэх, бусад арга хэмжээ авах зэрэг заалтыг оруулж өгсөн.

Монгол Улсын ЗГ-аас допингийн эсрэг үйл ажиллагаанд хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэх зохицуулалтыг Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах, холбогдох байгууллагуудын чиг үүрэг, ажлын уялдаа, хяналт тэнцлийг боловсронгуй болгох чиглэлийг өгсөн. Хуулийн төсөлд допингийн эсрэг үйл ажиллагааг зохицуулах тусдаа бүлэг орсон бөгөөд тус бүлэгт орсон заалт бүрийг дэлхийн допингийн эсрэг байгууллага WADA-тай гадаадтай харилцан зөвшилцөж нийцэл хийж оруулсан байгаа.

Спортын салбарт хөрөнгө оруулж буй компаниудыг аж ахуйн нэгжийн орлогоос төлөх татвар, гаалийн тарифын хөнгөлөлт зэрэг 2 төрлийн хөнгөлөлтийг төрөөс өмнөх хуулиар үзүүлж байсныг хуулийн шинэчилсэн найруулга түүнийг дагаад

бусад хуульд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөлд төрөөс татварын 6 төрлийн хөнгөлөлт дэмжлэг үзүүлэх талаар тусгасан.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын конвенц, зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор хууль тогтоомждоо хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг баримталж, хөгжлийн бэрхшээлтэй тамирчин, дасгалжуулагч, спортын холбоодын үйл ажиллагааг зохицуулсан 8 заалтыг шинээр оруулсан.

Хуулийн шинэчилсэн найруулгын төсөл сум, дүүргийн хороонд орон тооны биеийн тамирын арга зүйч ажиллуулна гэж туссан бөгөөд цаашид сум, дүүргийн хороодод ажиллах 430 спортын арга зүйч буюу хүний нөөцийн хэрэгцээ үүсэх бөгөөд эдгээр ажилтнууд засаг захиргааны нэгжийн хэмжээнд иргэдийн идэвхтэй хөдөлгөөнд дасгал хийх аргачлал, зааварчилгаа, зохион байгуулалтыг хариуцаж, биеийн тамирын үйлчилгээг иргэн бүрд хүргэх боломж нээгдэнэ.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 14.1.6-д аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллага өөрийн албан ёсны орон тоон дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний төлөөллийг авч ажиллуулах ийм зарчмын заалтуудыг оруулсан. Хуулийн төсөлд бол тусгасан байгаа гэдгийг хэлье. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

Б.Баярсайхан: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотой асуулт асуух гишүүн байна уу? Мөнхцэцэг гишүүн, Ундрам гишүүн, миний нэрийг бас оруулчхаарай. Ингээд тасалъя.

Биеийн тамир, спортын тухай хууль шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн

төслүүд дээр ажиллаж байгаа албан тушаалтнуудын нэрсийг та бүхэнд танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанд хүрэлцэн ирсэн байна.

Тэмүүжин Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны ажлын албаны дарга, Баттулга Биеийн биеийн тамир, спортын улсын хорооны дарга, Өлзийбаяр Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны ажлын албаны хуульч нар өнөөдөр Байнгын хорооны хурал дээр хүрэлцэн ирсэн байна.

Ингээд Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүнд микрофоныг өгье. Асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр биеийн тамир спортын бодлого бол аливаа үндэстний хүн амын эрүүл байх тэгээд үндэсний соёл өв уламжлалаа хадгалах, тэгээд дэлхийн тавцанд Монгол Улсын нэрийг гаргах тамирчдыг бэлтгэх зэрэг маш чухал асуудал хөтөлбөрийн салбар байгаа. Тийм учраас Биеийн тамир, спортын хуулийн шинэчилсэн найруулгыг бол дэмжиж байна.

Тэгээд 2017 онд батлагдсан нөгөө Биеийн тамир, спортын хуулийн хэрэгжилтийг бид нар хянах, хэрэгжилтэд хяналт тавих ийм ажлын хэсэг бол ажилласан байгаа. Миний хувьд энэ УИХ дахь Биеийн тамир, спортын бүлгийг дэмжих даргын хувьд энэ 2021 онд Монгол Улсад үйлчилж байгаа спортын хуулийн хэрэгжилтийг хангах энэ чиглэлийн хяналт шалгалтыг хийсэн. Тэгээд Улсын Их Хурлын бид нарын энэ ажлын хэсгээс гарсан зөвлөмжүүд бол ерөнхийдөө нэг 10 хэдэн зөвлөмж гарсан байгаа. Энэ дотор тамирчдын мэргэжлийн шигшээ багийн тамирчдыг дэмжих, тамирчдын ёс зүй, допингийн асуудлаар анхаарал хандуулах, мөн бие биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтуудыг дэмжих, тэгээд мөн биеийн тамир, спортын талаарх Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого дахь хэрэгжилтүүдийг хангах,

мөн биеийн тамир, спортоор хичээллэгсдийг дэмжих буюу Монгол Улсын хүн амын нийтийн биеийн тамирыг дэмжих, мэргэжлийн спортыг дэмжих гэдэг энэ чиглэлүүд дээр бол ийм санал зөвлөмжүүд гараад энэ чиглэлээр Их Хурлын тогтоол гарсан байгаа.

Тэгэхээр энэ хуулийн төсөлтэй холбогдуулан нэг хэд хэдэн асуулт байгаа. Ер нь Монгол Улсад бас хөгжиж байгаа эдийн засагтай орон гэдгээрээ спортын салбар дахь төсөв, тэгээд спортын салбар дахь тамирчны тэмцээн уралдааны асуудал их төвөгтэй байж ирсэн. Энэ чиглэлээр бид нар аль болох хувийн салбарынхаа оролцоог дэмжих, спортын чиглэлийн хөрөнгө оруулалтад татварын болон бусад дэмжлэг үзүүлэх шаардлагатай байдаг. Түрүүн энэ сайдын танилцуулга дээр нэг б төрлийн татварын дэмжлэг биеийн тамир, спортын салбаруудад олгохоор заасан гэсэн байна. Тэгэхээр яг ямар, ямар төрлийн спортын салбарын дэмжлэг байгаа вэ?

Ер нь яг мэргэжлийн спортын хувьд бол зарим тоног төхөөрөмжүүд асар үнэтэй байдаг. Тэгээд тэрийг гаалиар оруулж ирэхэд ихээхэн бас татвар өндөр байдаг. Тийм учраас энэ татварын дэмжлэг бол асар хэрэгтэй байгаа.

Тэгээд энэ хувийн салбартаа спортын хөгжлийг дэмжиж байгаа, спортын тэмцээн уралдааныг ивээн тэтгэдэг компани, хувь хүмүүсийг дэмжих нь бас чухал байдаг. Энэ чиглэлийн дэмжлэг манай энэ биеийн тамир, спортын салбарын бас хөрөнгө оруулалтад нэлээн дөхөм болохуйц л байгаа гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуулт нь ер нь бол энэ яг боловсролын байгууллага тэр дундаа ЕБС-д спортыг дэмжих, хүүхдийг бага наснаас нь спортоор хичээллэх явдлыг ер нь асар дэмжих шаардлага байгаа. Одоо бол ерөнхийдөө энэ яг биеийн тамирын

хичээл, урлагийн хичээл бол нэг ийм дагавар шинж чанартай юм шиг гээд эцэг эхчүүдийн дунд ч гэсэн ийм ойлголт байна. Багш нарын дунд ч гэсэн биеийн тамир спортын болон урлагийн багш нарын хөдөлмөрийг үнэлэхгүй байх, ер нь туслах шинж чанарын гэдэг юм уу, туслах хөтөлбөр гэж ойлгодог. Тэгвэл Монгол үндэстэн эрүүл байхын хамгийн чухал асуудал нь бол бага наснаасаа спортоор хичээллэж, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй байх ёстой юм. Тэгвэл ЕБС-аас авхуулаад энэ сургалтын бүх салбарт энэ нийтийн биеийн тамирыг дэмжих, спортыг дэмжих чиглэлийн ямар дэвшил гарч байгаа вэ гэдгийг асууя.

Мөн энэ маш олон нийтийн дунд нэлээн бас маргаантай байдаг нэг асуудал бол энэ допинг болон тамирчны ёс зүйтэй холбоотой асуудал байгаа. Тэгээд энэ төрөөс маш өндөр хэмжээний шагнал олгодог спортын олимпын болон бусад шагнал авсан тамирчид насан турш. Тэгэхээр энэ шагнал маань хэр хүртээмжтэй байгаа юм бэ? Хэрвээ тухайн өндөр түвшний шагнал авсан тамирчид ямар нэг ёс зүйн алдаа болон допингийн асуудалтай холбогдсон тохиолдолд энэ шагналыг зогсоох нь зөв юм биш үү гэдэг ийм байр суурь энэ манай ажлын хэсэг биеийн тамир, спортын чиглэлээр ажиллаж байхад бол энэ гарч байсан юм.

Тэгэхээр энэ тамирчны ёс зүйтэй уялдуулаад шагнал урамшлын бодлого дээр ер нь өөрчлөлт гарч байгаа юу, үгүй юү? Үүнийг ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Бат-Эрдэнэ сайдад микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Та бүхэн маань энэ Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос би түрүүн танилцуулгадаа дурдсан Засгийн газарт чиглэл өгсөн 8 дугаар тогтоолд

маш тодорхой зааж өгсөн. Яг энэ заасан зүйл, заалтуудыг энэ Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд бол тусгагдсан байгаа. Манай ажлын хэсгээс яг туссан хэлбэрээр нь та нар юуг нь өгөөрэй хариултыг нь өгөөрэй гэж.

Тэгэхээр зэрэг энэ биеийн тамир, спортын салбарын энэ салбар дундын уялдааг хангах чиг үүрэгтэй эрхэлсэн сайдын албыг бий болгосон. Энэ хүрээндээ бид нар салбар дундын уялдааг зохицуулахтай холбоотой тухайлах юм бол ЭМЯ-тай бид нар хамтарч манай эрүүл мэндийн салбар бол эмнэлгийн тусламж үйлчилгээг хамгийн эхний ээлжид авч явсан. Дэлхийн бусад улс орнууд нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг хамгийн эхэнд нь авч явдаг. Нэг үгээр хэлэх юм бол ард иргэдийнхээ эрүүл идэвхтэй, тэр амьдралын дадал хэвшил, өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх энэ бодлого нь бол өмнө нь явдаг. Тэгээд яг энэ жишигт нь нийлүүлээд УИХ, та бүхэн маань саяхан ЭМЯ-ны салбарын чиглэлийн Нийгмийн эрүүл мэндийн тухай хуулийг баталж өгсөн. Энэ хуулийн ажлын хэсэгт манай биеийн тамирын салбараас оролцсон. Энэ ажил зохицуулаад явж байгаа.

Нөгөө талынх нь юм бол боловсролын салбартай бид нар хамтарч ажиллаж байгаа. Хууль, эрх зүйн зохицуулалт. Яг бодит нөхцөл байдал бол таны хэлж байгаатай санал нэг байгаа. Энэ хүний хөгжлийн асуудлын суурь бол гоо зүй, урлаг, гоо зүйн хичээл, эрүүл мэнд, биеийн тамирын хичээл, хөдөлмөр, технологийн хичээл байдаг. Гэтэл энэ яг боловсролын салбарт олон 10 жил хавсарга байдлаараа явж байгаа. Тэгээд тийм учраас манай Байнгын хороо боловсролын салбарын багц хууль батлагдсан. Үүнтэй холбогдож сургалтын хөтөлбөр бусад шинэчлэлийн хүрээнд энэ асуудлаа арай өөр түвшинд авч үзэхээр ингээд яригдаж байгаа. Манай салбарын дэвшүүлсэн та

бүхнийхээ өгсөн чиглэлийн дагуу энэ боловсролын салбар дахь спортын заалны стандарт хэмжээ, эрүүл ахуйн шаардлага, гэрэлтүүлэг, агааржуулалт, заалны стандартыг бид нар тогтоож, үүнийг шинэчлэх чиглэлээр бид нар бүрэн хэмжээний ажил хийхээр ингэж төлөвлөж байгаа.

Дээрээс нь биеийн тамир, спортын салбар бол аль ч улс оронд дэмжигчдийн хүрээн дээр явдаг, ивээн тэтгэгч. Энэ биеийн тамирын салбар нийгмийн хариуцлагын хүрээндээ үйл ажиллагаа явуулж байгаа энэ байгууллагуудаа дэмжих ийм бодлого зорилтын хүрээнд анх удаа 30 гаруй төлөөлөл орсон. Степ Арена, Южи Арена, Мөнхийн үсэг, өөр бусад энэ томоохон хөрөнгө оруулж байгаа ААН-үүдийн төлөөлөл, энэ техник тоног төхөөрөмж таны хэлдэг яг дэлхийн стандартын тоног төхөөрөмж импортлож байгаа, хангаж байгаа, дотооддоо үйлдвэрлэж байгаа энэ ААН-үүдийн төлөөлөлтэй уулзаад тэднийхээ дэвшүүлсэн саналуудыг ЗГ, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Хууль зүйн яамтай тохиролцож байгаад бид бас бололцооны хэмжээгээр оруулсан байгаа. Тэр нэмэгдсэн 6 зүйл заалтын талаар түрүүн би хэлчихсэн байгаа. Үүнийг оруулж өгөх байх гэж ингэж байгаа.

Допинг, ёс зүйтэй холбоотой асуудалд бол онцгой. Бүр ёс зүйн ийм бүхэл бүтэн заалт оруулсан. Энэ бол өнөөдөр тавигдаж байгаа нийтлэг шаардлага. Бид Улсын Их Хурлын гишүүнийхээ ёс зүйн дүрмийг эхлээд хуулийг баталж авсан. Дараа нь Төрийн албан хаагчдын ёс зүйн тухай хууль батлагдсан. Энэ хүрээндээ ТАЗ-ийн дэргэд том хэмжээний хороо байгуулагдаад ажиллаж байгаа. Энэ шаардлагад нийцүүлж спортын холбоод дэргэдээ Ёс зүйн зөвлөлтэй байх, энэ ёс зүйн асуудлаа холбооныхоо дүрэмд хуульчилж өгөх ийм чиглэлээр асуудлуудыг ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Нэмэлт хариултыг ажлын хэсэг 3 дугаар микрофоныг нээж өгье. Баттулга дарга хариулна.

Олимп, нийтийн биеийн тамир, спортын үндэсний хорооны Ажлын албаны дарга Тэмүүжин. Ажлын хэсгийн ахлагч Тэмүүжин байна. Мөнхцэцэг гишүүний асуусан асуултад хариулъя. Тодорхой асуулт, энэ татварын хувийн хэвилийг спорт, нийтийн биеийн тамирт хөрөнгө оруулахад нь маш тодорхой хөнгөлөлтүүдийг үзүүлэхээр энэ хууль дотор заачихсан байгаа. Одоо үйлчилж байгаа хуулиар болбол ААНОАТ спортод дэмжлэг үзүүлсэн ААН-ийн албан татварын чөлөөлөх хэсгээс нь 10 сая төгрөг хүртэл хөнгөлөлт татвар ноогдуулахгүй байх хөнгөлөлтийг заасан байгаа.

2 дугаарт, гаалийн татварт тодорхой хэмжээгээр гаалийн татварыг Засгийн газрын шийдвэрээр гаргасан жагсаалтын дагуу чөлөөлөх бас ийм 2 заалтууд өнөөдрийн байдлаар үйлчилж байгаа. Үүн дээр нь нэмэгдүүлээд бид нар шинэ хууль дотроо дагалдах хуульдаа дараах хөнгөлөлтүүдийг эдлэхээр хувийн хэвилийнхнийг дэмжих үүднээс эдлэхээр заасан байгаа.

1 дүгээрт, ААНОАТ-ын хөнгөлөх хэсгийг 10 сая төгрөг байсныг бид нар 100 сая төгрөгөөр заасан байгаа.

2 дугаарт, спортын зориулалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг олон улсын олимпын стандарт шаардлагад нийцсэн барилга, байгууламжуудын гаалийн хөнгөлөлтийг энэ хөнгөлөхөөр нь заасан байгаа.

3 дугаарт, хуучин үл хөдлөх хөрөнгийн татварыг нь бүрэн хэмжээгээр төлж байсан. Одоогоор төлж байгаа бол бид нар эхний 5 жилдээ 50 хувиар хөнгөлөх одоо яг спорт барилга байгууламжийн 100 хувиар хөнгөлөх, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлөхөөр заасан байгаа юм.

Гааль мөн спортын тоног төхөөрөмж, спортын хэрэгслийг оруулж ирэхэд гаалийн татварыг одоо байгаа чөлөөлөлтийнхөө хэмжээнд хэвээр нь үлдээд үүн дээр нь нэмэгдээд дараагийн 4 жилд эдгээр гаалийн татварын төлбөрүүдийг 4 жил хүртэлх хугацаагаар хойшлуулах боломжуудыг нь нээсэн тийм заалтуудыг оруулсан байгаа.

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүн тодруулъя.

Ц.Мөнхцэцэг: ЕБС-д биеийн тамирын гэдэг юм уу, урлагийн багш нар маань ингээд хичээлээс гадуур нөгөө секц, дугуйлан ажиллуулахад хуучин бол яг бид нарыг 10 жилд байх үед бол нэлээн секц, дугуйлан хамралт сайтай байсан. Одоо ерөнхий боловсролын сургуулиуд маань нөгөө заалнуудаа хувь хүмүүст түрээслээд, сургуулийн хүүхдүүд нь өөрсдөө бэлтгэл хийх боломж олдохгүй байгаа.

Дээр нь яг тухайн секц, дугуйлан ажиллуулахад нөгөө багш нар нь ямар ч цалин урамшуулалгүй учраас ер нь их сонирхол багатай болчихсон. Тэгэхээр яг дунд сургуулийн биеийн тамирын багш нарыг хүүхдээ хөгжүүлэх, спортын секц, дугуйланг ажиллуулах энэ тухай дэмжлэг оруулсан ийм заалтууд байгаа юу? Хуульдаа.

Б.Баярсайхан: Баттулга дарга 4 номерын микрофон.

Биеийн тамир, спортын улсын хороо Баттулга. Байнгын хороодын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Бид энэ Биеийн тамир, спорт тухай хууль дээрээ энэ секц, дугуйлантай холбоотой асуудлуудыг бас урд талын хуулиасаа арай өөрөөр оруулж өгч байгаа. Секц, дугуйлангийн хэлбэрийг дугуйлангийнхаа хэлбэр, зохион байгуулалтыг өөрчлөх, шаардлагатай хөрөнгийг тухайн жилд тусгах, төсөвт

тусгана гээд 16.2.3 дээр бид нар бол заалтаар оруулж өгч байгаа. Энэ бол секц, дугуйланг хичээллүүлэх багш нарын тухайн цалин юутай холбоотой асуудлыг ингээд тусгана гэдгээр бол оруулж өгч байгаа.

Мөн энэ 16 дугаар зүйл маань бол боловсролын байгууллага дахь биеийн тамирын үйл ажиллагаа гэдэг зүйлээр орж байгаа учраас энэ боловсролын байгууллагад бас хамаарах ийм зүйл болоод явчхаж байгаа юм. Тэгээд энэ дээр нь бид нар мэргэжлийн биеийн тамир, спортын салбарын зүгээс бас боловсрол, сургалтын байгууллагын биеийн тамирын “цөм” хөтөлбөрийн агуулга стандартад ажлын хэсэгт нь ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Ажлын хэсэгт цаг нэмж өгье. 4 номер.

О.Баттулга: Биеийн тамир, спортын энэ сургалт, хөтөлбөрийг боловсруулахад биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн байгууллагаас хамтран саналыг тусгадаг авдаг байхаар ингэж тусгаж өгч байгаа. Урьд нь энэ асуудал бол байдаггүй байсан.

Мөн боловсон хүчин бэлтгэх биеийн тамир, спортын салбар хариуцсан байгууллагаас бас мөн саналыг тусгаж авч ажилладаг байхаар ингэж тусгаж оруулж өгч байгаа. Мөн стандартын боловсролын байгууллагын үндэсний стандартад нийцсэн стандарт талбай, тоног төхөөрөмж, хэрэгсэлтэй байх асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэхээр бас энэ дээр бас оруулж өгсөн байгаа. Ийм байдалтайгаар секц, дугуйлангуудын асуудлыг бол оруулж өгч байгаа. Бид бол энэ хуулийнхаа заалт дээр ийм байдлаар тусгаж байгаа. Яг оруулж өгч байгаа энэ асуудал маань боловсролын байгууллага дээрээ яг энэ хуулийн хэлбэрээрээ хэрэгжих асуудал дээр манай салбарын зүгээс бас хариуцаж оролцож ажиллах болно.

Б.Баярсайхан: Баярлалаа. Чинбатын Ундрэм гишүүн асуулт асууя.

Ч.Ундрэм: Энэ Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бол дэмжиж байгаа юм. Тэгээд өнгөрсөн хугацаанд сая Бат-Эрдэнэ сайд ч хэлж байна. Үнэхээр бас нэг ийм энэ салбар маань орхигдож ирсэн. Тэгээд сүүлийн 3 жил бол бас нэлээн энэ салбарт анхаарал УИХ, ЗГ тавьсан байгаа. Орон нутгийн жишээлбэл Биеийн тамир, спортын газруудад анх удаа хөрөнгө оруулалтууд хийгдэж байна. Тэнд урсгал зардал дээр нь нэмж төсөв хөрөнгө нь нэмэгдэж байна, орон тоо нь нэмэгдэж байна. Энэ орон нутагт байгаа иргэд чинь биеийн тамирын үйлчилгээ авах эрхтэй. Тэнд байгаа хүмүүсийн нийтийн эрүүл мэнд, нийтийн спорт, биеийн тамир нь бас хөгжих ёстой гэж би бодож байгаа.

Тэгээд ер нь бол энэ боловсролын хөтөлбөртэй л их сайн уялдуулж байж, нийтийн биеийн тамир болон спортыг аль алиныг нь хөгжүүлнэ гэж би бодож байгаа. Ер нь бол гадаадад бол дэлхийн аварга, олимпын аваргыг бага ангиас нь л бэлддэг. Бүр бага ангид нь бага сургууль дээр тэр үндэсний спортыг нь болон олон улсын спортыг нь хөгжүүлээд, клубүүд ажиллуулаад тэндээс л хүүхдүүдээ бэлдэж эхэлдэг. Манайд бол бас ёстой жинхэнэ нөгөө мөнчгөрөөрөө яваад л яг өөрсдийнхөө дур сонирхлоороо явсаар байгаад л зайлуул, өдий зэрэгтэй байгаа гэж харахаар байгаа юм.

Тийм учраас энэ орон нутагт байгаа нэг ээлжээр ажиллаж байгаа бас сургуулиуд байгаа шүү дээ, сумдад. Энэ дээр нэг ганц 2 спортын клубүүдийг бүр ингээд хөтөлбөрт нь оруулаад, багш нарыг нь аваад хөгжүүлж эхэлмээр байгаа юм.

1 дүгээрт, үндэсний спорт, сур харваа, бөх ч байдаг юм уу, тийм ээ. Үүнийг тэндээ хөгжүүлээд, яг үдээс хойш гадаадад яг спорт, биеийн тамирын л

хичээлд хамрагддаг юм шүү дээ, хүүхдүүд. Тэгээд хотод бол яах вэ, 2 ээлжтэй байгаа учраас боломжгүй. Тэгэхдээ 1 ээлжтэй сургуулиудаасаа эхлээд хөгжүүлээд, ингээд туршаад явбал зүгээр байна.

Мөн орон нутагт байгуулагдаж байгаа энэ ахлах сургуулиуд дээр бас яг энэ клубүүдээ ажиллуулаад эхэлбэл зүгээр байх гэж би бодож байна. Мөн энэ үндэсний бүх сагсан бөмбөгийн спорт сүүлийн үед яг ийм спортын бизнес чиглэлээрээ хөгжиж байгаа нь маш зөв. Тийм учраас үүнийг бас бид нар бусад спортоор хөгжүүлээд ингээд явах юм бол манай спортынхон нэлээд бас ашиг орлого нь ч нэмэгдэнэ. Спорт нь өөрөө ч хөгжиж байна. Олон хүүхдүүд ийшээ бас хамрагдах орох хүсэл сонирхолтой болж байна.

Энэ нөгөө ААН-үүд энэ биеийн тамир, спортын салбарт хэрвээ ингээд дэмжлэг үзүүлэх юм бол бас татвараас чөлөөлнө гэдэг бол маш зөв заалт. Компаниуд манайх гэхэд л өчнөөн олон 10 спортын хүүхдүүдийг гадаад явахад нь ингээд тусалж дэмжээд явж байна. Тэгэхдээ энэ жилд 100 сая гэдэг бол бас бага мөнгө шүү. Үүнийг бас жоохон өсгөх шаардлагатай байх гэж бодож байна. Тэгээд яах вэ, хуулийг хэлэлцэх шатад ажлын хэсэг байгуулагдаад энэ дээр бас тооцоо судалгаа хийгээд, өнгөрсөн хугацаанд компаниуд хэр хэмжээний дэмжлэг үзүүлж байсан юм, ер нь хэр хэмжээний дэмжлэг нэг багт жишээлбэл хэрэг болдог юм гээд үүнийг жоохон тооцоолж байгаад дүнг нь өсгөх шаардлагатай гэж би бодож байна.

Тэгээд ер нь хуулийг бол үзэл баримтлалын хүрээнд бүрэн дэмжиж байна.

Б.Баярсайхан: Ундрам бараг үг хэлчихлээ хариулах уу? Бат-Эрдэнэ сайд. Бат-Эрдэнэ сайд хариулья.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Байнгын хорооны маань гишүүд бол энэ 20 оноос хойш 4 жилийн хугацаанд энэ биеийн тамир, спортын салбарын бодлого, хууль, эрх зүйн шинэчлэлт, энэ тулгамдаж байгаа асуудал дээр бол үнэхээр анхаарч ажилласан улсууд. Мөнхцэцэг гишүүн, Баярсайхан гишүүн, 2 Мөнхцэцэг гишүүн, тийм ээ, манай Чинбүрэн гишүүн, Аубакир гишүүн бүгд л. Тэгээд та бүхэндээ баярлаж байгаа. Та бүхнийхээ Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоолоор ЗГ луу үүрэг чиглэл өгсөн энэ заалт, мөн тухайн үеийн Биеийн тамирын хороог даргалж байсан Жаргалсайхан даргатай хамт энэ хуулийн өнөөдрийн энэ төсөл дээр та бүхнийхээ ажиллаж байсан энэ яг төсөл хэлбэр дээр бид нар үргэлжлүүлээд ажилласан. Тэгээд энэ талаас нь бид нар онцгой анхаарч байгаа.

Та бүхний гаргаж байсан санал өгсөн чиглэл дотор бол ЭМД-ын сангаас өөрийнхөө эрүүл мэндийг хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажиллаж байгаа иргэдээ дэмжих ийм заалт оруулсан байсан. Энэ заалтыг сэргээх тухай асуудал та бүхэн маань оруулсан байсан. Бид нар Сангийн яамтай ярьж байгаад ерөөсөө ЭМД-ын сангаас биш шууд төсөв дээр нь тусад нь спортыг дэмжих сан дээрээ тооцоолол хийгээд, хөрөнгөө төвлөрүүлээд, тэндээсээ энэ бие бялдрын чийрэгжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ байгууллага, хүмүүст аттестатчилалд оруулаад, тэгээд иргэдээ урамшуулдаг бонус олгодог ийм чиглэлийн заалтуудыг бол оруулсан байгаа.

Нөгөө талд нь энэ ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулахтай холбоотой энэ тогтоолд заасан, үүрэг чиглэл өгсөн. Үүний дагуу Засгийн газрын тогтоол журам гарсан. Энэ журмын хэрэгжилт биелэлтийг хангаж ажиллаж байгаа. Баттулга дарга энэ жилийн хугацаанд энэ тухайлах юм бол олимп, дэлхийн

аваргаас, олимпын төрлийн спортоор бас олимп дэлхийн аваргаас медаль авсан, сар бүр л урамшилаа авч байгаа тамирчдын нийгмийн хариуцлагын хүрээнд үүргээ хэрхэн биелүүлж байгаа, ёс зүйтэй нь холбогдуулж дүгнэж энэ шагналын асуудлыг олгож байгаа.

Цаашилах юм бол энэ спортын холбоодтой чинь гэрээ хийдэг шигшээ баг байгуулдаг, улсаас бол шигшээ баг байгуулдаггүй шүү дээ. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төрийн зарим чиг үүргийг хувийн хэвслээр гүйцэтгүүлэх энэ хууль, бодлогын хүрээнд л бид ажиллаад тогтчихсон.

Тэгэхээр энэ спортын холбоодын засаглалыг сайжруулахтай холбоотой ялангуяа энэ хариуцлагатай холбоотой юман дээр нэлээн ажил хийгдэж байгаа. Тэгээд энэ талын юуг шаардлагатай бол нэмж хариулж өгч болно. Ер нь энэ салбар дундын уялдааг хангахтай холбоотой Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай бид бусад улс орнууд, Америк тэргүүтэй бусад улс орнуудад байдаг Гэр бүл, хөгжлийн төв цогцоороо, тэнд гэр бүлээрээ очоод сурах, боловсрох, сургалт авах, бүх юмнууд нь нээлттэй. Хүүхдийг тэнд саатуулах бүх юмнууд нэг цогцолбороороо. Спортоор хичээллэх, секц дугуйлан, урлагийн янз бүрийн секц дугуйланд явах тийм бололцоотой юмнуудыг нэгтгэсэн ийм төв байгуулах чиглэлээр бид нар хамтарч ажиллаж байгаа.

Ер нь бол манай үе үеийн парламентын гишүүд бол энэ биеийн тамир, спортын салбарын хөрөнгө оруулалтын чиглэлээр дандаа идэвх санаачилгатай ажиллаж ирсэн. Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 119 сумд сургуулийн спортын заалнаас гадна спортын цогцолборууд баригдчихсан байна. Манай Архангай аймагт гэхэд Шинэ спортын ордон баригдаж байгаа. Гэсэн хэдий ч аймгийнхаа төвийн алслагдсан гэж хэлэх юм уу, захын нэг хороодод спортын 5

шинэ спортын заал энэ жил 74 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх гээд 10 жил гагцхисан энэ аймгуудын, дүүргийн энэ биеийн тамирын спортын ордуудыг бүрэн ашиглалтад оруулах гээд бид нар бол чармайж ажиллаж байгаа.

Тэгээд энэ хуулийн төслийг хэлэлцүүлгийн явцад та бүхэн маань улам чамбайруулаад та бүхний ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Надад нэг 2, 3 асуулт байна. Монгол Улс Допингийн эсрэг үндэсний байгууллагыг анх 2007 онд байгуулж байсан. Манай улс бол Допингийн эсрэг конвенцод нэгдэн орсон ийм улс байгаа. Тэгтэл өнөөдөр энэ допингийн эсрэг асуудал маш их маргаантай явдаг. Сая Бат-Эрдэнэ сайдын танилцуулснаар допингийн эсрэг асуудлыг бие даасан бүлэг болгож оруулсан гэж байна. Тэгэхээр яг ингэснээр одоогийн энэ улсын бүртгэлтэй холбоотой үүсээд байгаа асуудал бүрэн шийдэгдэх үү гэдэг асуултад та нар маань хариулж өгөөч ээ.

2 дугаарт, энэ Нийгмийн эрүүл мэндийн тухай хууль батлагдсан. Энэ хуультай уялдан гарч байгаа энэ Биеийн тамир, спортынхоо хуулийг бол бүрэн дэмжиж байгаа юм. Энд би урьд нь ч гэсэн асууж байсан. Хэдийгээр боловсролын салбарын асуудал боловч энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт миний тусгуулсан нэг зорилт байдаг. Улсын хэмжээнд байгаа бүх сургууль, цэцэрлэгийг биеийн тамирын хичээлийн хэрэгслээр бүрэн хангана гэсэн. Тэгэхээр манай энэ спортын салбарынхан маань энэ боловсролын салбарт байгаа хэрэг техник хэрэгсэлгүй байгаа 1 дүгээрт, 2 дугаарт хүүхдийн нас биед тохирсон техник хэрэгслээр хангаж чадахгүй байгаа. Энэ нь хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж байгаа.

3 дугаарт, өнөөдөр энэ заалны асуудал байгаа шүү дээ. Стандартын бус заалтай биеийн тамир спортын заалнууд маань хүүхэд залуучуудын энэ сагс тоглож байгаа хүүхэд, залуучуудын нуруу өвдгийг маш их гэмтээж байгаа гэсэн. Ийм асуудал ингээд үүсээд байгаа. Энэ дээр та нар маань ямар яг шийдэл гаргах гэж байна вэ? Энэ боловсролын салбарын асуудал гэж ингэж орхих ямар ч боломжгүй байна. Нэгэнт бид нар бүхэл бүтэн Монгол Улсын хэмжээнд биеийн тамир, спортыг хөгжүүлэх, үүнийгээ бүх нийтийн эрүүл байх, урт наслах, мөн зөв зан чанар төлөвшилтэй байх ийм зорилгын хүрээнд хийгдэж байгаа хууль учраас энэ бол илүү том агуулгыг нь та бүхэн маань хариуцах байх гэж ингэж харж байна. Тэгээд энэ хуультай энэ миний асууж байгаа асуудал холбогдох уу гэдэг асуултад хариулт өгнө үү? Баярлалаа.

Бат-Эрдэнэ сайдад микрофон өгье.

Б.Бат-Эрдэнэ: Баярсайхан даргын асуултад хариулъя. Таны тавьж байгаа асуудал бол маш зөв зүйтэй ийм асуудал. Тэгэхдээ салбар дундын уялдааг хангахтай холбоотой бид нар хамтарч ажиллана. Бид бодлогоо гаргана. Би боловсролын салбарын СӨБ-өөс эхлээд бүх шатны боловсролын байгууллагын биеийн тамир, спортын хичээлийн заал танхим, хэрэглэл, хичээлийн агуулга энэ стандартын тэр чиглэлээр бид бодлого гаргана. Тэгэхээр зэрэг УИХ шийдээд энэ боловсролын салбарын таны хэлдэг спортын хэрэглэл, материалтай холбоотой асуудлыг, эсвэл тэр заалыг стандартын дагуу шаардлага хангасан ийм заалаар засах сайжруулах, шинэчлэх, шинээр барих энэ ажлын хөрөнгө зардлыг манай салбар дээр тусгаад өгчих юм бол түүгээрээ явчихна. Одоогийн Төсвийн хууль зохицуулалтын дагуу бол боловсролын салбар дээрээ тусгагдана. Бид бодлогыг нь гаргаад хатуу шаардана. Ийм л зохицуулалт байгаа.

Үнэхээр таны хэлж байгаагаар биеийн тамирын хичээлийн үр нөлөө, ач холбогдлыг нь олон 10 жил үнэлж явж ирээгүйгээс шалтгаалаад тэнд бол үнэхээр хүнд нөхцөл байдал байгаа. Улсын эдийн засаг хүнд байх үед шинээр баригдсан спортын заалууд ч гэсэн та бүхэн маань мэдэж байгаа. Ихэнх нь шаардлага хангахгүй, сэндвич, агааржуулалт, гэрэлтүүлэг муутай, дулаан халуун шаардлагын түвшинд хангаж чаддаггүй.

Дээрээс нь шал бол аймшигтай. Шалыг бол шууд цемент цутгаад дээрээс нь зориулалтын нэртэй ийм будаг түрхчихсэн эсвэл хулдаас дэвсчихсэн байгаа. Энэ бол яг таны хэлдгээр нуруу, үе мөчний, өвдөгний асуудал бол маш их хортой ийм байгаа, эрүүл мэндэд нь нөлөөлж байгаа. Тэгээд энэ чиглэлээс нь бол бид анхаарна.

Дараагийнх нь юм бол энэ допингтой холбоотой асуудал бол их ужгирсан ийм асуудал байна. Тухайлах юм бол энэ асуудал чинь допингтой холбоотой асуудал шалгагдаад, олон улсын арбитрын шүүхүүд хүртэл бол маргаан үүссэн тэр нөхцөлд процессын ийм алдаа гарсан байна. Ямар алдаа гарсан гэдгийг нь тогтоогоод өгчихсөн. Допингийн эсрэг үндэсний байгууллага ЗГ-тайгаа хамтарч үндэсний дүрмээ батлах ёстой. Гэтэл Допингийн эсрэг үндэсний байгууллага өөрөө дангаараа дүрмээ баталсан тухай асуудал ярьсан. Үүнийх нь дагуу олон улсын WADA байгууллагаас манайхыг нөгөө цагаан туганд орохоор ийм асуудал 22 оны 10 сарын 14-нөөр хугацаа заачихсан ийм нөхцөл байдалтай ажил авсан.

Ингээд бид нар маш шуурхай ажиллаад ингээд ЗГ-аар үндэсний дүрмээ батлуулсан. Тэр үндэсний дүрмийг бол өөрснөө санаачлаад батлахгүй. Ялгаагүй энэ хуулийн допингийн заалтыг WADA-аас нийцэл хийж байгаатай адилхан WADA-тай нийцэл хийж байж дүрмээ баталсан. Одоо бол ингээд үндэсний

хэмжээний биеийн тамирын хуульдаа допингийн асуудлыг бүрэн зохицуулсан ийм WADA-тай нийцэл хийсэн бүлэг, заалт орж байгаа учраас үүний дагуу бол асуудал цаашаа шийдэгдээд явна. Одоо үүсээд байгаа тэр маргаантай асуудал бол шүүхийнхээ журмаар тэр холбогдох байгууллагынхаа журмаар юмнууд нь явна.

Энэ хууль эцэслэгдээд батлагдсаны дараа бол асуудал цэгцрээд явна гэсэн шийдэгдэнэ гэсэн тийм юутай байгаа. Ер нь зүгээр энэ бас 8 сард нөгөө 2 олимпын хугацаанд хуримтлагдсан допингийн лабораторийн шинжилгээний төлбөр төлөөгүй өр үүссэн. Бусад асуудлууд үүссэн. Допингийн эсрэг үндэсний байгууллагатай холбоотой шүү. ЗГ-тай холбоотой асуудал биш. Тэгээд түүгээр хатуу шаардлага ирсэн. Дахиад олимпод цагаан тугийн доор орохтой холбоотой асуудал ирсэн шүү дээ.

Тэгээд энэ байдлыг нь Засгийн газарт, нийгэмд мэдээлээд, ЗГ-аас Хэрэг эрхлэхийн сайдаар ахлуулсан ажлын хэсэг ажиллаад бид нар маш богино хугацаанд энэ асуудлыг бүгдийг нь шийдсэн. WADA байгууллагаас бол Монгол бол олимпод ороход ямар ч асуудал байхгүй. Ногоон гэрэл ассан, бүх юу батламжаа өгчихсөн байгаа. Яг ийм маягтай л ажил бол явж байгаа.

Б.Баярсайхан: Тэгээд дэлхийн Допингийн эсрэг байгууллагын дүрэм, түүний заавал дагаж мөрдөх ёстой стандартад зааснаар болохоор Допингийн эсрэг үндэсний байгууллагыг эрх бүхий төрийн байгууллага эсвэл түүний эрх олгогдсоноор МҮОХ байгуулах боломжтой гэсэн энэ заалтыг оруулж өгөх юм бол энэ маргаан бас бүрэн эцэслэгдэх боломжтой юм болов уу гэж харж байна. Тэгээд хууль хэлэлцэх хүрээнд бас энэ асуудлаа сайн бид нар илүү нямбай чамбай оруулах байх. Ер нь бол Монгол Улс маань олон улсын өмнө, тэр тусмаа НҮБ, Юнеско-ийн өмнө

хүлээсэн үүргээ бас бүрэн биелүүлэх ёстой.

Нөгөө талаар Монголын ард иргэдийн хамгийн шударга бай, энэ спортод ёс зүйн асуудал цаашид гарахгүй байх ийм нөхцөлийг бид нар бүрдүүлж өгөх ёстой гэж ингэж харж байна.

Мөн Биеийн тамир, спортын улсын хорооноос бас энэ ХЭҮК-т та бүхэн маань хамтарч энэ хүүхэд, залуучууд сагсан бөмбөгт хайртай дуртай байгаа энэ хүүхдүүдийн стандартын бус энэ зааланд тоглохоороо, энэ шалыг хэрэглэснээрээ нурууны, үе мөчний, өвдөгний энэ насаараа ийм асуудалтай эрүүл мэндийн асуудалтай болж байгаа энэ асуудлыг шаардлага тавьж, үүнийг үндэсний хэмжээнд бас шийдэх тал дээр та бүхнийг санаачилгатай ажиллаасай гэж бас Байнгын хорооны гишүүдийг төлөөлж та бүхэндээ бас хэлж байна.

Ингээд Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя.

Энэ хуулийг бол бид нар дэмжээд явуулах ёстой. Өнөөдөр энэ Биеийн тамир, спортын тухай хууль бол өнөөдөр Монгол Улсын хүмүүс, хүн ард иргэдийн эрүүл мэндийн асуудал, зан чанарын төлөвийн асуудал, аливаа даваа нугачааг давах чадвартай энэ гар утасны хэрэглээ, энэ өнөөдөр нийгмийн соёлыг засах хамгийн гол хууль гэж ингэж харж байгаа. Тийм учраас Байнгын хорооны гишүүдийгээ бас саналаа дэмжиж өгнө гэж итгэж байна.

Санал хураалт.

Миний төхөөрөмж сая ажилласангүй. Тийм учраас саяын санал хураалтыг хүчингүй болгоод дахин санал

хураалт явуулж өгнө үү гэсэн саналыг гаргаж байна. Саяын санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Баярлалаа. Тэгвэл Биеийн тамир, спортын тухай хуулийг хэлэлцэх эсэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Аубакир гишүүн үг хэлье.

Т.Аубакир: Би сая дэмжиж санал өгсөн боловч аппарат ажилласангүй. Дахиж санал хураалт явуулж өгнө үү.

Б.Баярсайхан: Аубакир гишүүний гаргасан саналыг дэмжиж, саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн санал хураалтаар гишүүд саналаа өгнө үү.

Хуулийн төслийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Биеийн тамир, спортын тухай хуулийг нийт гишүүдийн 58,3 хувь дэмжсэн тул хуулийн төслүүдийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Аубакир гишүүн танилцуулна.

12.18 цаг

Ингээд дараагийнхаа хэлэлцэх асуудалд оръё.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлэг явуулъя.

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

Ч.Ундрам: Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2023 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих

тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэхийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны 2023 оны 06 дугаар сарын 22-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл ажлыг хангах санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг миний бие ахалж, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Адыасүрэн, Анужсин, Аубакир, Батиугар, Дамдинням, Жаргалмаа, Г.Мөнхцэцэг нар орж ажиллалаа. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн тусалцаа үзүүлэх үүрэг бүхий ажлын дэд хэсгийг Соёлын сайд Номин ахалж, бүрэлдэхүүнд Соёлын яам, Соёлын бүтээлч үйлдвэрлэл, соёл судлалын төлөөлөл, гар урлал, дизайн урлагийн төлөөлөл, дүрслэх урлагийн төлөөлөл, утга зохиол, ном хэвлэлийн төлөөлөл, дуу хөгжим, тайзны урлагийн төлөөлөл, дүрслэх урлагийн уран бүтээлчдийн нэгтгэсэн хамтын удирдлагын байгууллагын төлөөлөл, гэрэл зураг дүрслэлийн урлагийн төлөөлөл, маркетинг, зар сурталчилгааны төлөөлөл, дижитал контент, тоглоом хөгжүүлэлтийн төлөөлөл, кино, дуу дүрсний урлагийн төлөөлөл, хувцас загварын төлөөлөл, бүтээл түгээгчдийн төлөөлөл, хэвлэл мэдээллийн төлөөлөл, урлаг соёлын эвент менежментийн төлөөлөл, оюуны өмчийн хуульчдын төлөөлөл, ая зохиогч, продюсер, дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн төлөөлөл орж ажилласан бөгөөд ажлын хэсэг 1 удаа, ажлын дэд хэсэг 2 удаа хуралдсан.

Ажлын хэсэг хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн нийтлэг шаардлагын дагуу төслийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр холбогдох бусад хууль

тогтоомжтой нийцүүлэн үг, хэллэгийг жигдэлж, Улсын Их Хурлын гишүүд болон дэд ажлын хэсэг, Ди парламентад ирүүлсэн саналыг тусгасан болно.

Ажлын хэсгээс хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй 24, найруулгын 1 багц санал, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан 23 зарчмын зөрөөтэй саналын томъёолол бэлтгэснээс дараах зарчмын гол өөрчлөлтийг тусгалаа. Тухайлбал, Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох насыг Иргэний улсын бүртгэлийн тухай хуультай нийцүүлж 16-18 байхаар, оюуны өмч бүтээхийг урамшуулах, хамгаалах, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн, үр шимийг нь уран бүтээлчдэд хүртээхийн тулд соёлын бүтээгдэхүүнийг арилжааны зорилгоор ашиглах, бүртгэх, хянах систем бүхий дэд бүтэц нэвтрүүлэхээр төсөлд тусгасныг бусад холбогдох хуультай нийцүүлж, боловсронгуй болгохоор соёлын бүтээлч, үйлдвэрлэл эрхлэгчийг бусдын оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байхыг үүрэг болгохоор өөрчлөлтийг хийсэн бөгөөд мөн ЗГ батлахаар 13 журам байсныг 8 болгож цөөлөхөөр санал бэлтгэж аж ажилласан болно.

Хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хүрээнд Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн 1 дүгээр зүйлд олон нийтийн оролцоо, хяналтыг сайжруулах зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий удирдах зөвлөлтэй байх агуулга бүхий хэсэг нэмэхээр, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ноогдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив гэж өөрчлөхөөр, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн

төсөлд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичигтэй холбоотой журам зөрчсөн бол зөрчлийн шийтгэл оногдуулахаар Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд гадаадын киног Монгол Улсад гаргасны ашигийн 2 хувийг Кино урлагийг дэмжих санд төвлөрүүлж байхаар саналыг тус тус гаргаж байна.

Мөн Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаахаар шийдвэрлэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан ажлын хэсгээс бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг та бүхэнд тараасан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Баярсайхан: Ундрам гишүүнд баярлалаа.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүд өнөөдөр энд хүрэлцэн ирсэн байна. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Соёлын сайд Номин ирсэн байна. Соёлын дэд сайд Баттөр, ая зохиогч, продюсер Өлзий-Ориших, М мюзик компанийн захирал Батмагнай Өмгөөллийн Төгс энд ко компанийн захирал Төгсбаяр Соёлын яамны Соёлын бүтээлч үйлдвэрлэл, инновацын хэлтсийн дарга Батхуяг, Соёлын яамны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Батцэцэг нар хүрэлцэн ирж Байнгын хорооны

хуралдаанд оролцож байна. Мөн Эконтэ компанийн захирал Тамир бас хүрэлцэн ирсэн байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Гишүүн хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан гишүүдээс хууль санаачлагчаас асуух асуулт байна уу? Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу. Алга байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу?

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Ажлын хэсэг саналтай юу.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь заалтын “эрхлэх хувь” гэснийг “эрхэлж байгаа” гэж, 4.1.8 дахь заалтын “байрилын хувьд” гэсний дараа “болон” гэж нэмж, 4.1.9 дэх заалтын “зэргийг кластержуулах замаар дэмжсэн” гэснийг “зэргээр энэ хуулийн 4.1.8-д заасан кластер байгуулсан” гэж, “төвлөрлийн түвшин бусад бүс нутгаас өндөр байгаа” гэснийг “төвлөрсөн” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ундрэм, Адьяасүрэн, Анужин, Аубакир, Батишугар, Дамдинням, Жаргалмаа, Мөнхцэцэг. Цаашид “ажлын хэсэг” гэх. Санал хураалт.

54,5 хувиар дэмжигдлээ.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6 дахь заалтын “хөдөлмөр эрхлэлт,” гэснийг “6.1.3.” дахь заалт руу шилжүүлэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

63,6 хувиар дэмжигдлээ.

Төслийн 5 дугаар зүйлтэй холбоотой асуулт асуух, санал хэлэх гишүүн байна уу? Байхгүй.

Ганхуяг гишүүн горимын санал гаргая гэж байна.

Х.Ганхуяг: Ер нь дарга аа, юу яая, гялалзуулъя. Энэ нөгөө 2-оос бас дахиад Байнгын хорооны хуралтай байхгүй юу. Тэгэхээр цөмөөрөө угаасаа энэ хуулиа уншихсан юм чинь энэ зарчмын зөрөөтэй саналууд дээрээ илээр буюу гараар саналаа хураагаад явчихъя, тэгэх үү.

Б.Баярсайхан: Ганхуяг гишүүнээс гаргасан горимын саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хурааа.

54,5 хувиар дэмжигдэж байна.

Ингээд Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “түгээх үйл явцыг” гэснийг “түгээхтэй холбоотой үйл ажиллагааг” гэж, 7.4 дэх хэсгийг 7.5 дахь хэсэг болгон өөрчилж, 7.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 7.2-т заасан” гэснийг болон “7.5” дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

7-гоос 7 хүн дэмжлээ. 68,8 хувиар дэмжигдлээ.

Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн “агуулгыг дэмжих” гэснийг “агуулгын дэмжлэг” гэж, 8.3 дахь хэсгийн “эээмшүүлнэ” гэснийг “олгоно” гэж, 8.4 дэх хэсгийн “15-18 хүртэлх” гэснийг “16-18” гэж, 8.5 дахь хэсгийн “заасныг хэрэгжүүлж,” гэснийг “заасан үндэсний соёлын агуулгыг дэмжих болон” гэж,

“хязгаарлалт тавих, шаардлага тавихтай холбоотой журам” гэснийг “хязгаарлалт тогтоохтой холбоотой журам,” гэж өөрчилж, 8.3 дахь хэсгийн “энэ хуулийн 8.4-т заасан” гэснийг болон “8.2” дахь хэсгийг тус тус хасаж, 8.5 дахь хэсгийн “8.3” гэсний өмнө “8.1,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

7 гишүүнээс, 11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.3 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 9.8 дахь хэсгийн “Мэргэжлийн” гэсний дараа “болон техникийн” гэж нэмж, 9.4 дэх хэсгийн “мэргэшүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэхэд” гэснийг “мэргэшүүлэхэд” гэж, 9.6.2 дахь заалтын “Боловсролын тухай хуульд” гэснийг “боловсролын хууль тогтоомжид” гэж, 9.6.3 дахь заалтын “шатны” гэснийг “түвшний” гэж, 9.6.4 дэх заалтын “чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж байгаа” гэснийг “чиглэлийн сургалтын үйл ажиллагаа эрхэлж байгаа” гэж, 9.8 дахь хэсгийн “9.6-д” гэснийг “9.6.1, 9.6.4-т” гэж, “9.7-т” гэснийг “9.7.1, 9.7.2-т” гэж өөрчилж, 9.6.1 дэх заалтын “хөнгөлөлттэй” гэснийг болон “холбогдох журмыг батлах” гэснийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтын “тэргүүн ээлжид” гэснийг, 11.1.3 дахь заалтын “үндэсний болон олон улсын” гэснийг хасаж, 11.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж нэмж, 11.3 дахь хэсгийн “11.2” гэснийг “10.1” гэж

өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, цаашид тухай бүр нийцүүлэн өөрчилж, 12.4 дэх хэсгийн “дэмжлэг” гэсний өмнө “дэд бүтэц, систем нэвтрүүлэхэд” гэж, 12.6 дахь хэсгийн “удирдлагын” гэсний дараа “байгууллага” гэж нэмж, “систем хөгжүүлэлтийг” гэснийг “системийг” гэж, “хийх” гэснийг “хөгжүүлэх” гэж өөрчилж, доор дурдсан агуулгатай “12.7” дахь хэсэг нэмэх:

“12.7.Энэ хуулийн 12.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хамтын удирдлагын байгууллага нь Оюуны өмчийн тухай хуулийн 17.2-т заасан дагнан байгуулсан объектын төрлийн зохиогчийн эрхийг эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн олонхийг нэгтгэсэн байна.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 12 дугаар зүйлийн 12.8 дахь хэсгийн “12.3-12.6” гэснийг “12.3, 12.5, 12.6” гэж, “12.9 дэх хэсгийн “бүтээгдэхүүний зохиогч, зохиогчийн эрх эзэмшигч болон түүнд хамаарах эрх эзэмшигчийн чиглэлээр” гэснийг “асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллага нь” гэж өөрчилж, мөн хэсгийн “төрөөс” гэснийг, 12.4 дэх хэсгийн “тодорхой” гэснийг болон 12.10 дахь хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 13 дугаар зүйлийн гарчгийн “дэмжлэг” гэсний өмнө “болон бусад” гэж нэмж, 13.1.1 дэх заалтын “төсвийн дэмжлэг үзүүлэх” гэснийг “төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх”

гэж, 13.1.4 дэх заалтын “гаргах” гэснийг “санхүүжүүлэх” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “14.1” гэсний дараа “, 14.5” гэж, 14.5 дахь хэсгийн “олон” гэсний дараа “улсын” гэж нэмж, 14.5 дахь хэсгийн “Холбогдох журмыг Засгийн газар батална.” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 15 дугаар зүйлийн зүйлийн 15.1 дэх хэсгийн “хамтын удирдлагын байгууллага,” гэсний дараа “эсхүл” гэж, 15.10 дахь хэсгийн “Соёлын” гэсний өмнө “холбогдох төрийн байгууллага” гэж нэмж, 15.2 дахь хэсгийн “төр, нийтийн” гэснийг “төрийн” гэж, “холбогдох бүртгэлийг” гэснийг “бүртгэл” гэж, 15.6 дахь хэсгийн “таатай үнээр” гэснийг “хөнгөлөлттэй үнэ” гэж, 15.10 дахь хэсгийн “авах” гэснийг “өгөх” гэж өөрчилж, 15.8 дахь хэсгийн “, хөтөлбөрийг” гэснийг болон “15.9” дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 16.1 дэх хэсгийн “боловсруулан,” гэснийг, 16.4 дэх хэсгийн “Төрөөс” гэснийг хасаж, 16.3 дахь хэсгийн “Төр өөрийн мэдэлд байгаа” гэснийг “Төрийн эзэмшлийн” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

14. Төслийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсгийн “кластерын” гэсний ард “төлөвлөлт, эсхүл” гэж нэмж, 17.6 дахь хэсгийн “олгохдоо” гэснийг “хүссэн этгээд нь” гэж, 17.8 дахь хэсгийн “төвлөрлийн түвшинг” гэснийг “төвлөрлийг” гэж өөрчилж, 17.8 дахь

хэсгийн “менежмент хийх мэргэжлийн багийн зардлыг” гэснийг болон 17.9 дэх хэсгийг тус тус хасаж, 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн соёлын бүтээлч үйлдвэрлэлийн парк, цогцолбор байгуулах саналыг техник, эдийн засгийн үндэслэлийн хамт Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11 гишүүнээс 7 гишүүн дэмжлээ.

Төслийн 18 дээр санал байна уу? Байхгүй байна.

15. Төслийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг “, эсхүл” гэж, “мэдээлэлд үндэслэн бүртгэх,” гэснийг “болон шаардлагатай бусад мэдээлэл, журамд үндэслэн бүртгэх,” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

16. Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “үндсэн” гэснийг хасаж, доор дурдсан агуулгатай “20.2.7” дахь заалт нэмэх:

“20.2.7.оюуны өмчийн эрхийг зөрчихгүй байх.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

17. Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.8 дахь заалтын “чадавхыг” гэснийг “мэдлэгийг” гэж өөрчилж, 21.1.9 дэх заалтын “улс орны хөгжлийн онцлогт нийцүүлэн” гэснийг, 21.1.10 дахь заалтын “менежмент хийх” гэснийг болон “21.1.11” дэх заалтыг хасаж, “21.1.2” дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“21.1.2.энэ хуульд заасны дагуу соёлын бүтээлч үйлдвэрлэлд

дэмжлэг үзүүлэх;" Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

22 дээр асуулт, санал байхгүй, тийм ээ. Байна уу.

18. Төслийн 23 дугаар зүйлийн 23.1.4 дэх заалтын "холбогдох хуулийн хэрэгжилтийг хангах" гэснийг "холбогдох хуулийн" гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

19. Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтын "үйлдвэрлэлийн" гэснийг "үйлдвэрлэлийг дэмжих" гэж өөрчилж, 24.1.3. дахь заалтын "соёлын" гэсний өмнө "энэ хуулийн 4.1-д заасан" гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжсэн байна.

20. Төслийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтын "эдийн" гэсний дараа "засгийн" гэж нэмж, "хөтөлбөр, төсөв" гэснийг "төлөвлөгөө" гэж, 25.1.3 дахь заалтын "ашиглуулах" гэснийг "эзэмшүүлэх" гэж өөрчилж, "талаарх" гэснийг болон 25.1.4 дэх заалтын "нутаг дэвсгэрт" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжиж байна.

21. Төслийн 26 дугаар зүйлийн 26.1.1 дэх заалтын "эдийн" гэсний дараа "засгийн" гэж нэмж, "талаарх" гэснийг болон "төсөв" гэснийг хасаж, 26.1.2 дахь заалтын "нутаг дэвсгэрийн" гэснийг "орон нутгийн" гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Төслийн 27 дугаар зүйлийн 27.1.1 дэх заалтын "үйлдвэрлэлийн" гэснийг

"үйлдвэрлэлийг дэмжих" гэж өөрчилж, 27.1.3. дахь заалтын "соёлын" гэсний өмнө "энэ хуулийн 4.1-д заасан" гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

23. Төслийн 28 дугаар зүйлийн гарчгийн "үйл ажиллагаан дахь тайлагнал" гэснийг, "үйл ажиллагааны" гэж, 28.4 дэх хэсгийн "авсан" гэснийг "олгосон" гэж өөрчилж, 28.3 дахь хэсгийн "мэдээллийн" гэсний өмнө "бүртгэл," гэж нэмж, "энэ хууль болон" гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

29 дээр санал байна уу? Байхгүй байна.

24. Төслийн 30 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Найруулгын санал танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн "эдгээртэй" гэснийг "эдгээр хуультай" гэж, 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн "арга хэмжээ, журмыг" гэснийг "арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг" гэж, 9.6.1 дэх заалтын "чиглэлийн" гэснийг "чиглэлээр" гэж, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалтын "хөрөнгө оруулалтад" гэснийг "хөрөнгө оруулалт" гэж, 12.2 дахь хэсгийн "бүртгэгдсэн бүтээл" гэснийг "бүтээлийг" гэж, 12.8 дахь хэсгийн "этгээд" гэснийг "этгээдэд" гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн "эдлүүлнэ" гэснийг "үзүүлнэ" гэж, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн "хориглоогүй буюу" гэснийг "хориглоогүй," гэж, 15.4 дэх хэсгийн "загварыг" гэснийг "загвараар" гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн "хүн ам" гэснийг "иргэдэд" гэж, 22 дугаар

зүйлийн 22.2 дахь хэсгийн “, зэрэг арга хэмжээнд” гэснийг “бусад үйл ажиллагаанд” гэж өөрчилж, 3 дугаар зүйлийн “гадна” гэснийг, 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтын “болон” гэснийг, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “болон” гэснийг, 22 дугаар зүйлийн 22.1.6 дахь заалтын “системтэйгээр” гэснийг хасаж, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Засгийн” гэсний дараа “газрын” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжлээ.

2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томьёолоор санал хураалт явуулья.

1.Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийн “системийг ашиглах” гэснийг “системийн” гэж өөрчилж, “системийн хөгжүүлэлт хийх” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

2. Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар” гэснийг “3, 18 дугаар” гэж өөрчилж, “хэсэг” гэсний дараа “, заалт гэж нэмж, доор дурдсан агуулгатай “18.6” дахь хэсэг нэмэх:

“18.6.Төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн байгууллага нь удирдлага, урын сангийн бодлогын болон засаглалын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн ажиллах журмыг Засгийн газар

батална.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Төслийн 2 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

3. Төслийн 4 дүгээр зүйлийн “12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн “чиглэл” гэсний өмнө “тодорхой” гэж,” гэснийг хасаж, “33 дугаар зүйлийн” гэсний өмнө “32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийн “шилдэг бүтээл” гэснийг “шилдэг уран бүтээлч болон шилдэг бүтээл” гэж” нэмж, мөн зүйлийн “50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсгийн “дурсгал” гэснийг “түүх соёлын дурсгалт зүйлээр” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

4. Төслийн 5 дугаар зүйлд “9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтын “уран сайхны” гэснийг” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Аубакир гишүүн дэмжихгүй байгаа юм уу, саяын саналыг.

11-ээс 7.

Төслийн 6 дугаар зүйлд “26 дугаар зүйлийн 26.3,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 гишүүн дэмжжээ.

Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн 3 дугаар зүйлийн “хассугай” гэсний өмнө “тус тус” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Тийм, хассугай гэсэн төсөл дээр байсан байна. Үүнийг тус тус гэж нэмэх.

11-ээс 7.

4. ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “15.1.15” гэснийг “15.1.16” гэж өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

15.1.16.соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, соёлын өвийг хамгаалах зорилгоор албан татвар ногдох орлогын 5 хувиас хэтрэхгүйгээр өгсөн хандив. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

2. Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “22.5.11, 22.5.12” гэснийг “22.5.20” гэж өөрчилж, “хөнгөлнө” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

5. Барилгын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 11.1.8 дахь заалтын “нүүр” гэсний дараа “болон” гэж нэмж, “талд үндэсний агуулга, хэлбэр, дүр төрхийг илэрхийлсэн үзэл баримтлал,” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

6. Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “16.1.17” гэснийг “16.1.19” гэж, 2 дугаар зүйлийн “заалтын” гэснийг “хэсгийн” гэж, “16.1.16” гэснийг

“16.1.18” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

7. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 болон 2 дугаар зүйлийн “38.1.21” гэснийг “38.1.23” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

8. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “Соёл, урлагийг дэмжих сан” гэснийг “Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан” гэж өөрчилж, 13.3.5 дахь заалтын “арга хэмжээнд оролцуулах,” гэснийг, 13.3.7 дахь заалтын “онцгой” гэснийг, “13.4” дэх хэсгийг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

9. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн 9.14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 3 дахь хэсэг нэмэх:

“3.Соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичиг олгох, хянах, хэрэглэгчийн статистик мэдээлэлд үндэслэн хязгаарлалт тогтоох, шаардлага тавихтай холбоотой журмыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуугаас гурван зуун нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянгаас дөрвөн

мянган нэгж хүртэлх хэмжээний төгрөгөөр торгоно.”

Санал гаргасан ажлын хэсэг. Хүнийг гэж явах юм уу, тийм ээ. Санал хураалт.

Иргэнийг гэх юм уу. Иргэнийг гэх юм биш үү? Энэ хүнийг гэж байгаа чинь нэг тийм найруулгын хувьд. Нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гэнэ ээ. Зөрчлийн хуульдаа ийм байгаа юм уу, Батцэцэг ээ.

Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 9.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

10. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “6.10 дугаар зүйлийн” гэснийг “1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.46 дахь заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

11. Кино урлагийг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Кино урлагийг дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “үүсвэрээс” гэсний дараа “болон гадаадын киног Монгол Улсад гаргасны ашгийн 2 хувиас” гэж

нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Төслийн 2 дугаар зүйлийн “байгууллагатай” гэсний өмнө “төв” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийг хуулийн төсөл санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийн гарчгийн “, өөрчлөлт” гэснийг хасаж, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

2 дугаар зүйл. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2 дахь хэсгийн “34.27” гэсний дараа “, 37.28” гэж нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

14. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

1. Төслийг хуулийн төсөл санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

15. Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Төслийн гарчгийн “ӨӨРЧЛӨЛТ” гэсний өмнө “НЭМЭЛТ,” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7.

Төслийн 2 дугаар зүйлийг 1 дүгээр зүйл болгон өөрчилж, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтын “аргачлалыг” гэсний дараа “соёлын болон” гэж нэмсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

11-ээс 7 дэмжлээ.

Энэхүү хуульд санал гаргаагүй тухай хуулийг танилцуулъя. 1 дүгээрт, Зар сурталчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Номын сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай мөн Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиуд энэ хуульд тусгаадаагүй болно. Саналын томъёолол гараагүй болно гэдгийг албан ёсоор мэдэгдэж байна.

Ингээд гишүүд ээ, одоохон шүү, түр хүлээж байгаарай. Ганицхан санал хураалт үлдлээ.

Цаглавар батална, Байнгын хороогоор.

Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийг боловсруулах дэд ажлын хэсэгт Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн төлөөлөл, МУГЖ, нийтийн дууны холбооны дарга

Далантай, Монголын хөгжмийн зохиолч Хүрэлбаатар, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн удирдах зөвлөлийн тэргүүлэгч гишүүн Анхбаяр, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн төлөөлөл МУГЖ Ариунаа, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн төлөөлөл МУСТА, продюсер Болд, Дуу бичлэг бүтээгчдийн үндэсний төвийн төлөөлөл, Хууль зүйн ухааны доктор, профессор Батзориг нар бас энэ дэд ажлын хэсэгт бас албан ёсоор ажилласан, санал онолоо энэ хуульд тусгасан гэдгийг бас өнөөдөр Байнгын хороон дээр албан ёсоор бас зарлаж байна. Энэ дэд ажлын хэсэгт ажилласан хүмүүстээ болон энэ ажлын хэсгийг ахалж байгаа Ундрэм гишүүндээ бас талархал илэрхийлж байна.

Ингээд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд ажлын хэсгийг ахалж байгаа Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрэм танилцуулна.

12.53 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

Хаврын чуулганы 4 дүгээр сард Байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10.5-д ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүрийн захирамжаар батална гэж, 10.6-д энэ хуулийн 10.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж мөрдүүлнэ гэж заасан.

Байнгын хорооны тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Байнгын хорооны тогтоолын төсөлтэй

холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байна уу? Байхгүй байна.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сард Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Ингээд 11-ээс 7 гишүүн дэмжсэн тул цаглаварыг баталлаа. Баярлалаа.

12.55 цаг.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх 5 дахь асуудалдаа оръё.

Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын 23 дахь илтгэлийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар ХЭҮК-ын дарга Сүнжид танилцуулна. Ингээд Сүнжид даргын танилцуулгыг сонсъё.

Өнөөдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хэлэлцэх асуудлын хүрээнд Монгол Улс дахь Хүний эрх эрх чөлөөний байдлын 23 дахь илтгэлийн боловсролын салбар дахь хүний эрхийн нөхцөл байдлын талаар танилцуулах байгаа.

Ингээд ХЭҮК-ын дарга Сүнжид танилцуулна.

Д.Сүнжид: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. 23 дахь ХЭҮК-ын илтгэлийн 1 сэдэв, 2 дахь сэдэв нь боловсролын салбар дахь хүний эрхийн асуудал гэдэг ийм сэдвийн хүрээнд дүн

шинжилгээ хийж бэлтгэсэн. Энэ хүрээнд БШУЯ-ны сайдтай хамтарч ХЭҮК-оос СӨБ, ЕБС, мэргэжлийн сургалтын төв, дээд боловсролын байгууллагад судалгаа хийлгэсэн. Энэ хийсэн судалгааны үр дүнд үндэслээд мөн Комисст ирсэн гомдол мэдээлэл, хийсэн хянан шалгалтыг үндэслээд, дүгнэлтийг үндэслээд энэхүү сэдвийг боловсруулсан.

Боловсролын салбарын статистик мэдээлэл үзэхээр нийтдээ Монгол Улсын хүн амын 3-ны 1 нь суралцаж байна 1 сая 229597 гэдэг ийм тоо байна. Тэгээд энэ судалгааг гүйцэтгэхдээ 4 А гээд зарчмаар буюу НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас бэлтгэсэн хүний эрхийн эдийн засаг, нийгэм, соёлын байнгын хорооноос өгсөн зөвлөмжийн дагуу хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, нийцэн зохицсон байх гээд энэ зарчмыг баримталж ингэж гүйцэтгэсэн. Ингээд 4 дэд сэдэв байгаа.

СӨБ дахь боловсролын байгууллага дахь хүний эрхийн зарим асуудал гээд энд бол юун түрүүн цэцэрлэгийн орчин нөхцөлийн асуудал, хүртээмжийг авч үзэх ёстой байна гээд. Улаанбаатар хот тэгээд 5 аймгийг түүвэрлэж, энэ судалгаанд хамруулж авч үзсэн. Ингэхэд цэцэрлэгийн барилга зарим нь Улаанбаатар хотоос бусад газар орон нутгууд хуучин 1970, 1960 онд баригдсан ийм барилгууд байна. Ангийн дүүргэлтийн асуудал яригдаж байна. Тэгш хамран сургалтын асуудал яригдаж байна. Малчдын хүүхдүүд, газар нутгийн алслагдмал оршин сууж байгаа байдлаасаа хамаараад СӨБ-д хамрагдаж байгаа байдлыг бас анхаарах ёстой байна гэдэг асуудал хөндөгдсөн.

Мөн юуны бүлэг дүүргэлтийн хувьд харилцан адилгүй байна. Зарим бүлгүүд бол тооноосоо их хүүхэд авдаг. Тийм учраас хамт харилцан хүүхэдтэйгээ ажиллах, халамжлах, хөгжих боломжийг бүрдүүлэх энэ

асуудлын бол цаашидаа ч гэсэн анхаарах хэрэгтэй байна.

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанарын асуудал, шим тэжээлийн тооцоо үүнийг бол бас анхаарах ёстой. Энэ 7000 хүүхэд шим тэжээлээс дутагдалтай гэдэг ийм дүгнэлтийг бас эрүүл мэндийн байгууллагаас гаргасан байна. Тийм учраас цэцэрлэгийн хүүхдийн хоолны чанар, шим тэжээлийн байдал бол цаашидаа зайлигүй анхаарч таарах нь.

Сургалтын нөөц хэрэглэгдэхүүний хангамж хүрэлцээний тухайд. Ер нь дээшилсэн байна. 2023 оны Боловсролын багц хуулийн хүрээнд санхүүжилтийн асуудал, сургалтын хэрэглэгдэхүүн, багш, ажилтны цалингийн асуудал, ер нь боловсролын салбарт оруулж байгаа хөрөнгө оруулалт бол эрс дээшилсэн. Тэгээд энэ дутагдаад байгаа энэ хүрээлэгдэхүүн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шийдэхээр төлөвлөсөн, шийдээд явж байгаа ийм сайн дүр зураг байгаа боловч цаашидаа ч гэсэндээ энэ СӨБ-ын түвшинд нөөц хэрэглэгдэхүүний тухайд тэр шаардлага хэрэгцээг нь хангаж шаардлагатай байна.

Юуны СӨБ-ын байгууллага дээр энэ хийсэн судалгааны үр дүнд хэлсэн нэг асуудал юу гэхээр аюулгүй орчин бүрдүүлэх тал дээр бол манай багш, ажилтнууд төдийлөн анхаарлаа хандуулж хэвшээгүй байна. Нэг яг энд хүүхдүүд байрладаг өрөөнд шагай, батарей ингээд төмөр, ингээд юу аюулгүй байдалд нь эрсдэлтэй байж болзошгүй принтер, ийм залгуур энэ тэр яг зэрэгцээд байж байдаг юм байна. Үүндээ бол төдийлөн анхаарал хандуулдаггүй юм байна гээд. Тэгэхээр энэ СӨБ дээр үүнийг бас анхаарах ёстой гэдгийг нь хэлсэн байна.

Багш, ажилтны хөдөлмөрлөх эрхийн хувьд цалин нэмэгдсэн боловч 4 төрлийн багш бол дутагдалтай хэвээрээ явсаар байна. Ялангуяа хөдөө орон

нутагт бол нэг 2 багш бол 2 мэргэжлийн багш бол байнга ингээд дутагдалтай, нөхөгдөхгүй ийм хэвээрээ явж байгаа. Тэгээд бусад багш нар энэ ажлыг нь хавсран гүйцэтгэдэг ийм зурагтай.

Сургалт сургах, хөгжих тал дээр бол СӨБ-ын салбар дахь багш, ажилтнууд хувь хүний хөгжлийн чиглэлийн, манлайллын чиглэлийн, боловсролын чиглэлийн сургалтад бол бүтэн хамрагдаж чаддаг. Харин хүний эрхийн мэдрэмжтэй байх гэдэг юм уу тэр чиглэлийн сургалтыг бол бид нар ерөөсөө хамрагдаж байгаагүй ээ гэдэг ийм хариултыг өгсөн байгаа учраас цаашидаа үүнийг бас энэ тал дээр багш, ажилтнуудыг сургах, ингээд давтан сур сургалтыг бол байнга хийдэг. Тэр хүрээндээ бас сэдвийг нь шинэчлэх, баяжуулах асуудлыг бас хөндөж тавьсан.

Цэцэрлэгийн хүүхдийн хамгааллын, хүүхэд хамгааллын бодлогыг бол эцэг эхчүүд, багш нар бүгдээрээ мэдэж байна. Гэхдээ яг бодлогын хүрээнд төлөвлөгөө төсөв санхүүжилт хийдэг. Тэр нь эргэх холбоотой асуудал шийдэж чаддаггүй гэдэг дээр эцэг эхчүүдээс эргэлзсэн ийм дүн, дүгнэлтийг өгч байгаа юм л даа. Мэддэг ээ, хүүхэд хамгааллын бодлого байдаг. Энэ хүүхэд хамгааллын багийг хэн ахалдаг гэдгийг нь бид нар бол мэдэж байгаа гэж байгаа боловч юу хийдэг вэ? Эсвэл эрсдэлтэй нөхцөлд үзсэн хүүхдийг чинь эрх зөрчигдлөө гэж үзвэл яах вэ? Хамтарсан ямар арга хэмжээ авдаг вэ, хэнд гомдол гаргадаг вэ, эргэж шийдэж байсан уу гэхээр түүн дээр бол хариулт нь 3 хүн тутмын 1 нь л эерэг хариулт өгч байгаа. 3 хүний 2 нь шийдэгдээгүй ээ, шийдэхээ мэдээгүй ээ гэдэг ийм байдалтайгаар хариулж байна.

Ерөнхий боловсролын салбар дахь хүний эрхийн асуудал тэр сургалтын байгууллагын орчин хөндөгдөж байгаа юм. Тэгээд энэ хүртээмжийн асуудал ер нь 4 ерөнхий боловсрол, мэргэжлийн

сургалтын боловсролын байгууллага, СӨБ-ын байгууллагууд дүгнэлтэд хөндөж байгаа жигд биш байна. Ялангуяа энэ Улаанбаатар хотын хэмжээнд сургуулийн анги дүүргэлтийн л дандаа хэмжээнээсээ стандартын дагуу байх хэмжээнээс хүүхдийн тооноосоо олон байгаа. Тэр хэрээрээ тэгээд эргээд нөгөө хүүхдийн боловсрох, сурч боловсрох, багшийн ажиллах нөхцөл гэдэг энэ асуудал давхар хөндөгдөж явдаг.

Лабораторийн нөөц бүрэлдэхүүн хангамж бол эрс сайжирч байгаа хэдий ч гэсэндээ нөүтбүүк, интернэт, дадлага ажилд хэрэгтэй ийм шаардлагатай бүтээгдэхүүн бол бид нарт бас хангалттай биш хэвээрээ байна гэж байгаа юм.

Сурах бичгийн агуулгад хүний эрх агуулга туссан байдлыг үзэхээр энэ нь бол хангалтгүй байна. Ялангуяа дунд анги, ахлах ангид бид нар тун хүний эрхийн мэдрэмж муутай, зураг, дүрслэл кэйс, жишээ зүйрлэл ингээж хэрэглэдэг юм байна. Тийм учраас хөтөлбөр болоод сурах бичгийн агуулгаа дахин энэ үүднээс шалгуураа шинэчлэх шаардлагатай байна гэдэг дүгнэлтийг хийсэн.

Сургуулийн ЕБС-ийн боловсролд нэг маш ноцтой энд анхаарахгүй бол болохгүй ээ гэж дүгнэсэн асуудал ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтийн асуудал байгаа. Энэ дээр 10 хүүхэд тутмын 3 нь ямар нэг байдлаар бид нар хэн нэгнээс ялгаварлал авч байгаа ялангуяа үе тэнгийнхэн багшаас бас ирж байгаа гэдгийг бол хэлнэ. Тэгээд бие махбодын хувьд ялгаварлаж байна, бие махбодод халдаж байна гэдэг асуудал ярихын зэрэгцээгээр юунаас нь өөрийнх нь нь байгаа төрөх, эсвэл амьжиргааны түвшин, ар гэрийнх нь байдлын улмаас бол бид нар ялгаварлалд өртөж байна гэдгээ бас хэлээд байгаа.

Тэгээд үүний эсрэг 2020 онд БШУЯ-наас сайдаас чиглэл өгсөн боловч

яг үүний хэрэгжилт бүрэн дүүрэн бол биш дүрэм журам бол хангалттай биш. Энэ чиглэлийн хүрээнд илүү сургуулийн захирлууд, нийгмийн ажилтнууд хэрвээ сайн ойлгосон бол тэр хүрээндээ хариу арга хэмжээ авах байдалтай, хүүхэд хамгааллын бодлогын хүрээндээ тусгасан бол хариу арга хэмжээ авах байдалтай яг жигд бус нэг ийм дүр зураг байгаа бөгөөд ЕБС дээр бол энэ асуудалд анхаарал тавьж, үүний эсрэг үр дүнтэй аж хийх ажлыг хийх ёстой байна гэж ингээж дүгнэсэн.

Тэгш хамран сургалтын асуудлыг бүх энэ сургалтын байгууллагад бас авч үзэх шаардлагатай. Хэдийгээр энэ Боловсролын багц хууль нь 2023 онд маш тодорхой заалтыг заасан. Сургалт, туслах багш, нөөц хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж тэгээд энэ шаардлагатай ямар хэрэгсэл байгаа юм, түүнийг нь ханга гэдгийг бол 2023 оны Боловсролын багц хуульд заасан. Одоо хэрэгжүүлэх тухай асуудлыг цаашидаа бол анхаарах ёстой. Энэ хэрэгжүүлэхийн тулд 1 дүгээрт нь, хүний нөөц хэрэгтэй 2 дугаарт нь, санхүүгийн боломж хэрэгтэй, 3-т нь, зохион байгуулалт, удирдлага бол бүгд жигд байх ийм шаардлагатай юм байна лээ. Тэгэхээр цаашидаа үүнийг бол сая анхаарч жигд хэрэгжүүлэх нь зүйтэй гэж дүгнэсэн.

Өдөр өнжүүлэх төвийн үйлчилгээ хэдийгээр ингээд нийт улсын хэмжээнд 830 орчим Өдөр өнжүүлэх төв ажиллаж байгаа боловч 2022 оны Боловсролын тухай хуульд байсан заалтыг авсны улмаас хаана харьяалагдах нь тодорхойгүй, хаанаас зөвшөөрөл авах нь тодорхойгүй байдалтай, ямар шалгуураар энэ өдөр өнжүүлэх төвийг байгуулах вэ, тэнд ямар хяналт тавигдах вэ гэдэг нь тодорхойгүй байдалтай үлдчихсэн байгаа. Бас хуулийн хийдэл гэж үзэж байна. Тиймээс үүнийг бол зайлшгүй зохицуулах шаардлагатай.

2021 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын өдөр өнжүүлэх төвд

тавигдах ийм журамласан байсан. Тэгэхдээ 2002 оныхоо хуулийг дагаад энэ нь бол хүчингүй болчихсон юм байна.

Хувийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд бол хяналтыг байнга тавьж байх ёстой. Нөгөө ялангуяа төрийн захиргааны асуудал хариуцсан боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас үүнийг жигд хэрэгжүүлэх нь зүйтэй байна. Хуульд тодорхой заалтууд орсон. Тэгэхдээ хяналтыг хэрэгжүүлэхдээ өдөр тутамдаа бол түүн дээр хүүхдийн эрхийн үүднээс энэ хяналтыг хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэж дүгнэсэн.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагууд энд бол хамгийн бага хувь эзэлж байгаа энэ 30 гаруй мянган хүүхдийн асуудал яригдаж байна. Тэгээд юун түрүүн яригддаг асуудал нь энэ дээр сургалтын орчин нөхцөл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж яригддаг юм байна лээ. Дадлага хийдэг ээ, эд нар маань.

Тэгэхээр энэ дадлага хийх бүрэн тийм боломж, тоног төхөөрөмж бол хангалттай байдаггүй ээ гэдгийг бол бүгдээрээ хэлж байгаа юм. Багш, ажилтан, суралцагч бүгдээрээ. Тэгээд суралцагчдын нөгөө нэг зарим нь бол нөгөө насанд хүрээгүй, насанд хүрсэн янз бүрийн ийм холимог байдаг. Ер нь бол ахлах ангийн гэсэн үг. Ахлах ангийн л суралцагчид гэсэн үг. Энэ дээр хүүхдийн эрх хамгаалал, ялгаварлан гадуурхалтгүй байх, дарамт хүчирхийллээс ангид байх гээд адил яригдана. Нөгөө эрх нь хэвээрээ.

Багш, ажилтнууд бол бид нарын цалин эрс сайжирсан. 2023 оны хуулийг дагаад эрс сайжирсан гэж хэлж байгаа. Гэсэн хэдий ч бид нарт юу хэрэгтэй вэ гэхээр хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх, хүний эрхийн мэдрэмжтэй байх, боловсролын чиглэлээр өөрсдийгөө

дахин давтан хөгжүүлэх энэ асуудал бол бид нарт дутагдалтай байгаа гэдгээ илэрхийлсэн.

Элсэлт сургалтын салбараар төгсөгчдийн ажил эрхэлж байгаа байдлыг аваад үзэхээр ер нь энэ хөдөлмөрийн зах зээл дээр нэг дүн шинжилгээ хийгээд энэ элсэн суралцаж байгаа энэ мэргэжлээ дахин авч үзээд, тэгээд энэ тэтгэлгийг бас төгссөний дараа авах болзолтойгоор олгох нь хэр зөв бэ? Үр дүнтэй гэж үзэж байгаа юу? Үүний үр дүнтэй хэсэгтээ эргээд бас дүгнэлт хийх хэрэгтэй байна гэж үзсэн. Төгсөгчдийн бол 60 гаруй хувь нь яг энэ төгссөн чиглэлээрээ ажилладаг юм байна. Тэгээд 40 гаруй хувь нь ажиллаж чадахгүй байна. Элсэгчид бүгдээрээ бүрэн бол бас төгсөж чадахгүй байна.

Тийм учраас энэ салбар дээр илүү ямар байдлаар зохион байгуулалтыг цаашидаа сайжруулах ёстой вэ гэдгийг тэтгэлэг болон элсэлт хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан дүгнэх шаардлагатай гэж үзсэн.

Их, дээд боловсролын сургалтын байгууллагад хамгийн одоо орчин нөхцөл ярихгүй байгаа нэг салбар энэ их, дээд боловсролын сургалтын байгууллага. Энд ерөөсөө тоног төхөөрөмж, туслах хэрэгсэлтэй холбоотой нэг л асуудал тавьж байгаа нь интернэтийн дата-ны хүрэлцээ хангамжийн асуудлыг тавьж байгаа юм. Тэгээд ном, сурах бичгийн хангалтын асуудлыг тавьж байгаа юм. Бусдаар сургалтын орчин нөхцөл хангалттай гэж суралцагчид болон багш нар үнэлжээ.

Сургалтын зээл, тусламж авах асуудал дээр Боловсролын зээлийн сангаас зээл авч байгаа. Гэхдээ хагас өнчин, бүтэн өнчин хүүхдүүд, эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зөвхөн төлбөрөөс хөнгөлөх нь хангалттай биш юм байна. Тэтгэлгийг бас олгоход амьжиргаанд шаардлагатай анхдагч ийм тэтгэлгийг олгох энэ

асуудлыг бас шийдэх нь зүйтэй юм байна гэж үзсэн. Тэгэхгүй бол зөвхөн зээлийн сангаас олгосноор тэр хүмүүсийн сурах нөхцөлийг бид нар бүрэн хангаж чаддаггүй юм байна. Элссэн байлаа ч гэсэн төгссөн хувийг нь аваад үзэхээр ялангуяа энэ амьжиргааны түвшин доогуур хүүхдүүдийн хувьд энэ бол маш бага ийм дүн шинжилгээ гарч байна.

Суралцагчдын эрх, хамгаалал, ялгаварлан гадуурхал, дарамт хүчирхийллийн асуудлаар ажил эрхлэлт хөдөлмөрийн харилцаанд Хөдөлмөрийн тухай хуулиар бол зохицуулчихсан. Харин суралцагчдын хувьд ялангуяа их, дээд боловсрол эзэмших энэ сургуульд суралцагчдын хувьд энэ бэлгийн дарамт, ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг аль нэг хууль зохицуулаагүй учраас бүх багш бүх энэ сургуулиудыг дотоод журамдаа үүнээс ангид байх асуудлыг заавал тусгах ёстой байна гэдэг ийм саналыг бас хүргүүлсэн байгаа.

Тэгш хамран сургах асуудал дээд боловсрол дээр мөн адилхан ялгаагүй хамгийн бага хувьтай явдаг. Ийм асуудал байна. Тэгээд багш, ажилтнуудын хөдөлмөрлөх эрхийн хувьд харьцангуй их, дээд сургуульд ажиллаж байгаа багш, ажилтнууд бид нар цалин хөлсний асуудал нэмэх шаардлагатай гэж үздэг ээ гэсэн. Бусдаар ачааллаа тэнцвэржүүлээд ингээд болж байна гэдгээ илэрхийлдэг.

Ингээд үзэхээр СӨБ-ын байдал дээр хамгийн анхаарал татаж байгаа асуудлыг нь хоолны шим тэжээлийн асуудал гэж үзсэн. 2 дугаарт нь, тэр анги танхимын аюулгүй байдлыг байгаа түвшиндээ заавал үүнийг бол ингээд анхаарах ёстой, аюулгүй байдлыг нь хангах, зөвлөмжийг өгөх ёстой байна гэж үзсэн.

Ундны ус, ариун цэврийн байгууламжийг аль болох энэ үе шаттайгаар гаар шийдвэрлэхийг зорих ёстой байна.

Тэгээд барилгыг бас хөрөнгө оруулалтын боломжоороо шийдвэрлэх ёстой байна гэж дүгнэсэн.

ЕБС-ийн хувьд сургуулийн хүртээмж, энэ стандартын дагуу анги дүүргэлтийг байлгах боломжийг бас үе шаттайгаар шийдэх ёстой байна. Цаашидаа мөн тэгш хамран сургах энэ хуульд орсон зохицуулалтыг хэрэгжүүлэх бүх арга хэмжээг удирдлага, зохион байгуулалтын түвшинд авах нь зөв байна. Ялгаварлан гадуурхалтын эсрэг бүх түвшиндээ бодлоготой арга хэмжээг тодорхойлоод төлөвлөгөөтэй талууд хамтарч хэрэгжүүлэх ёстой байна гэж ингэж үзсэн.

Мэргэжлийн боловсролын хувьд бол дүн шинжилгээ хийгээд энэ элсэж байгаа, төгсөж байгаа байдал, мэргэжлийн чиглэл, тэгээд энэ тэтгэлгийн авч байгаа байдал энэ нөхцөл нь өөрөө хэр үр дүнтэй энэ суралцагчид тусаж байгаа вэ гэдэг дүн шинжилгээ хийж, эргэх арга хэмжээ авах ёстой байна.

Лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулах ёстой байна гэж дүгнэсэн.

Их, дээд сургуулиудын дотоод журамд энэ ялгаварлан гадуурхалтаас ангид байх, дарамт хүчирхийллээс ангид байх, бэлгийн дарамтаас ангид байх эрхийг заавал тусгах ийм зөвлөмжийг өгөөд Боловсролын зээлийн сан дээр амьжиргааны түвшинтэй уялдуулан бас тэтгэлэг олгох асуудлыг нэмж журамлах нь зүйтэй байна гэдэг ийм дүгнэлтийг хийсэн. Танилцуулж дууслаа. Асуулт байвал хариулъя.

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүн асуулт асуух байсан. Гараад явчихлаа, орж ирээд асуух байх.

Надад асуулт байна. Баярлалаа. Сүнжээ дарга аа.

Тэгээд өнөөдрийн бас боловсролын салбар дахь хүний эрхийн энэ мэдээллийг өгөхөөр Байнгын хорооны хуралдаанд ХЭҮК-ын дарга Сүнжид, ХЭҮК-ын Хүний эрхийн боловсрол хариуцсан референт Тодбулаг, ХЭҮК-ын Судалгаа, дүн шинжилгээ хариуцсан референт Золжаргал ирсэн үү? Ирсэн байна. БШУЯ-наас Энх-Амгалан сайд орж ирэх байх. Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Батжаргал хүрэлцэн ирсэн байна. Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Оюунаа, Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир нар хүрэлцэн ирсэн байна.

Ингээд ХЭҮК-оос гаргасан мэдээлэлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Мөнхцэцэг гишүүн асуух уу, тийм ээ. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Улсын Их Хурлын Хүний эрхийн дэд хорооны дарга асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр энэ Монгол Улсын хүний эрх эрх чөлөөний тайлан илтгэл энэ 23 дахь илтгэлд бол боловсролын салбарын хүний эрхийн асуудлаар бас нэлээн өргөн хүрээтэй дүгнэлтүүд гарсан байна. Үүнийг үндэслээд бас тодорхой зөвлөмжүүд Байнгын хорооноос гарч холбогдох яам болон Боловсролын ерөнхий газар хүргүүлэх байх. Тэгээд энэ хүний эрхийн зөрчил, боловсролын салбар дахь асуудлаар санаа зовсон, анхаарал татсан их олон асуудал байна. Тухайлбал Монгол Улсын жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Боловсролын багц хуулиуд зэрэгт заасан тодорхой заалтуудыг хангахгүй ийм хүний эрхийн зөрчлүүд нэлээн байна. Тухайлан хэлэх юм бол энэ ЕБС-ийн сурах бичиг дэх хүний эрхийн болон жендерийн тэгш эрхийг хангах тухай энэ агуулгууд маань маш дутуу яваад байна. Жишээлбэл Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 12.5 дахь хэсэгт ер нь ном сурах бичиг, сургалтын байгууллагын агуулга нь жендерийн тэгш эрхийг үгүйсгэсэн

агуулгатай байж болохгүй ээ гэсэн ийм заалт байдаг. Гэтэл энэ ХЭҮК-ын хийсэн энэ иргэний боловсрол, Монгол ёс зүйн боловсрол, эрүүл мэнд, нийгэм судлал гээд энэ хэд хэдэн сурах бичигт хүний эрхийн зөрчил нэлээн их байна.

Энэ дээр жендерийн ялгаатай байдлыг авсан эсвэл тухайн тэр сурах бичгийн агуулгад хадам эх, хадам эхийн талаарх харилцаа ч гэдэг юм уу яг нөгөө хүүхдийн нас бие, сэтгэл зүйн сэтгэлийн онцлогт тохироогүй ийм агуулга бүхий хүний эрхийн зөрчилтэй ийм агуулга байна гэдэг бол энэ судалгаагаар харагдаж байна.

Тэгээд дээр нь энэ сурах бичгийн агуулга нь мөн аль нэг үзэл бодлыг тулган хүлээлгэсэн эсвэл энэ олон соёл, олон шашин, үнэт зүйлийн зөвхөн нэгийг сонгон авч оруулсан жишээтэй. Жишээлбэл энэ домгийн хэсэгтээ домгийн шинж бүхий кэйс, философийн номууд нэг бол зөвхөн Буддын шашны сургаалыг агуулсан ч гэдэг юм уу гэх мэтээр энэ эх сурвалж болон агуулга нь хүний эрхийн олон улсын шаардлагад нийцэхгүй ийм байгаад байна.

Тэгэхээр энэ талаар энэ Боловсролын ерөнхий газар болон БШУЯ боловсролын сурах бичгийн агуулга дахь энэ шинэчлэлийг яаж хийж байгаа вэ? Энэ ХЭҮК-ын энэ хүний эрхийн энэ зөрчлүүдтэй холбогдуулан ямар, ямар ажлууд хийх вэ гэдгийг 1 дүгээрт, асууя.

2 дугаарт нь, энэ Боловсролын ерөнхий хуулийн гол заалтууд дээр нэг чухал асуудал бол энэ үе тэнгийн дээрэлхэлгүй орчинд хүний эрхийн зөрчилгүй ийм орчинд хүүхдүүд сурч боловсрох ёстой. Гэтэл энэ судалгаанаас ингээд харахаар үе тэнгийн дээрэлхэл бол маш их байна. Жишээлбэл энэ ХЭҮК-ын тайлан илтгэл ингээд харахаар ерөнхийдөө хүүхдүүдийн 14,3 хувь нь бусад хүүхдүүдийн зүгээс дээрэлхэлд өртсөн байна. Янз бүрийн нэр хоч өгөх эсвэл ялгаварлан гадуурхах явдлууд

нэлээн байна. Энэ бол энэ төрийн өмчийн болон хувийн өмчийн төрийн өмчийн бус сургууль ерөөсөө ялгаагүй их байна.

Тэгээд дээрээс нь ер нь дээрэлхэлд хэр давтамжтай байдаг юм гэхээр бас л нэлээд олон хүүхэд энэ олон удаа энэ дээрэлхэлд өртсөн гэж хариулж байна. Тэгэхээр бид нар бол өнгөрсөн жилүүдэд миний бие Боловсролын сайд Энх-Амгалантай хамтран үе тэнгийн дээрэлхлийн эсрэг ажлын хэсэг байгуулан ажиллаж, тодорхой зөвлөмжүүд гаргаж байсан. Энэ ажлын үр дүн маань хэр яваад байгаа юм бэ? Яг дунд сургууль дээрээ. Үүнийг мөн мөн энэ боловсролын салбарынхнаас асуумаар байна.

Тэгээд 3 дахь нэг анхаарал татсан зүйл нь энэ хувийн өмчийн сургуулиудад сургалтын төлбөртэй холбоотойгоор хүүхдийн маань сурч боловсрох эрхийг зөрчсөн ийм кэйсүүд бас нэлээн байна. Тухайлбал энд хамрагдсан ээж, эцэг эхчүүдийн юунаас ингээд харахаар сургалтын төлбөрөө төлөөгүй эсвэл сургалтын төлбөртэй холбоотой мөн багшийн зааж байгаа арга зүйтэй холбоотой асуудлаар санал тавьсан нөгөө хүүхдийг ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүний цагийг нэмье.

Ц.Мөнхцэцэг: Энэ нөгөө тухайн хувийн өмчийн сургууль үндэслэлгүйгээр сургалтын төлбөр нэмсэн эсвэл нөгөө багш нарын боловсрол, ур чадвартай холбоотой гомдол, санал тавьсан эцэг эхчүүдийн хүүхдүүдийг үндэслэлгүйгээр сургуулиас хассан ийм гомдлууд Комисст ирдэг юм байна. Тэгэхээр энэ чиглэл дээр манай БШУЯ, Боловсролын ерөнхий газар ямар хяналт тавин ажиллаж байна.

Ер нь бол Зөрчлийн тухай хуулийн 6.20 дээр энэ аливаа төлбөр хураамжууд төлөөгүй үндэслэлээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хууль бусаар хязгаарлах

нь хүүхдийн эрхийн зөрчил гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл хуулийн хариуцлага байгаа. Тэгэхээр энэ чиглэлээр энэ манай боловсролын яам анхаарал тавих шаардлагатай байна.

Б.Баярсайхан: 4 номерын микрофон дээр ТНБД Батжаргал. Дараа нь Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир, ХЭҮК хариулах билүү, нэмж Сүнжид дарга хариулна.

Х.Батжаргал: Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя. Сурах бичгийн агуулгатай холбоотой ямар нэгэн өөрчлөлт, сайжруулалт ямар ажил хийгдэж байгаа вэ гэдэг талаар асуулаа. Ер нь энэ өнөөдөр хэлэлцэгдэж байгаа энэ хүний эрхийн боловсролын салбартай холбоотой энэ илтгэлийн тайлан, мэдээлэл боловсруулалтад оруулсан энэ мэдээлэл дата бол бас 2022 оны мэдээлэл дээр тулгуурласан гэж ойлгож байгаа.

Тэгэхээр Боловсролын багц хууль холбогдох шинэчлэл, түүний мөрөөр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд, ялангуяа шинэчилсэн хуулийн хэрэгжилтийг хангах төсвийн хамгийн эхний жил бол 2024 он. Тэгэхээр энэ хүрээнд бол бас холбогдох арга хэмжээнүүд бол үе шаттайгаар хэрэгжүүлж явж байгаа. Тэгэхээр яг боловсролын агуулгатай холбоотой бол Боловсролын багц хуулийн шинэчлэлд бол Улсын Их Хурлаас батлагдсан Боловсролын үндэсний зөвлөл Ерөнхий сайдаар ахлуулж, байгуулагдан боловсролын сургуулийн өмнөх болон ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг Үндэсний зөвлөлөөр саяхан хэлэлцэж, өнөөдрийн бас Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн баталлаа.

Тэгэхээр сургалтын хөтөлбөрийн агуулга бол энэ хүрээндээ холбогдох судалгааны дагуу холбогдох зөвлөмжийн дагуу ингээд өөрчлөлт, шинэчлэлтүүд үе шаттайгаар хийгдэнэ. Эхний ээлжид 24-25 оны хичээлийн шинэ жилд бол угтаж сургуулийн өмнөх болон ЕБС-ийн

сургалтын хөтөлбөрийн бага ангийн боловсролын хөтөлбөрийн өөрчлөлт шинэчилсэн энэ өөрчлөлтийг ингээд хэрэгжүүлээд ингээд ажиллана. Яг нарийвчилсан заалт болон холбогдох агуулгатай холбоотой мэдээллийг манай холбогдох газрын дарга Оюунаа дарга нэмж тодруулж хариулна.

Б.Баярсайхан: 5 номерын микрофон дээр ажлын хэсэг хариулъя.

П.Оюунаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Мөнхцэцэг гишүүний асуусан сурах бичиг дэх хүний эрхийн асуудалтай холбоотой хариултыг Батжаргал даргын хэлсэн дээр нэмж тодруулъя гэж бодож байна. ТНБД-ын хэлсэнчлэн бид нар үзэл баримтлалаа боловсруулсан. Боловсролын ерөнхий хуульд бол заавал судлах агуулгын нэгд хүний эрхийн асуудал орсон. Тэгэхээр үүнтэй холбогдуулаад сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийг бид нар энэ хичээлийн энэ жилээс эхлээд сургуулийн өмнөх болон бага боловсрол дээр эхэлж хийнэ. Ингээд СӨБ-оос эхлээд бид нар хүний эрхийн асуудлуудыг жижиг зан үйлээр дамжуулан хөгжүүлдэг тэр агуулгыг СӨБ-ын хөтөлбөрт суулгаж өгнө.

Үүнтэй уялдуулаад бид нар сурах бичгийнхээ ялангуяа бага ангийн сурах бичигтээ өөрчлөлтийг хийнэ. Шинэчилсэн хөтөлбөрийнхөө дагуу. Үүнтэй холбогдуулаад бид нар сурах бичгээ хийхдээ энэ дээр энэ хүний эрхийн 23 дугаар тайлан илтгэл дээр гарсан зөвлөмжүүдийг тусгаж ажиллана.

Үүнээс гадна 2023 оноос эхлээд БШУЯ дээр яг энэ 4 А-ын хүрээнд хүний эрхийн хүний эрхэд мэдрэмжтэй бодлого төлөвлөлт, агуулгыг хэрэгжүүлэх ажлуудыг эхлүүлээд байгаа. Бид нар Боловсролын ерөнхий хууль болон бусад дагалдах хуулиуд дээрээ энэ 4 А-ынхаа хүрээнд шинжилгээ хийж үзсэн. Энэ шинжилгээг бид нар зөвхөн хууль, эрх зүйн орчиндоо төдийгүй сурах бичиг,

сургалтын хэрэглэгдэхүүн, орчин дээрээ энэ хүрээний дагуу шинжилгээг тогтмол хийдэг ийм болж байгаа.

Тэгэхээр бид нар энэ ирэх хичээлийн жил гэхэд бид нар ЕБС-ийн бүх сурах бичгүүд дээр мөн шинэчлэн боловсруулах сурах бичгийнхээ хүрээнд хүний эрхийн мэдрэмжтэй байдлаар хэрхэн боловсруулагдсан байна вэ гэдэг шинжилгээг тогтмол хийж, холбогдох байгууллагуудад тайлагнадаг байхаар ийм шинэ зохицуулалтыг бодлого, төлөвлөлт, хэрэгжилт дээрээ оруулж ирж байгаа.

Б.Баярсайхан: Мөнхцэцэг гишүүн тодруулъя. Тодруулж асууя.

Ц.Мөнхцэцэг: ЕБС-ийн сурах бичгийн агуулгыг концепцын хувьд баталсан нь их сайшаалтай байна. Тэр агуулгын талаар энэ манай Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хороондоо бас танилцуулах шаардлагатай байх.

2 дугаарт нь, энэ яг сурах бичиг бичдэг эрдэмтдийн баг, эрдэмтдийн бүрэлдэхүүнийг хэрхэн сонгож байгаа юм бэ? Ер нь манай би дээд сургуулийн багш байсан хүний хувьд бас яг тухайн үед багш нар яаж боловсролын сурах бичгийн агуулгад оролцдог талаар бас тодорхой мэдээлэлтэй байгаа. Тэгэхээр яг энэ багшийг сонгохдоо зөвхөн их, дээд сургуулийн багш нар төдийгүй, иргэний нийгмийн байгууллага, хүний эрхийн чиглэлээр мөн тухайн салбарын чиглэлээр мэргэшсэн бусад ТББ, тэгээд хувийн хэвчлээс сонгон авсан маш сайн баг байх ёстой байхгүй юу. Энэ тал дээр л анхаармаар байгаа юм. Жилийн жилд нэг ном сурах бичиг бичих хэдхэн хүн байдаг. Хэвлэдэг хэдхэн компанитай. Өөрөөр хэлбэл маш явцуу хүрээнд хэдхэн хүмүүсийн хүрээнд энэ сурах бичгийн агуулга маань явж ирсэн. Үүнийг өөрчлөх л хамгийн чухал байгаа. Энэ тал дээр ямар ажил хийж байгаа юм бэ?

Б.Баярсайхан: Ажлын хэсэг хэн хариулах билээ? Оюунаа дарга хариулъя. 5 номерын микрофон өгье.

П.Оюунаа: Гишүүн ээ, таны хэлдэг асуудал бол яалт ч үгүй үнэн асуудал. Энэ маш олон жил ингэж явж ирсэн. Энэ асуудлыгаа бид нар халах чиглэлээр өнгөрсөн жилээс эхлээд Кембриджийн их сургуулийн сурах бичиг боловсруулдаг зөвлөх үйлчилгээг аваад, 2023 оны 01 сараас эхлээд бид нар сурах бичиг зохиох хөтөлбөр бичих хүмүүстээ үе шаттайгаар сургалтад хамруулсан байгаа. Тэгэхээр энэ сургалтад хамруулах үйл ажиллагааны хүрээнд хүний эрхэд мэдрэмжтэй, жендерийн мэдрэмжтэй мөн соёлын мэдрэмжтэй ийм сурах бичиг, сургалтын хөтөлбөрийг яаж боловсруулах вэ гэдэг чиглэлээр сурах бичиг зохиох үндсэн багийн хүмүүстэй сургалтуудыг зохион байгуулсан.

Тэгэхээр энэ сургалтуудыг зохион байгуулахдаа бид нар зөвхөн сурах бичиг бичдэг хуучны баг биш, сурах бичиг зохиодог компаниуд, хэвлэлийн компаниуд, их, дээд сургуулийн багш нар, ЕБС-ийн багш нар, манай мэргэжлийн байгууллагууд, мөн иргэний нийгмийн байгууллагын хүмүүсийг бүгдийг нь оролцуул ... /минут дуусав/

Б.Баярсайхан: Ажлын хэсгийн микрофонд цаг сунгая даа. Дахиад 1 минут өгье.

П.Оюунаа: Ингээд нэлээн олон өргөн бүрэлдэхүүнтэй яг таны хэлсэнчлэн энэ баг бид нар үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан байгаа. Ингээд шинээр хийгдэх сурах бичгүүддээ ялангуяа сурах бичиг дээр хийх хүний эрхийн шинжилгээнүүд дээрээ бид нар дэвшил гаргана гэсэн ийм хүлээлттэй байгаа. Үүнээс гадна бид нар сонгон шалгаруулалт дээрээ бас жоохон өөрчлөлт оруулж байгаа. Энэ дээрээ хуучин хийдэг гэдэг хүмүүсээсээ илүүтэй бид нар нэлээн өргөн хүрээний багийг оролцуулна. Тэгээд сурах бичгээ дахиад

бид нар туршаад тохирцыг нь хангаад нутагшуулсны дараа үндэсний хэмжээнд хэрэгжүүлдэг ийм шинэ механизмыг оруулж ирж байгаа.

Б.Баярсайхан: Баярлалаа. Надад нэг 2 асуулт байна.

Би нөгөө ажил хийвэл дуустал, давс хийвэл уустал. Нөгөө боловсролын салбар дахь хамгийн их хүүхдийн эрх зөрчигдөж байгаа хүний бие засах эрх зөрчигдөж байгаа, Монголын хүүхдүүд бие засахдаа даарч, айж, ичиж явж байгаа энэ зөрчлийг л арилгах гэж ингээд өнгөрсөн 3, 4 жил бид нар үнэхээрэнэ модон жорлонг халах талаар ажиллалаа.

Ажлын хэсгийг ахлаад ажиллаж байгаа хүний хувьд энэ улс даяар хийгдэж байгаа модон жорлонгийн асуудал чанаргүй байна гэдгийг Ням-Очир дарга аа, би танд олон удаа хэлж байгаа. Та хөдөөгүүр явахгүй байгаа. Бид хөдөөгүүр яваад нүдээрээ хараад энэ сумын сургуулийн захирлууд, багш нар, сумын удирдлагуудтай уулзаад газар дээр нь өнөөдөр ингээд ажиллаад явж байгаа хүмүүсийн хувьд яг өөрсдийнхөө энэ нүдээрээ энэ бичлэгээрээ бүх талаар баримтжуулаад таны ахалж ажиллаж байгаа энэ ажил чанаргүй байна. Хүүхдийн эрх зөрчигдсөөр байна. Хүүхдүүд тав тухтай газар бие засаж чадахгүй байна. Энэ Эрдэнэт үйлдвэрээс гарсан 160 тэрбум төгрөгийн хэд нь зарцуулагдчихав. Хаана явна вэ. Та энэ ажилдаа ер нь хариуцлага хүлээх юм уу. Энэ ажлаа чанаржуулах юм уу? Хөдөөгийн хүүхдүүдийн энэ зөвхөн бие засах бие засах эрхийг хангаж өгч чадах юм уу? Та гэдэг энэ асуултыг л би танаас асуумаар байна л даа.

Тэгээд эмзэглээд ингээд хувь хүний асуудал шиг яриад байх шиг байна. Энэ ерөөсөө та бид 2-ын хувь хүний асуудал биш. Энэ бол та бүхэл бүтэн энэ том тендерийг зарлаад, итгэмжтэй компаниудыг сонгон шалгаруулаад, энэ ажлыг улсын хэмжээнд чанартай хийнэ

ээ л гэж үзсэн бол та энэ ажлынхаа цаана энэ хүүхдүүдийг хайрлаад гарчихмаар байна. Тэгэхгүй өнөөдөр улсын хэмжээнд 1 ширхэг 100 хувийн яг чанартай, болчихсон байна гэдэг ийм 0 алга байна. Тэгээд танай гэрийн 0 ямар байдаг юм, танай хүүхдүүд ямар душинд усанд ордог юм. Тэгвэл хөдөөгийн хүүхдүүдэд энэ нөхцөл байдал чинь хангагдахгүй байна. Тэгээд энэ асуудлыг яах юм бэ? Энэ дээр та нэг сайхан тодорхой хариулт өгөөч.

3 номерын микрофоныг өгье дөө.

Т.Ням-Очир: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 24 оны үйл ажиллагааны хөтөлбөрт жилд 100-аас доошгүй нүхэн жорлонг орчин үеийн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжаар солино гэсэн ийм зорилт орсон. Энэ хүрээнд энэ үйл ажиллагааг 4 үе шатад хувааж хэрэгжүүлэхээр Эрдэнэт УУГ-аас санхүүжилтийг нь гаргаж хэрэгжүүлж байгаа. 1, 2 дугаар ээлжид түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр худалдан авах ажиллагаанууд зарлагдсан. 3, 4 дүгээр ээлжид зураг төсөв бэлэн болсны дагуу худалдан авах ажиллагаанууд зарлагдаад явж байгаа. Яг өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 261 объект буюу 261 цэцэрлэг, ЕБС, дотуур байрны нүхэн жорлонг байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллаад хүлээгээд авчихсан байгаа. Ашиглалтад орсон 261 объектын ашиглалт ямар байна, хэр чанартай байна гэдэг дээр ерөнхийдөө та болон манай Боловсролын ерөнхий газар, БШУЯ-наас тодорхой ажлын хэсгүүд ашиглалттай нь танилцаж байгаа. 215 объект нь ямар нэг байдлаар хэвийн ажиллаж байна гэдэг ийм урьдчилсан судалгаа тооцооллын хийгээд байгаа. Тодорхой объектууд дээр жишээлбэл өнгөрсөн өвөл 35 объект дээр хөлджээ. Өвлийн яг эд хүйтрэлийн үеэр хөлджээ. Ингээд ашиглалт нь зогсжээ. 2 объект эколог буюу тоног төхөөрөмж

нь шатжээ гээд. Ингээд яг нарийвчилсан судалгаануудыг гаргаж байгаа.

Энэ дээр яг ашиглагч байгууллагын ашиглалтаас болсон байна уу, гүйцэтгэж өгсөн байгууллага чанаргүй гүйцэтгэсэн байна уу? Энэ дээр нэг бүрчлэн гүйцэтгэсэн компаниуд, ашиглагч байгууллагуудтай хэлэлцүүлэг, хурлуудаа зохион байгуулаад гүйцэтгэгчээс болсон бол гүйцэтгэгчээр үүнийг нь нөхүүлэх, шаардлагатай нэмэлт засвар үйлчилгээнүүдийг хийлгэх ийм албан шаардлагуудыг бол өгөөд явж байгаа. Ашиглагч байгууллагаас шалтгаалсан байгаа бол ашиглалтыг сайжруулах чиглэлээр сургалт, мэдээлэл зөвлөмжүүд өгөх. Цаашаа энэ алдааг давтахгүй байх ийм асуудлууд гарч байгаа, хийж байгаа.

Ер нь бол 300 гаруй яг энэ 260 объектын цаана 1980 угаалтуур, 1750 суултуур, 250 гаруй душ буюу холигч ингээж ашиглагдаж байгаа. Эндээс боляг энэ ашиглалтын явцад бол 300 гаруй суултуур, угаалтуур хагарсан байна. Хаалга үүд гажсан байна гэдэг ийм нарийвчилсан тооцоо судалгаануудыг гаргаж байгаа. Энэ дээр ч гэсэн хэрвээ гүйцэтгэгч байгууллага чанар муутай угаалтуур, суултуур хийгээд энэ нь ашиглалт даахгүй байгаа бол бид нар үүнийг солиулж байгаа. Мөн энэ тухайн стандарт зөрчсөн, зургаасаа зөрсөн ийм зүйлүүд гарсан байх юм бол энэ дээр бол засвар үйлчилгээ хийгээд явж байгаа. Энэтэйгээ холбоотой мөн орон нутгийн удирдлагуудад мэдээж зөвхөн сургууль, цэцэрлэг биш тухайн сум, орон нутгийн бусадэнэ ариун цэврийн байгууламж, нэгдсэн халаалт эд нартай холбоотойгоор орон нутгийн удирдлагууд, ашиглалтын ялангуяа гүйцэтгэгч компани гүйцэтгээд ашиглалтаа хариуцаад явах, засвар гэмтлээ хариуцаад явах энэ 3 жилийн хугацаанд энэ ариун цэврийн байгууламжийг байнгын ашиглалттай байж, хүмүүсээ чадавхжуулж, энэ үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх

чиглэлээр бас бид нар аймаг, орон нутгийн удирдлагуудтай нэлээн ингээж тулж ажиллаж байж жигдрэх юм байна гэдэг ийм бас дүгнэлтийг хийгээд байгаа.

Ингээд ажлын хэсгээс ирсэн мэдээллүүдийг нэгтгээд ингээд явахаар ер нь бол 24 ондоо багтаад энэ бүх ажлуудыг нэг жигдрүүлэх, цаашидаа 25, 6 онд гүйцэтгэгч компанийн энэ хяналтаа тавиад сайжруулах энэ хугацаанд бол энэ асуудлуудыг бол нэг мөр шийдээд явна гэсэн ийм байдалтай ажиллаж байна.

Б.Баярсайхан: Хоёулаа 2 жил ажлын хэсгээрээ энэ асуудлыг та л яг ингээж хариулаад л, би ингээж асуугаад л ингээд дуусаж байгаа юм. Би таныг өөрийнхөө биеэр энэ аймгуудаар яваад, энэ ямар нолийн асуудлыг та захиалаад байгаа юм. Ямар компаниудыг шалгаруулаад байгаа юм. Тэд нар ямар юм хийгээд байгаа юм гэдгийг л та өөрийнхөө нүдээр очоод нэг үзээч ээ гэж би танд олон удаа хэлж байгаа.

Тийм учраас таны гадаад дотоод надад явах ерөөсөө хамаагүй. Хөдөө орон нутагт хийж байгаа энэ том бүтээн байгуулалтаа шалгахгүй байж байж ингээд ерөөсөө олдохгүй ингээд яваад байна л гэдгийг би танд хэлсэн юм. Нэг 7 хоног 1 улс руу, дараагийн 7 хоног дараагийн улс руу. Өнөөдөр Монгол Улсад хамгийн их тулгамдаад байгаа асуудал хөдөө орон нутгийн хүүхдүүдийн энэ эрүүл аюулгүй орчинд амьдрах асуудал байгаа. Тэгээд энэ асуудлыг зүгээр л цаасан дээрээс Та ингээд гоё статистик ярьдаг. 216 газар хэвийн ажиллаж байгаа газар 1 ч байхгүй. Таны томилсон Монгол Улсын зөвлөх инженер, танай ерөнхий газрын инженер 2 энэ нолийн асуудлын чанарыг 0-10-д алинд нь үнэлэх вэ гэхээр 10-д үнэлэх ажил байхгүй. 9, 8-д үнэлэгдэхгүй байна гэдгийг өөрсдөө хүлээн зөвшөөрчихсөн шүү дээ.

Тэгээд бид нар зүгээр энэ хайран сайхан Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагад хийгдэж байгаа 1 удаа бид нарт Монгол Улсын хэмжээнд бараг 100 жилд анх удаа олдсон энэ хөрөнгөөр яг та таны гэрийн ноль ямар байдаг юм, жорлон чинь ямар байдаг юм, таны гэрийн халуун ус ямар байдаг юм, энэ бид ямар халуун ус, нолийн ариун цэврийн байгууламж хэрэглэдэг юм, тэрийг л хөдөө авчиръя гэсэн байхгүй юу. Тэгэхээс биш сарамнай, чанаргүй материалаар хийчихсэн, стандартын биш, зураг байхгүй, ямар ч стандарт байхгүй ийм зүгээр нэг ноль төдий нэртэй юм хийчих гэж энэ хөрөнгө мөнгө урсаагүй. Би таны ажил чанаргүй байгааг л хэлээд байна. Тэгэхээс шомбойлгоод шомбойлгоод нэг юм тавьчихсан. Нэг наалантай ноль үзүүлээд байгаа энэ асуудлыг би яриагүй байна шүү дээ.

Тэгээд би таны хажууд бараг 5, 6 аймгаар ингээд явчихлаа. Бүх сумдаар нь яваад нөхцөл байдалтай нь танилчихлаа. Энэ хамгийн шилдэг нь болжээ, 100 хувь болжээ гэдэг ийм ноль байхгүй байна шүү дээ. Тэгээд та ямар хариуцлага хүлээх юм бэ? Та нэг энэ хөдөө орон нутгаараа нэг яваад өгөөч ээ. Энэ ажилтайгаа нэг танилцаад өгөөч. Битгий худлаа цаасан дээр тоо яриад суугаад байгааг.

Тэгээд та 3 ТНБД-ын ахалж байсан энэ ажлыг та аваад явсан. 1, 2 дугаар ээлжийг та ярих, алдааг засах танд эрх байхгүй. Үүнээс чинь хойш 2 жил өнгөрчхөөд байна. Та ажлаа хийгээч. Таны өмнө нь Боловсролын яамны ТНБД-аар ажиллаж байхдаа хууль бус асуудал хийж байсан, хулгайн тендер явуулж байсан асуудлын чинь ул мөр өнөөдөр ч гэсэн боловсролын салбарт оюутнуудын эрхийг зөрчөөд, энэ боловсролын салбарт хүний эрхийг зөрчөөд ингээд байж л байгаа шүү дээ. Дутуу барьсан тэр балгас болчихсон, Төсвийн хууль өөрчлөөд засчихсан энэ эрүүгийн шинж чанартай ийм гэмт

хэрэг хийчихсэн хүн шүү дээ, та. Ийм хэрэг хийсэн шүү дээ, та.

Одоо тэр АУИС-ийн гадаа байгаа тэр дутуу каркас босчихсон асуудлыг яах юм. Харин тийм, тийм учраас би таньг энэ асуудлыг харин шалгаж өгөөч ээ гээд. Ингээд АТГ нь манай энэ яаманд чинь ажиллаж байсан хүмүүс ингээд өгдөг, шалгагддаггүй, үүнийг ийм учраас би үүнийг чуулган дээр ярьдаг байхгүй юу. Тэгээд харамсалтай нь ийм итгэмжгүй хүнд ийм том хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг ингээд хариуцуулаад явж байгаад л бухимдаад байгаа юм л даа. Үнэхээр та тэр 216 сургууль, цэцэрлэг, дотуур байр хаана тэр чанартай, ямар аймгийн, ямар сумын ямар ноль өнөөдөр 100 чанартай байгаа юм. Та тэгвэл яг хэлээд өг л дөө. Тийм газар байхгүй байгаад байна шүү дээ.

Энэ сонгууль болох гээд худлаа яриад ингээд сууж чадахгүй. Үнэндээ энэ хөдөө, орон нутгийн хүүхдүүдийн эрх зөрчигдөж байгаа. Би өнөөдөр энэ хүний эрхийн 23 дахь илтгэлтэй холбоотой, Сүнжид даргын мэдээлэлтэй холбоотой маш олон зүйлийг яримаар байна. Хүүхдийн хоолны шим тэжээлийн асуудал, дотуур байр, цэцэрлэгийн хоолны мөнгө хүрэхгүй байгаа асуудал, энэ цахим хичээл хийж байгаа гээд та цахимаар ингээд хичээл зарлачхаад байдаг тийм ээ. Гэтэл энэ цахим орчинд хичээл хийх тэр багш нарын арга зүй, тэр интернэтийн орчин хөдөө орон нутагт байхгүй талаар, ингээд олон зүйлүүдийг яримаар байна. Тэгэхдээ цаг бага байгаа учраас би тантай энэ модон жорлонгийн асуудлыг ярьж байгаа юм.

Би хэлж байгаа бүх үгэндээ хариуцлага хүлээнэ. Ням-Очир дарга аа. Өнөөдөр харамсалтай байна. Би үүнийг Засгийн газарт ч гэсэн Байнгын хорооны даргын хувиар энэ ажлын хэсгийн даргын хувиар би албан бичгээ өгсөн байгаа. Улс даяар хийгдэж байгаа энэ сургууль, цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг

халах энэ бүтээн байгуулалтын ажилд шалгалт оруулж өгөөч ээ гэдгийг Засгийн газарт тавьсан байгаа. Удахгүй энэ талаар бас УИХ дээр сонсгол явуулна. Та тэр үед надад үгээ хэлээрэй. Түүнээс өмнө та ажлын хэсгээ ахлаад хөдөө, орон нутагт ажиллаад өгөөч ээ гэж танаас хүсэж байна.

Ингээд өнөөдөр хүний эрхийн талаар, боловсролын салбар дахь хүүхдийн эрхийн талаар, боловсролын салбар дахь хүний эрхийн талаар сонсголыг сонслоо.

Тэгээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан үүгээр дуусаж байгааг мэдэгдье.

ХЗБХ-нд Хүний эрхийн дэд хорооны дарга Мөнхцэцэг гишүүн та энэ санал, дүгнэлтийг хүргүүлье. Танаар хүргүүлье.

Ингээд хуралдаан дууслаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ